

DDC
363.2
Б-342

Албан хэрэгцээнд зориулав

ЦАГДАА СУДЛАЛ

*Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл*

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Л.Гэрэлмаа

Хэвлэлийн хуудас

Цаасны хэмжээ: В.5

Хэвлэсэн газар: Номын цацал ХХК

Дугаарыг эрхлэн гаргасан: Докторант Б.Баянмөнх

ISBN 978-99962-8882-2-7

2020 №1 (25)

“ЦАГДАА СУДЛАЛ” ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

P
O
L
I
C
E

S
C
I
E
N
C
E

T
H
E
O
R
E
T
I
C
A
L

A
N
D

M
E
T
H
O
D
O
L
O
G
I
C
A
L

J
O
U
R
N
A
L

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

Ж.Долгорсүрэн Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Б.Пүрэв Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор

Ж.Заанхүү Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор

Г.Гантөмөр Хууль зүйн доктор, (Ph.D), профессор

З.Төрмандах Хууль зүйн доктор (Ph.D)

Т.Оюунчимэг Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Ж.Мөнхболд Хууль зүйн ухааны (Ph.D) дэд профессор

Сэтгүүлийн эрхлэгч: ДХИС-ийн тэргүүн дэд захирал Б.Бат-Эрдэнэ
Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Эрхлэн гаргасан, нарийн бичгийн дарга: Докторант Б.Баянмөнх

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

Т.Бямбаа Хууль зүйн доктор (Ph.D)

О.Цэцэгмаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Д.Энхжаргал Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)

Д.Мягмарцэрэн Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Ш.Ариунбилэг Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Манай хаяг: Дотоод хэргийн их сургууль Баян зүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, хилчиний гудамж-1, утас 70155011, 99878219, мейл хаяг: bayanmunkh@uia.gov.mn

ЦАГДАА СУДЛАЛ
Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл
(дугаар 2020 №1)

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Я.Цэлмэн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээрх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт.....	4
А.Амарсайхан, Э.Энхбадрал Өсвөр насны хүнд оногдуулж буй эрүүгийн хариуцлагын онцлог, анхаарах асуудал.....	13

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Д.Эрдэнэбаатар Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйлд хийсэн тайлбар.....	21
Б.Баянмөнх Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг.....	37
Б.Цогтбаатар Цагдаагийн алба хаагчаас явуулах тодорхой ажиллагааны эрх зүйн зохицуулалт ба анхаарах зарим асуудал.....	53
Д.Бямбахүү Нийслэлийн зарим хороонд гарч буй зөрчил, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, түүнийг багасгах зарим арга зам.....	64
Э.Дашгаадан Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын алба хаагчдыг бэлтгэхэд анхаарах зарим асуудал	74

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Эрдэнэбат Эрүүгийн процессын зарчим.....	79
З.Эрдэм, П.Орхон Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд шинжлэх ухаан, техник технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх асуудал.....	86

УДИРДАХУЙН УХААНЫ ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Эрдэнэбат Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэх захиргааны удирдлага.....	92
---	----

ЦАГДААГИЙН ТАКТИК ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

З.Цэрэнбатаа Терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагааны сургалт, бэлтгэлжилтийн зарим асуудал.....	99
---	----

СЭТГЭЛ СУДЛАЛЫН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Д.Цэрэнлхам Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх сэтгэл заслын үйлчилгээнд анхаарах зарим асуудал.....	108
---	-----

ГАДААД ХЭЛ ДЭЭРХИ ӨГҮҮЛЭЛ

R.Bayarmagnai, Y.Battulga Ead of the state auto inspection the main subject of making road safety.....	114
---	-----

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭРХ
МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн
ахлах багш, цагдаагийн хошууч Я.Цэлмэн,

Товчлол: Энэхүү өгүүлэлд хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэх чиглэлээрх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, БНХАУ болон Монгол Улсын хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтын талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг: Хүн худалдаалах, хамтын ажиллагаа, хуулийн шинэчлэл, олон улс

Үндсэн хэсэг. Монгол Улсын Засгийн газраас хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, илрүүлэлтийг нэмэгдүүлэх, эрүүгийн хэргийг бодитоор хянан шийдвэрлэх нөхцлийг нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэлийг хийж байгаа. Энэхүү шинэчлэлийн хүрээнд 2012 онд “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хууль, 2014 онд “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”, 2017 онд “Шинэчилсэн эрүүгийн хууль”, “Шинэчилсэн эрүүгийн процессын хууль”-иудыг Монгол Улсын Их Хурлаас батлан, 2017 онд “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн Газраас баталж нийтээр дагаж мөрдөж байна.

2017 оноос Азийн сан, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Дотоод хэргийн их сургуультай хамтран “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхжуулах нь” төслийг хэрэгжүүлж эхэлсэн ба төсөл нь доорх хоёр зорилтыг тавьсан байна. Үүнд:

1. Хохирогч төвтэй стратеги хэрэгжүүлэх, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, прокурор, шүүгчдийн хамтын ажиллагааг сайжруулах
2. Хил хамгаалах ерөнхий газар, гадаадын иргэн, харъяатын газрын алба хаагч нарын хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулах юм¹.

Үндсэн хэсэг. Хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг бөгөөд сүүлийн жилүүдэд уг гэмт хэргийг хар тамхи, мансууруулах бодис худалдах, тээвэрлэх зэрэг гэмт хэрэгтэй хавсран үйлдэж ихээхэн хэмжээний ашиг орлого олдог хууль бус бизнес болон өргөжиж байгаа нь дэлхий нийтийн анхаарлыг татсан асуудал болоод байна.

¹ Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, алба хаагчдын чадавхыг үнэлэх судалгааны тайлан. УБ.,2018 он

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нь ихэвчлэн буурай хөгжилтэй болон хөгжиж байгаа орнуудын орлого багатай, боловсролын түвшин доогуур, эмзэг бүлгийн хүүхэд, эмэгтэйчүүд байдаг бөгөөд тухайн орны эдийн засгийн хөгжил доогуур, иргэдийн эрх зүйн мэдлэг муу байгаа зэрэг нь энэхүү гэмт хэргийн хохирогч болох гол хүчин зүйл болж байна. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албанаас гаргасан тайланд дурдсанаар хүн худалдаалах гэмт хэргийн улмаас 137 орны 2,4 сая иргэн (хохирогч) хохирсон байдаг бөгөөд хохирогчдын 75 хувийг охид, эмэгтэйчүүд эзэлж байна. Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг тархацаар нь авч үзвэл 1000 хүн тутмын 1,8 нь ямар нэг байдлаар энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох, харин Ази Номхон далайн бүс нутагт 1000 хүн тутмын 3 нь хохирогч болох эрсдэлтэй байгаа гэсэн үзүүлэлт гарсан байна.

Монгол Улс 2002 онд баталсан Эрүүгийн хуульд анх удаа хүн хулгайлах, хүн худалдах, худалдан авах, хүний цус, эд эрхтэнг хууль бусаар авах гэмт хэргийг хуульчилсан нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдэх эхлэл тавигдсан. Засгийн газраас 2005 онд “Хүн, ялангуяа эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлсэн.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох, энэ чиглэлээр ажилладаг төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зөв ойлголт, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зэрэг олон талт үйл ажиллагаанууд хийгдсэн байна. Улмаар 2008 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд нэгдэн орсон².

Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэх чиглэлээрх

Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улс хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын зэрэглэлээр 2018 оны байдлаар 2-р шатлалын буюу “Анхаарал татсан орон”-ы жагсаалтад орсон байна.

Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн улс болохын хувьд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар олон улс болон үндэстний хэмжээнд хүний эрх, эрх чөлөөг хангах хамгаалах чиглэлээр улс орнуудтай хамтын ажиллагааг улам бүр идэвхижүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал³-ын 1 дүгээр зүйл “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш эрхтэй байна...”, 3 дугаар зүйл

² Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр. МУ-ын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт. УБ хот.

³ Хүний эрхийн түгээмэл тунхаглал. НҮБ-ын Ерөнхий ассамблейн 217 /А/III/ тогтоолоор 1946 оны оны 12 дугаар сарын 10-ны өдөр батласан. МУ-ын олон улсын гэрээ

“Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан эрхтэй” 4 дүгээр зүйл “Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно” гэж тус тус тунхагласан билээ.

Мөн иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын хэлэлцээрийн⁴ 8 дугаар зүйлд “хэнийг ч бусдын эрхшээлд байлгах болон боол болгох, түүнчлэн албадан хөдөлмөрлүүлж буюу заавал ажилд тулгаж болохгүй” агуулга тусгалаа олсон. Энэ утгаараа Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/263 дугаар тогтоолоор “Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол”⁵-ыг баталж, 2002 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилжээ.

Хүн худалдаалах гэмт хэрэг хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахууль өгөх зэрэг аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулан хүлээн авсан хууль бус үйлдлээр илэрдэг.

Манай улсад хүн худалдаалах гэмт хэрэг нь хөдөлмөрийн мөлжлөг, бэлгийн мөлжлөг, хүний эд эрхтний наймаа, гэр бүл болоход зуучлах, хүүхэд хууль бусаар үрчлэх зэрэг арга, хэлбэрээр үйлдэгдэж байгаа бөгөөд Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгээс хүн худалдаалах гэмт хэргийн талаар хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд тус гэмт хэрэгт бэлгийн мөлжлөгийн хэлбэр зонхилж байна. Тухайлбал, олон нийтийн газраас үйлчлүүлэгч олох, саун, массажны газарт массажист нэрээр халхавчлах болон цэнгээний газар ширээнд үйлчлэн орлого оруулах хэлбэрээр биеэ үнэлэх, үнэлүүлэх ажлыг зохион байгуулах, цахим орчинд зар байршуулан дуудлагаар секс үйлчилгээ үзүүлэх замаар хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэх явдал түгээмэл болсон байна. Мөн гадаадад өндөр цалинтай ажилд зуучлах, сургуульд тэтгэлэгтэй суралцуулах, гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах зэргээр зар гаргаж, охид, эмэгтэйчүүдийг хуурч мэхлэн гадаад улсад гарган биеийг үнэлүүлж, хилийн чанадад гэмт хэргийн хохирогч болгосон тохиолдлууд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх хуулийн байгууллагын 2010-2016 оны статистик мэдээллээс үзэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 дугаар зүйлд

⁴ Монгол Улсын Олон улсын гэрээ.

⁵ Монгол Улсын Олон улсын гэрээ.

заасан Хүн худалдаалах (113 дугаар зүйл) 54 гэмт хэрэг, Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах (124 дүгээр зүйл) 122 гэмт хэрэг тус тус цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдсанаас хүн худалдаалах 8 гэмт хэрэгт 15 хүн, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах 36 гэмт хэрэгт 54 хүн шүүхээс ял шийтгүүлсэн байна. Хүн худалдаалах гэмт хэрэг нь нууц, далд аргаар үйлдэгддэг, хохирогчийг хамгаалах тогтолцоо сул байгаагаас гэмт хэргийн хохирогч нь уг гэмт хэргийн талаар мэдээлдэггүй зэргээс шалтгаалан хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэргийн тоо цөөн, гэмт хэргийн статистик тоо бодит бус байна.

2017-2018 оны байдлаар Шинэ Эрүүгийн хуультай бүрэн танилцаж амжаагүй гэх шалтгаанаар прокурорууд ял шийтгэл оногдуулах оновчтой арга замыг эрэлхийлж, хэрэг тус бүр дээр хянамгай ажиллахын оронд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг батлах явцад шалгагдаж байсан хүний наймааны 26 хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл буурахгүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангах байгууллагуудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхой бус, албан хаагчид нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар нэгдмэл ойлголтгүй, байгууллага хоорондын хамтын ажиллагаа байхгүй, гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн байдал дутмаг байгаатай холбоотой байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттайгаар үндэстэн дамнан үйлдэгддэг тул энэ төрлийн гэмт хэргээс урьчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлан тогтоосны үндсэн дээр уг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, арга хэлбэрийг шинэчлэх шаардлагатай байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд тайлагнасанчлан Монгол улс нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэх, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах сурвалж болон хүлээн авагч улс болж байна. Монголын эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэхээр Турк, Казакстан, Норвеги, Швед улсуудад, харин бэлгийн мөлжлөгт ашиглахаар Өмнөд Солонгос, Япон, Хятад, Хонконг, Макао, Малайз, Герман, Швед, Бельги, Турк, АНУ улсууд руу худалддаг байна. Монгол улсад бол охид, эмэгтэйчүүд массажны газар, зочид буудал, баар цэнгээний газар болон караоке клубүүдэд бэлгийн мөлжлөгийн зорилго бүхий хүний наймаанд өртөж байна. Эцэг эхийнх нь гарын үсэг зурж байгуулсан гэрээний дагуу ажиллаж буй уран нугараач Монгол охидыг гол төлөв Монгол, Туркт, мөн цөөн тоогоор Хонконг, Сингапурт албадан хөдөлмөр эрхлүүлж байна.

Монгол эмэгтэйчүүдийг Хятад, Өмнөд Солонгосын эрчүүдтэй арилжааны зорилготой зуучлалаар гэр бүл болгосны дараа гэртээ зарцлах, эсвэл хүчээр биеийг нь үнэлүүлж байгаа ч Өмнөд Солонгост энэ байдал буурч байна. Хүний наймаачид зарим үед хар тамхи, олон нийтийн хуурамч сүлжээ, ажлын байрны цахим зар, англи хэлний хөтөлбөрүүд зэргийг ашиглан хохирогчдыг хууран мэхлэх замаар бэлгийн

мөлжлөгт татан оруулдаг ажээ. Хөдөө орон нутгийн болон эдийн засгийн хувьд ядуу хорооллын хохирогчдын ихэнх нь Улаанбаатар хотод болон хилийн ойр орчим бэлгийн мөлжлөгт өртөж байна. Түүнчлэн өмнөх жилүүдэд Япон болон Өмнөд Солонгос Улсын жуулчид хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох сонирхлоор Монголд ирдэг талаар мэдээлж байсан⁶.

Дээрх үйл явдлуудтай холбоотойгоор хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн бодлогыг манай улсаас ихээхэн анхаарах шаардлагатай байгаа бөгөөд хамтын ажиллагаа зайлшгүй болсныг илтгэнэ.

Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд ХХГХ-тэй тэмцэхэд чиглэсэн тусгай бүлгийг байгуулах, хүнийн нөөцийг сонгон суралцуулах, мэргэшлүүлэх, чадавхижуулах зэрэг асуудал бидний өмнө тулгамдаж байна.

Монгол Улсын хувьд тогтолцооны шилжилт хийх, эдийн засаг, нийгмийн байгууллыг интеграцчлах гээд нэлээд асуудал байгаагийн зэрэгцээ нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр ч мөн анхаарал татсан асуудал үүсэн бий болсоор байна. Уг анхаарал татсан асуудлуудын нэг нь ХХГХ-ийн нийгэмд учруулж буй аюул заналхийлэл юм.

Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд хүн худалдаалах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмэ бэлдмэлийн хууль бус эргэлт, мөнгө угаах зэрэг улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд шинээр батлагдсан хуулиудын тодорхой хугацааны хэрэгжилтийн явцад уялдаа холбоог хангах, коллиз, хийдэл, алдааг холбогдох судалгааг үндэслэн Хууль тогтоомжийн хуулийн⁷ дагуу боловсронгуй болгох шаардлага бий болсон байдаг.

МУ-ын Эрүүгийн хуульд /ЭХ/ Палермогийн протоколын ХХГХ-ийн эрүүгийн эрх зүйн шинжүүд дараах байдлаар хуульчлагдсан. Үүнд:

1. 2002 оны ЭХ-д 113 дугаар зүйлд тусгагдаж МУ-ын Дээд Шүүх /ДШ/ 2008 оны 3 дугаар сард 12 дугаар тогтоол гарган “ЭХ-ийн 113 дугаар зүйлийг тайлбарлах тухай” албан ёсны тайлбар гаргаснаас гадна Улсын Их Хурлаас /УИХ/ 2008 онд ЭХ-ийн 113 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулсан нь Палермогийн протоколд нийцүүлэх чухал алхмууд байсан.
2. ХХГХ-ийг 2005 оны ЭХ-д Арван гуравдугаар бүлэг /хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг/-т системчилж Палермогийн протоколын 3 дугаар зүйлд заасан агуулгаар 13.1 дүгээр зүйлд гэмт хэрэгт тооцохоор хуульчилж 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж байна.
3. Палермогийн протоколын 3 дугаар зүйлд заасан тайлбарууд буюу хүүхдийг худалдаалах гэмт хэргийн хохирогчоор тогтоох болон хохирогч зөвшөөрсөн эсэх нь ХХГХ-ийн зүйлчлэлд үл нөлөөлөх агуулгууд нь ЭХ-ийн 13.1 дүгээр зүйлийн тайлбарт бүрэн утгаар тусгагдсан байна.

⁶ МУ дахь АНУ-ын ЭСЯ. Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан. УБ., 2018.

⁷ Төрийн мэдээлэл 2015 он №25. Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах,... оршино.” гэж заасан.

ЭХ-ийн 12.3 дугаар зүйлд “Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж: эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол бэлгийн мөлжлөг гэмт хэрэгт тооцох”-оор хуульчилсан.

Энэ нь ХХГХ-ийг зорчих эрхээр нь хязгаарлахгүй шинжээр ялгагдаж байгаа боловч Палермогийн протоколын 3 дугаар зүйлийн хохирогч бэлгийн мөлжлөгт өртөж байгаагаа зөвшөөрсөн түүнчлэн МУ-ын ЭХ-ийн 13.1-д заасан ХХГХ-ийн тайлбарт дурдсан хохирогч зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй байх агуулгатай зөрчилдөж байгаагаас гадна ХХГХ-ийг бэлгийн мөлжлөг гэмт хэргээр зүйлчлэн шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлснээр ХХГХ-ийн статистик бодитой гарахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 13.11 дүгээр зүйлд бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүйхөдөлмөр эрхлүүлсэн бол албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна. Энэхүү албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг нь Палермогийн протоколын 3 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгыг агуулж байгаа төдийгүй зарим ХХГХ-ийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргээр зүйлчлэн шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй байна.

2012 оны ЭХ-ийн 113 дугаар зүйлд тусгагдсан байсан ХХГХ үйлдсэн хүнд хүлээлгэж байсан эрүүгийн хариуцлагыг 2015 оны ЭХ-иар дараах байдлаар өөрчилж, чангатгасан нь шудрага ёс тогтоох, энэхүү төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулгатай байна. Үүнд:

2002 оны Эрүүгийн хууль		2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга	
Зүйл, хэсэг	Оногдуулах ял	Зүйл хэсэг	Оногдуулах ял
113.1 хүндэвтэр гэмт хэрэг	3-5 жил	13.1 хүнд гэмт хэрэг	2-8 жил
113.2 хүнд гэмт хэрэг	5-10 жил	13.2 хүнд гэмт хэрэг	5-12 жил
113.3 онц хүнд гэмт хэрэг	10-15 жил	13.3 хүнд гэмт хэрэг	12-20 жил хорих

2015 оны ЭХ-иар гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж хоёр ангилан, давтан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тухайн хэрэг бүрд ял оногдуулахаар, харин байнга тогтвортой үйлдсэн бол хүндрүүлж зүйлчлэхээр заасан байна.

БНХАУ болон Монгол Улсын хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт.

Монгол Улс болон БНХАУ-ын хууль сахиулах байгууллагууд өөр хоорондоо болон бусад орны зохих байгууллагуудтай хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн

шалгах, өөрийн орны иргэдийг авран хамгаалах, эргүүлэн авч ирэх чиглэлээр хамтран амжилттай ажиллаж ирсэн туршлагатай төдийгүй хамтын ажиллагааны механизм нь харьцангуй тогтворжсон байдаг.

Хоёр орны хамтын ажиллагааны хэд хэдэн санамж бичиг зурагдсан байдгаас дурьдвал, Монгол Улсын Хууль Зүй, Дотоод Хэргийн яамны харьяа Гадаадын Иргэдийн Харьяатын Ерөнхий Газар болон болон БНХАУ-ын НАХЯ-ны харьяа Орох, гарахыг хамаарах товчооны хооронд байгуулсан хамтын ажиллагааны хэд хэдэн санамж бичиг /2016 оны 09 сар/, Монгол Улс, БНХАУ хоорондын стратеги хамтын ажиллагааны дунд болон урт хугацааны хөтөлбөр /Бээжин, 2013 оны 10 сар/, Гэмт хэрэгтэй хамтран тэмцэх тухай хамтын ажиллагааны гэрээ /Монгол, 2011/ зэрэг байна. Эдгээрээс харахад эрх зүйн зохицуулалтын хүрээнд хамтран ажиллахыг дэмжих улс төрийн хүсэл зориг ихээхэн байгаа энэ үед техник түвшиндээ хамтын ажиллагааг өрнүүлэх, ялангуяа хүн худалдаалахыг мөрдөн шалгах чиглэлээр практик ажиллагаанд хамтрах шаардлага байна.

Монгол улсын өмнөд хэсэгт өрнөж буй уул уурхайн салбарын хөгжил дотоодын болон олон улсын шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлсэн нь ялангуяа Хятад-Монголын хилийн эргэн тойронд хүн худалдаалах гэмт хэргийн эрсдлийг өсөн нэмэгдүүлж байна. Хилээр нүүрс зөөж буй ачааны машины жолооч нарын паспортыг тээврийн хэрэгслийн барьцаа болгож хурааж авдаг нь тэднийг мөлжлөгт өртөх болзошгүй байдал хүргэж байна.

Эмэгтэйчүүд, охид уул уурхайн компаниудыг Хятадын хилтэй холбодог нүүрс тээвэрлэх зам дагуу хил нэвтрэхээр хүлээж буй жолооч нарт болон уул уурхайн жижиг тосгон, хотууд дахь шөнийн цэнгээний газруудад биеэ үнэлж бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл мөн өндөр байна. Уул уурхайд ажиллаж буй ажилчид урт хугацааны ээлжийн гарааны үеэр үр хүүхдээ гэртээ орхисноор тэд бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлд орж байна.

Түүнчлэн бага насны хүүхдүүд бичил уурхайтай холбоотойгоор албадан хөдөлмөр эрхлэлт болон бэлгийн мөлжлөгт өртөж байна. Зарим хүүхэд хүчээр гуйлга гуйх, хулгай хийх, эсвэл хогийн цэг дээр хог түүх, барилга дээр ажиллах, хурдан морь унах, мал маллах зэрэг эдийн засгийн албан бус секторт хөдөлмөр эрхэлж, зарим тохиолдолд гэр бүлийн гишүүдтэйгээ хамт бэлгийн мөлжлөгийн зорилго бүхий хүний наймаанд өртөж байна. Монгол улсад барилга, үйлдвэрлэл, газар тариалан, ой мод, загас, ан агнуур, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашины засвар, уул уурхайн салбарт гэрээгээр ажиллаж буй Хойд Солонгос болон Хятад ажилчид хүний наймаанд өртөх магадлалтай байна. Монгол улсад үлдсэн Хойд Солонгосын ажилчид хүнд, хэцүү нөхцөлд ажиллаж амьдардаг боловч чөлөөтэй зорчих, ажлын байраа сонгох эрхгүйн дээр цалин хөлснийхөө өчүүхэн хэсгийг гар дээрээ авдаг байна. Зарим хятад ажилчид цалин хөлсөө аваагүй тухай мэдээлжээ. Зарим нэгэн төрийн албан хаагчдын авлигын асуудал нь хууль бус газрууд дахь бэлгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг өөгшүүлж, хүний

наймааг таслан зогсоох засгийн газрын хүчин чармайлтад сөргөөр нөлөөлж байгаа тухай ажиглагчид дурдсан байна.⁸

Дүгнэлт, санал. 2008 онд Палермогийн протоколыг соёрхон баталж хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчдыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагын хүчин чармайлт, олон улсын дэмжлэгтэйгээр олон судалгаа хийгдэж Монгол Улсын хүн худалдаалахтай тэмцэх хууль тогтоомжийн чадавх эрс сайжирч олон улсын жишигт нийцжээ.

Мөн БНХАУ-тай хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах эрхзүйн үндэс хэдийн бүрэлдсэн байгаа нь сайшалтай. Бид Олон улсын өмнө хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж өөрийн уулсын иргэдийн эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангахын тулд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг эрс сайжруулах шаардлагатай байгаа бөгөөд дараах саналтай байна. Үүнд:

1. Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэл бодитой оршиж байна. Энэ гэмт хэргийн стратегийн эрсдлийг үнэлэх хэрэгцээ шаардлага нэгэнт бий болжээ,

2. Монгол Улс болон БНХАУ хоёр нь хил гаалийн шалгалт, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэх, түүнд хамаарагдах эрсдэл бүхий этгээдүүдийн зорчих, оршин суух хөдөлгөөн, үйл ажиллагааны талаар мэдээллийг шуурхай солилцох нь зохих үр дүнд хүрнэ.

3. Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийн үнэлгээг Монгол Улс, БНХАУ-ын Үндэсний аюулгүй байдал, хууль сахиулах ажиллааг хариуцдаг байгууллагын судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд хамтран хийхээс гадна тэдгээрийн багш, судлаачид харилцан туршлага судлах ажлыг зохион байгуулах.

4. Монгол Улс, БНХАУ болон бүс нутгийн хэмжээнд хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэл, бодит аюул, үр дагавар, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэх талаар хамтарсан бодлогоо шинэ түвшинд боловсруулж хэрэгжүүлэх,

5. Хоёр улсын хууль сахиулах, аюулгүй байдлыг бэхжүүлэх хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улсын гэрээнд заасан ажлуудаас гадна хөрш улсын хамтын ажиллагааг олон талт хэлбэрээр өргөжүүлэх шаардлагатай байна.

Ном зүй:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он: ТМ №1
2. Эрүүгийн хууль. 2002 он. ТМ №5
3. Эрүүгийн хууль. /шинэчилсэн найруулга/ 2015 он. ТМ №8
4. “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” Монгол Улсын хууль. 2012 он. ТМ №7

⁸ <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2018-trafficking-persons-report-mn/>

5. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. НҮБ-ын Ерөнхий ассамблейн 217 /А/III/ тогтоолоор 1946 оны оны 12 дугаар сарын 10-ны өдөр батласан. МУ-ын олон улсын гэрээ
6. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн протокол. ТМ №17
7. Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 148 дугаар тогтоол. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр
8. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, алба хаагчдын чадавхыг үнэлэх судалгааны тайлан. УБ., 2018 он.
9. Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яам. Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан. УБ., 2018.
10. <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2018-trafficking-persons-report-mn/>

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛЖ БУЙ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ

*ЦС-ийн ЦЭЗТ-ийн эрхлэгч,
цагдаагийн хурандаа А.Амарсайхан,
ЦС-ийн 335 дугаар дамжааны
дэд түрүүч Э.Энхбадрал*

Товч агуулга. Бид энэхүү өгүүллийн хүрээнд өсвөр насны хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын эрх зүйн орчин, тэдгээрээс гэмт хэрэг үйлдэж шүүхээс хорих ялыг хойшлуулсан байдал, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудлыг судлан тодорхой санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг. Өсвөр насны хүн, эрүүгийн хариуцлага

Үндсэн хэсэг. Өсвөр нас нь аливаа хүний хувийн амьдралын мөчлөгийн чухал хүчин зүйл төдийгүй, эрх зүйн харилцаанд оролцох субъектийн чадварыг тодорхойлоход шийдвэрлэх ач холбогдолтой тодорхой этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шалгуур нөхцөл болдог онцлогтой.

Өсвөр нас хүртэл хүүхэд насны хөгжлийн үе нь тэдний бие хүн болж төлөвших суурь нь болдог. Өсвөр насныхны сэтгэл зүйн хөгжлийн явц нь харилцан адилгүй. Өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийг мөрдөх болон шүүхээр хянаж үзэх үед “Насанд хүрээгүй этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн бодит мөн чанар болон нийгэмд учруулах аюулыг хамсарлах, эсхүл жолоодох боломжтой байсан уу” гэсэн асуудлыг авч үзэх ёстой юм.

Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт “Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” талаар заасан байна. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулах бодлогыг тусгайлан тодорхойлсон, хорих ялын бодлогыг уян хатан тодорхойлж хорихоос өөр төрлийн ялыг нэмж тусгасан бөгөөд уг бүлгийн онцлон авч эрэл хайгуул хийж, тоон судалгаа, цахим болон ном, сурах бичгээс онолын болон практикт хэрхэн хэрэглэгдэж байгаа талаар судлав.

Хүний нас нь өргөн утгаараа хувь хүний онцлогийг тодорхойлох нэг гол шинж болохын хувьд өөртөө биологи, физиологи, сэтгэл судлал, нийгэм, эрх зүйн учир холбогдолтой олон хүчин зүйлийг багтаасан төрөх үеэс эхлэлтэй амьдрах, амьдарсан хугацаа юм.

Хүнийг ухамсарт үйл ажиллагааны онцлог, сэтгэцийн түвшинг тодорхойлогч хүчин зүйл бол түүний нас юм. Учир нь хүний нас ахиж, физиологийн хөгжлийн тодорхой өндөрлөгт хүрэх тусам хувь хүний оюун ухаан, сэтгэх үйл явцын цар хүрээ улам сайжирч, энэ хэрээр амьдрал үйл ажиллагааны туршлага баяжин төлөвшиж, өөрийн үйл ажиллагааны мөн чанар, утга учир, гарах үр дагаврыг ухамсарлан

ойлгох, тайлбарлах, түүнчлэн үйл ажиллагаагаа удирдан залах, захиран хариуцах чадвар улам нэмэгддэг зүй тогтолтой.

Монгол хэлний их тайлбар тольд “өсвөр нас” гэдгийг ид өсөн торниж буй хүүхэд үеийг хэлнэ хэмээн тайлбарласан байдаг⁹ бол өдгөө Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудад өсвөр насны хүн /насанд хүрээгүй хүн/-ий ойлголтын талаар тодотгон тогтоосон нэр томъёо хэллэг нь нэг утга агуулга бүхий байх нь чухал асуудал юм.

Эрүүгийн хуулиар гэмт хэргийн субъектийг тодорхой насанд хүрсэн байхыг шаарддаг. Энэ нь хүүхдийн үйл ажиллагааныхаа учир холбогдлыг ойлгон ухамсарлах сэтгэхүйн хөгжлийн чадамжид үндэслэдэг. Учир нь гэмт хэрэг нийгмийн харилцааны энгийнээс нарийн төвөгтэйг хүртэл хамардаг учир хэрэг бүрийн нийгмийн учир холбогдол, хор уршгийг бага насны хүүхэд тэр бүр ойлгон ухамсарлах чадваргүй байдаг тул Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээх насыг нийтлэг байдлаар 16 наснаас эхлэн эрүүгийн хариуцага хүлээлгэдэг.

Харин хүүхэд нийгмийн учир холбогдол, хор уршигийг нь ойлгоход төвөггүй, нийгэмд аюултай болохыг нь ухамсарлах боломжтой зарим төрлийн гэмт хэргийн хувьд субъектийн насыг 14 наснаас эхлэхээр тогтоосон. Харин зарим төрлийн гэмт хэрэгт 18 насанд хүрсэн этгээдийг субъектээр тооцох шаардлага тавигдана.¹⁰

Өсвөр насны хүнийг насны ангиллын хувьд дараах байдлаар хуваан үзэж болох юм. Тухалбал:

1. Арван дөрөв хүртэлх насны хүүхдийг бага насны хүүхэд¹¹ гэх ба бага насны хүүхэд нь өөрийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюул, учир холбогдлыг бүрэн ухаарах чадваргүй, үйлдсэн хэргийн хариуцлага, үр дагаврыг мэдэх боломжгүй, оюун ухааны хөгжил гүйцээгүй байх тул бага насны хүүхдийг хариуцлага хүлээх чадваргүй гэж үздэг.
2. 14-18 хүртэлх насны хүүхдийг насанд хүрээгүй буюу өсвөр насны хүн гэж үзэх ба тэд хэдийгээр өөрийн үйлдлийн учир холбогдлыг ухаарах боловч бүрэн ухаарах чадваргүй, өөрийгөө удирдан жолоодох, үйлдлээ хянах, үр дагаврыг ойлгох чадвар, насанд хүрсэн хүнтэй харьцангуй сул тул тэдний үйлдсэн хэргийг тусгайлан авч үздэг.

2018 оны 11 сарын байдлаар шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 57 өсвөр насны этгээд хяналтанд байсан. 2019 оны 03 дугаар сарын байдлаар Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байгаа 6 эрэгтэй, 1 эмэгтэй өсвөр насны хоригдол анх удаа гэмт хэрэг үйлдэж шүүхээс оногдуулсан хорих ялыг хойшлуулсан хугацаандаа дахин гэмт хэрэг үйлдэж хорих ялыг биечлэн эдэлж байгаа нь анхаарал татах асуудал юм.

⁹Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” УБ хот, 1966 он, 156 дахь талд

¹⁰Г.Эрдэнэбат “Эрүүгийн эрх зүйн” гарын авлага, УБ хот, 2007 он, 91дэх талд

¹¹ Монгол Улсын Эрүүгийн Хууль, УБ, 2015 он, Төрийн мэдээлэл 2016 он, №7

Монгол улсад гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэл авч байсан өсвөр насны хүүхдүүдийг судалж үзэхээр эцэг, эх, харгалзан дэмжигчдийн хараа хяналт муу байх, үл хайхрагдах хүчирхийлэлд өртөж байсан зэрэг нь нөлөөлсөн байдаг.

Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна¹².

Эрүүгийн хуульд шүүх анх удаа “хөнгөн гэмт хэрэг”¹³ үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно¹⁴. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.

Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх анх удаа энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7.6 дугаарзүйлд заасны дагуу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа 7.3 дугаар зүйлийн 2,3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно” гэж тус тус заасан байна¹⁵.

ЭХ-ийн 7.6.1-т зааснаар хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулах үндэслэл нь өсвөр насны хүн анх удаа хөнгөн гэмт хэрэг /хорих ялын дээд хэмжээ 5 жил/ үйлдсэн байх бөгөөд ЭХ-ийн 8.6.1-т заахдаа анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ялын дээд хэмжээг 8 жил эсхүл түүнээс доош хугацаагаар тогтоосон гэдэгтэй шууд утгаараа зөрчилдөж байна.

Өөрөөр хэлбэл ЭХ-ийн 1.9-д заалснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ гэж заасан нь шүүхээс өсвөр насны хүн хөнгөн эсхүл хүнд гэмт хэрэг үйлдсэнээс үл хамааран хорих ялыг хойшлуулах боломжтой байдал үүсээд байгаа юм. Иймд ЭХ-ийн 7.6 дугаар бүлэгт энэ тухай тусад нь зүйл заалт болгон оруулж өгөх хэрэгтэй байна.

Мөн Эрүүгийн хуульд зааснаар гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг хоёрны нэгээр тооцож хорих ял оногдуулдаг. Хорих ялын дээд хэмжээг 8 жил хүртэл эсхүл түүнээс доош хугацаагаар тогтоосон гэмт хэрэг

¹²Монгол Улсын Эрүүгийн хууль,УБ.,2015 он., 8.1 дүгээр зүйлийн 2 дахь заалт;

¹³Монгол Улсын Эрүүгийн хууль,УБ.,2017 он., 2.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар хорих ялын дээд хэмжээг 5 жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял он

огдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ” гэж заасан.

¹⁴Монгол Улсын Эрүүгийн хууль,УБ.,2015 он., 7.6 дугаар зүйлийн 1 дэх заалт;

¹⁵Монгол Улсын Эрүүгийн хууль,УБ.,2017 он., 8.6 дугаар зүйлд 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

үйлдсэн өсвөр насны хүн шүүхээс хуулийн дагуу ялыг хөнгөрүүлж 4-н жилийн хорих ял оногдуулсан хорих ялыг хойшлуулах боломж харагдаж байна.

Сургалт-хүмүүжлийн байгууллагын нийгэм-сэтгэл зүйн албатай учир нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авч хохирлоо барагдуулахгүй бол хугацааны өмнө тэнсэн суллагдах эрх үүсэхгүй гэдгийг ойлгуулахаас гадна зан үйлд нөлөөлөх, хөдөлмөрлөх дадал олгох сургалтанд өсвөр насны хоригдлуудыг бүрэн хамруулж, үр дүн нь ч сайн байдаг.

Өсвөр насны хоригдол насанд хүрээгүй тул тодорхой ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй ерөнхий боловсролын сургалтанд хамруулж, сард 10 хүртэл шагналын хоног олгож, эдэлсэн ял дээр нэмж тооцдог. Мөн тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглож байнгын биечилсэн хяналтыг тавьж ар гэр рүү нь утсаар яриулах, зөвхөн хувийн хэрэгт бүртгэлтэй гэмт хэрэг үйлдэхэд хамааралгүй хүнтэй эргэлт, уулзалтаар уулзахыг зөвшөөрдөг.

ЭХ-ийн 6.12.1 дэх хэсэгт “Ялтан гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлж зан байдлаараа нийгэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялыг дараах хувийг эдэлсэн бол прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно” гэж заагаад 6.12.1.1. 5-н жил хүртэл хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг эдэлсэн бол хугацаанаас өмнө суллаж болно.

Мөн хуулийн 6.12.2 “Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтооно” гэж заасан нь практикт зөвхөн хорих ял биечлэн эдэлж байгаа хоригдлуудад хэрэгжүүлээд хорих ялыг биечлэн эдлээгүй ч хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан ялтан хяналтын хугацаанд хорих ял эдэлсэнд тооцогдгийг харгалзан үзэж энэ заалтыг нэг мөр хэрэгжүүлэх шаардлагатай.

Шүүхээс 2013-2017 онд 1443 насанд хүрээгүй этгээд ял шийтгүүлснээс 1273 хүүхдийн хорих ялыг хойшлуулж, 36 хүүхдэд тэнсэн харгалзсан байдаг.

Хүснэгт 1¹⁶

2013- 2017 он	НХХ-д шүүхээс хорих ял оногдуулсан байдлын судалгаа			Нийт 1443 100хувь
	Хорих ялыг биечлэн эдэлсэн	Тэнсэн харгалзах	Хорих ялыг оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан	
	134 буюу 9.3хувь	36 буюу 2.5хувь	1273 буюу 88хувь	

¹⁶“Монгол улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдэвт судалгааны ажлын тайлан /2013-2017/, УБ., 2018 он., 22 дахь тал;

2019 оны 3 сарын байдлаар Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад 30 гаруй өсвөр насны хоригдол хорих ял эдэлж байгаагаас 7 өсвөр насны хоригдол шүүхээс оногдуулсан хорих ялыг хойшлуулсан хугацаандаа дахин гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн байна.

Мөн эмэгтэй өсвөр насны хоригдлын хувьд 2018 онд анх удаа хулгайлах гэмт үйлдээд 2 жилийн хорих ял авч шүүхээс хорих ялыг 1 жилээр хойшлогдсон хугацаандаа дахин хулгайлах гэмт хэргийг бүлэглэн үйлдэж шүүхээс урьд оногдуулсан хорих ял дээр нэмж 2 жилийн хорих ял шийтгүүлэн 4 жилийн хорих ялыг багасгаж 2 жил болгон хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад биечлэн эдлүүлэх болсон.

Хорих ял хойшлогдсон хугацаанд нь Залуучуудын хөгжлийн төв, төрийн бус байгууллагуудын оролцоон дор зоргоор нь орхилгүй батлан даалтанд авсан хойд эцэг, төрсөн эх нь анхаарал сайн тавьж, охиныхоо бусдад уруу татагдах, гадуур тэнэх зэргээс урьдчилан сэргийлж чадсан бол бүлэглэн гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцөл бүрдэх байсан.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудын ял шийтгэлийн байдлыг 2019 оны 3 сарын байдлаар хүснэгтээр харуулвал:

Хүснэгт 2

Эрүүгийн хуулийн зүйл анги	Гэмт хэргийн ангилал	
	Хөнгөн	Хүнд
10.1 Бусдын амь насыг санаатай хохироох		2016 онд 5 жил хорих ял авсан. 1 хоригдол. 17 настай Анх удаа ял шийтгэгдсэн
11.1 Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах		2018 оны 1 сард 2 жил хорих ял авсан. 1 хоригдол. 17 настай Анх удаа ял шийтгэгдсэн
12.1.2.1, 12.1.2.2 Бусдын бэлгийн эрх чөлөөнд халдах	7 хоригдол. 16-17 насны /1-2 жилийн хорих ялтай/ Анх удаа ял шийтгэгдсэн	
12.1.4 бусдын бэлгийн эрх чөлөөнд халдах /хүндрүүлэх нөхцөлтэй/		7 хоригдол. 16-17 насны /6-9 жилийн хорих ялтай/ Анх удаа ял шийтгэгдсэн
17.1.2.1 Хулгайлах	9 хоригдол. 15-17 насны 1-2 жилийн хорих ялтай /Анх удаа ял авсан 6 нь, давтан шийтгэгдсэн 3/	

17.2.2. Дээрэмдэх		3 хоригдол. 15-17 насны 1-2 жилийн хорих ялтай давтан үйлдэлтэй .
Бүгд	17 хоригдол.	12 хоригдол.

Энэ нь эцэг эхийн зүгээс тавих хараа, хяналт алдагдаж бүтэн буюу эцэг эх нь салж сарнисан хагас өнчрөлд орох нь өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэрэг үйлдэхэд дөхөм үзүүлсэн нэг нөхцөл болж байна. Одоогоос 40 гаруй жилийн өмнө 1971 онд Монголд гэр бүл салалтын улмаас өнчирсөн, хаягдсан хүүхдүүдийн 12.6 хувь нь гэмт хэрэг үйлдэж, 14.5 хувь нь зөрчилд холбогдсон байгааг¹⁷ тогтоосон байдаг.

Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдэж буй хэргийн 60 гаруй хувь нь хулгай, үлдсэн хувь нь дээрэм, хүчин, танхай, зодоон бусад хэргүүд зонхилон эзэлдэг¹⁸.

Гэр бүл салалтыг аль болох гаргахгүй байх нь чухал гэдгийг эрдэмтэн Н.Жанцан 1984 онд өөрийн бүтээлдээ “...гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүсийн 400 хавтаст хэргийн материалд судалгаа хийж үзэхэд судалгаанд хамрагдагсдын 33.2 хувь бүрэн биш гэр бүлд хүмүүжсэн, 4.6 хувь нь эцэг эхгүй, 18.1 хувь эцэгтэйгээ, 9.2 хувь эхтэйгээ, 1.3хувь нь төрөл садныхантайгаа хамт амьдарч байсан байна...”¹⁹ гэж тэмдэглэжээ.

Энэ нь гэр бүлийн амьдралын нөхцөл үл хайхрагдах байдал нь хүүхдийн хүмүүжилд чухал нөлөө үзүүлдэг гэдгийг 25 жилийн өмнө баталсан бол 2013-2017 онд хорих ял авч хойшлогдсон 1273 хүүхэд, хорих ял биечлэн эдэлсэн 134 хүүхдийн ар гэрийн байдалд гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн байсан. Мөн Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа хүүхдүүдийн ар гэрийн байдал гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн болох нь тогтоогдсон байна.

Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулахыг аль болохоор зайлсхийж, харин нээлттэй “шорон” буюу нийгмээс тусгаарлахгүйгээр эрх чөлөөг нь түр хязгаарлах замаар нийгэмшүүлэх чиглэлийн олон сонголттой ялын төрлийг хэрэглэж, энэ нь “төр, иргэний байгууллага, гэр бүл”²⁰ гэсэн гурвалсан субъектын хамтын хариуцлагын зарчмаар хэрэгжүүлэхээр зохицуулсан байдаг.

НҮБ-аас гаргасан жишиг дүрэмд²¹ энэ талаар тодорхой тусгасан ба энэ нь шүүхээс хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэх болсныг илэрхийлнэ. Хүүхдийн эрхийн конвенцэд хүүхэд бүр эрхээ эдлэхийн тулд шаардлагатай бүхий л олон улсын конвенц болон үндэсний хуулийг хэрэглэх эрхтэй.²² Насанд хүрээгүй

¹⁷Н.Жанцан, Ю.Цэвээннамжил, “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, УБ., 1975 он., 26 дахь тал;

¹⁸Б.Наранзаяа. “Насанд хүрээгүй этгээдээс үйлдэгдэж буй хулгайн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн ба криминалгийн зарим асуудал” сэдэвт Цагдаагийн дээд сургуулийн дипломын ажил, УБ., 1999 он., 56 дахь тал;

¹⁹Н.Жанцан, “Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам”, УБ., 1984 он., 85 дахь тал;

²⁰“Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе”, УБ., 2013 он., 34 дахь тал;

²¹НҮБ-ын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдахь наад захын жишиг дүрэм./Токиогийн дүрэм/Ерөнхий Ассамблейн 1990 оны 10-р сарын 14-ний өдрийн 45/110-р тогтоол.

²²“Хүүхдийн эрхийн конвенц”, НУ., 1989 он., 37(Б);

этгээдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэдний насыг болон засарч хүмүүжихэд нь дэмжлэг үзүүлэхийг харгалзсан байна.²³

Хэргийн нөхцөл байдал шаардахгүй бол насанд хүрээгүй нэг ч хүнийг эцэг, эхийнх нь хараа хяналтаас бүрэн буюу зарим хэмжээгээр гаргаж болохгүйг заасан байдаг.

Дүгнэлт. Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүнийг хорих байгууллагад хорьсноор засарч хүмүүжүүлнэ гэж байхгүй, улмаар дахин гэмт хэрэгт холбогдох, суурь хүмүүжил муу этгээдүүдээс буруу үлгэрлэл олж авч төлөвшил тогтворгүй ёс зүйгүй хүн болж төлөвшин тогтнох суурийг бий болгох талтай.

2002 оны Эрүүгийн хуульд өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ямар ял оногдуулах талаар зааж өгөөгүй. Өсвөр насны хүн, том хүн хоёр нэг хуулиар яллуулдаг байсан бөгөөд шинэчилсэн найруулгаар хүүхдийн хорих ангийн хэлбэр өөрчлөгдөж сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага болсон. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүн ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалтад хамрагдаж байгаа юм. Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахдаа хорих ялыг хамгийн эцсийн арга хэмжээ болгож хэрэглэж байгаа юм.

Өсвөр насны хүнд оногдуулах ялын төрөл, ял оногдуулах журам, түүнд хэрэглэх албадлагын арга хэмжээг бие даасан бүлгээр 2015 оны Эрүүгийн хуулинд хуульчилж өгсөн. Ингэснээр өсвөр насны хүний бие, сэтгэл зүйн онцлогийг харгалзан насанд хүрэгчдээс ялгамжтай ял оногдуулах, аль болох хорих ял оногдуулахаас зайлс хийж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг үр дүнтэй хэрэглэж, нийгэм, хамт олны дунд хүмүүжүүлэх боломж нээгдэх юм.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулахаар, шүүх хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж, хуульд заасан хугацаагаар хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах, өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж болохоор тусгасан байгааг нь шинэчилсэн эрүүгийн ололттай тал харагдаж байна.

Дэвшүүлж буй санал:

1. Гадаад улс орнуудын Эрүүгийн хууль тогтоомжид “Насанд хүрээгүй хүн”-д ялыг хэрхэн оногдуулж, эдлүүлж буй талаар практикийн сургалт зохион байгуулах, хэсэгчлэн туршлагыг судлан үр дүнг харгалзан Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд ял эдлүүлэх хэсэгт нэмэлт оруулах.
2. Гадаадын зарим улсад “Насанд хүрээгүй хүн”-д ялыг хэрхэн оногдуулж, эдлүүлж буй талаар эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах.

²³“Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, 1966 он.,14.4 дэх хэсэг;

3. Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийг хорих ангид ялыг биечлэн эдлүүлснээр бүрэн дүүрэн хүмүүжүүлэх нь учир дутагдалтай учраас тэдэнд зөв иргэн хүн болж төлөвших суурийг нь бат суулгаж өгөхийн тулд тухайн нутаг дэвсгэрийг хариуцан ажиллаж байгаа хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, хүүхдийн байцаагч, хорооны цагдаа, нийгмийн ажилтан мөн гэмт хэрэгт холбогдож буй өсвөр насны хүүхдийн гэр бүлийн гишүүд түүнийг асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгч нарт энэ талаар сургалт зохиож үр дүнтэй ажлуудыг системтэй байгуулах шаардлага байна.
4. Насан хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэгт холбогдсон болон холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус мөн түүнчлэн гадаадын байгууллагын хамтын ажиллагааг шат шатандаа үр дүнд суурилсан арга зүй арга барилыг явуулах төрийн нэгдсэн тогтолцоог бий болгох.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ЗҮЙЛД ХИЙСЭН ТАЙЛБАР****Д.Эрдэнэбаатар**

(Хууль зүйн доктор, PhD)

Дотоод хэргийн их сургууль,

Монгол Улс Цахим шуудан:

erdenebaatar.d@uia.gov.mn

Оршил: Дотоод хэргийн их сургуулийн Цагдаа судлалын профессорын судалгааны багийн тэргүүлэх профессор, доктор, хошууч генерал Б.Пүрэвийн санаачлагаар тус судалгааны багаас Цагдаагийн албаны тухай хуулийн шинжлэх ухааны тайлбарыг хийхээр ажиллаж байгаа билээ.

Тайлбар хийх явц нэлээд удааширч байгааг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ нэгэнт бичиж эхэлсэн тайлбартаа судлаачдын санал шүүмжийг авах нь зүйтэй гэж үзсэн учраас Цагдаа судлал сэтгүүлд цувралаар нийтлүүлэхээр шийдсэн юм.

Эрдэмтэн, судлаач, сонирхогч хэн бүхэн Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалтад хийсэн тайлбарын талаар үнэтэй шүүмж ирүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтооход оршино.

ТАЙЛБАР

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтад²⁴ Засгийн газар нь “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх” үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан. Засгийн газар энэхүү бүрэн эрхийн хүрээнд тодорхой бүрэн эрхийг²⁵ эдэлдэг бөгөөд үүний нэг нь “Нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах” явдал юм.

Засгийн газар нь өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага буюу агентлагийг Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйл, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд²⁶ заасны дагуу байгуулна.

Цагдаагийн албаны тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үүргийг биелүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын

²⁴ Төрийн мэдээлэл. 1992 он. №1

²⁵ Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйл. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрх. //Төрийн мэдээлэл. 1993 он. №3

²⁶ Төрийн мэдээлэл. 2004 он, №16

тогтолцоо, үйл ажиллагаа, түүнд ажиллах төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тогтоох, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих иргэний хяналтыг хуульчлах зорилготой.

Хуулийн зорилтыг хууль тогтоогчоос тодорхойлсныг задалж үзвэл, энэ хуулиар 1) цагдаагийн албаны тогтолцооны эрх зүйн үндсийг; 2) цагдаагийн албаны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг; 3) албан хаагчийн эрх зүйн байдлын эрх зүйн үндсийг; 4) цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг; тус тус тогтоохыг зорьжээ.

Тухайлбал, цагдаагийн албаны тогтолцооны эрх зүйн үндсийг мөн хуулийн Цагдаагийн албаны тогтолцоо гэсэн 6 дугаар зүйлд, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын талаар 7 дугаар зүйлд, тэдгээрийн чиг үүргийн талаар 14-15 дугаар зүйлд, тогтолцоог бүрдүүлэгч олонлогийн нэг гэж үзэж болох Цагдаагийн байгууллагын сургалтын байгууллагын талаар 17 дугаар зүйлд, Судалгааны төвийн талаар 18 дугаар зүйлд тус тус заасан байна.

Харин цагдаагийн албаны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Цагдаагийн байгууллагын чиг үүрэг гэсэн 2 дугаар бүлгийн 10, 11, 12, 13 дугаар зүйл, Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журам гэсэн 4 дүгээр бүлэг, Албадлагын арга хэмжээ гэсэн 5 дугаар бүлэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шуурхай байдал, аюулгүй байдлыг хангах гэсэн 6 дугаар бүлэг, 7 бүлгийн Олон нийт цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг зохицуулсан 63, 64, 65 дугаар зүйлүүд, Цагдаагийн байгууллагын санхүүжилт гэсэн 9 дүгээр бүлэг, 10 дугаар бүлгийн 95, 96 дугаар зүйлээр тус тус тогтоожээ.

Цагдаагийн албан хаагчийн эрх зүйн байдлын эрх зүйн үндсийг 8 дугаар бүлгээр тогтоосон бол цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг 7 дугаар бүлгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих иргэний хяналтын талаар хэм хэмжээ тогтоосон 62 дугаар зүйлээр тогтоосон.

2 дугаар зүйл. Цагдаагийн албаны хууль тогтоомж

2.1. Цагдаагийн албаны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

ТАЙЛБАР

Цагдаагийн байгууллага нь чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа явуулахдаа:

- 1) Үндсэн хууль;
- 2) Засгийн газрын тухай хууль;
- 3) Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- 4) Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль;
- 5) Цагдаагийн албаны тухай хууль;

б) бусад хууль; -ийг дагаж мөрдөнө.

Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүхий л эрх зүйн хэм хэмжээний актыг дагаж мөрдөнө. Үндсэн хууль бол манай орны бүх хуулийн гол эх сурвалж, нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтын үндэс байдаг. Ийм учраас бүх хууль тогтоомж Үндсэн хуультай нийцсэн байхыг шаарддаг.

Цагдаагийн албаны тухай хуульд холбогдох харилцааг нарийвчлан зохицуулахаар заасан бол тухайн хуулийн хэм хэмжээг баримтлана. Жишээлбэл, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.9 дэх хэсэгт сахилгын шийтгэлтэй байх хугацааг хуульд өөрөөр заагаагүй бол 1 жил байхаар тогтоосон. Тэгвэл Төрийн албаны тухай хуулиар энэ хугацааг өөрөөр заасан бол Төрийн албаны тухай хуулиа баримтлана гэсэн ойлголт юм.

Хэрэв Төрийн албаны тухай хуулиар зохицуулсан харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар нарийвчлан зохицуулсан бол нарийвчилсан хэм хэмжээг хэрэглэх талаар Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт²⁷ заасан. Жишээлбэл, Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.11 дэх хэсэг хэсэгт зааснаар цагдаагийн алба хаагчид олгох цалин хөлсний нэмэгдлийн хэмжээ нь 2002 оны Төрийн албаны тухай хуулийн 28.13-т заасан төрийн албан хаагчийн цалин хөлсний 40 хувиас хэтрэхгүй байх зохицуулалтад хамаарахгүй²⁸.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “гэмт хэрэгтэй тэмцэх” гэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулахыг;

3.1.2. “нийтийн хэв журам хамгаалах” гэж гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг сахиулах үйл ажиллагааг;

3.1.3. “олон нийтийн аюулгүй байдлыг хангах” гэж хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, улс орны эрх ашигт ноцтой хор уршиг, хохирол учруулж болзошгүй аюулыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг;

3.1.4. “үндэслэл бүхий сэжиг” гэж цагдаагийн алба хаагч өөрт ил болсон тодорхой үйл явдал, мэдээ баримт, тухайн нутаг дэвсгэрийн онцлог, гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшин, сэжигтэй хүн, хуулийн этгээдийн байдал, үйл ажиллагаа зэргийг үнэлэн энэ хуульд заасан ажиллагааг гүйцэтгэх шаардлагатай гэх дүгнэлтэд хүрэх нөхцөл байдлыг;

3.1.5. “хамаарал бүхий этгээд” гэж цагдаагийн алба хаагчийн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн болон дагавар, үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач, зээг;

²⁷ Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг. Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ. //Төрийн мэдээлэл. 2002 он, №7

²⁸ 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдсантай холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.11 дэх хэсэгт өөрчлөлт оруулаагүй байгааг анхаарч залруулах нь зүйтэй. (Зох)

3.1.6. “биеийн хүч хэрэглэх” гэж цагдаагийн алба хаагч өөрийн бие махбод, мэргэжлийн тусгай бэлтгэлийг ашиглан бусдын хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор биеэр хийх үйлдлийг.

ТАЙЛБАР

Хууль зүйн шинжлэх ухаанд тайлбартай холбоотой “интерпретаци, эгзегеза, герменевтик” гэсэн нэр томъёонууд байдаг бөгөөд “эгзегеза” гэдэг нь дундад зууны үеийн Ромын эрх зүйд хэрэглэж байгаад одоо зүүд, үзмэр зэргийг тайлбарлах гэдэг утгаар хэрэглэдэг болсон.

Харин “герменевтик” гэдэг нь эртний грекийн уран илтгэгч, бурхны мэдээг ойлгомжтой болгохын тулд тайлбар хийдэг байсан Гермес бурханы нэрнээс гаралтай, хууль зүйн шинжлэх ухаанд тайлбар хийх авьяас чадварыг судлах, хууль зүйн бичвэрийг шинжлэн судлах гэдэг утгаар одоо хэрэглэгддэг. Дашрамд дурдахад хууль зүйн герменевтик нь эрх зүйн онолын бие даасан судлагдахуун болон хөгжиж байна.

Тэгвэл амьдрал дээр хууль тогтоогч эрх зүйн хэм хэмжээ, үйл баримтыг хэрэглээтэй нь уялдуулан тайлбарлах шаардлагатай тулгардаг. Хэл болон агуулга хоёр тэр болгон нийлдэггүй учраас латин хэлний “агуулга”, “мэдлэг” гэсэн үгнээс гаралтай интерпретаци буюу тайлбарлах гэдэг юмны утга агуулга, учир шалтгааныг дэлгэрүүлэн тайлж хэлэх, таниулж өгөх хууль зүйн шинжлэх ухааны ойлголт бий болжээ. Эрх зүйн онолчид “тайлбарлах гэдэг нь эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэхийн тулд агуулгыг нь тогтоох үйл ажиллагаа мөн” гэсэн байдаг.

Эрх зүйг бүтээгч байгууллага өөрийн гаргасан хэм хэмжээг тайлбарлах эрх эдэлдэг утгаараа Улсын Их Хурал Цагдаагийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлд зарим нэр томъёоны албан ёсны буюу аутентик тайлбар хийсэн нь заавал биелэгдэх шинжтэй юм. Үүнд:

Нэг. Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн нэг болох “Гэмт хэрэгтэй тэмцэх” гэдгийг дараах зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулахыг ойлгоно гэж тодорхойлсон:

- а) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;
- б) гэмт хэргийг таслан зогсоох;
- в) гэмт хэргийг илрүүлэх;
- г) гэмт хэргийг мөрдөн шалгах.

Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлд цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрхийн талаар заасан байна.

Эндээс цагдаагийн байгууллага “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулах”; “гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулах”; “гэмт хэргийг илрүүлэх зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулах”; “гэмт хэргийг мөрдөн шалгах зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулах”-аар хийх ажлыг заасныг үзэж болно.

Хуульд заасан ажиллагааг зөвхөн энэ хэм хэмжээгээр хязгаарлахгүй бөгөөд Цагдаагийн албаны тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай зэрэг хуульд болон тодорхой төрлийн гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулсан бусад хуульд заасан ажиллагаанууд хамаарна.

Гэмт хэрэгтэй тэмцэх нь гэдэг нь гэмт хэргийн гаралтын түвшинг бууруулах, тодорхой түвшинд тогтоох, гэмт хэрэг гарах боломжид нөлөөлөх, арилгах, таслан зогсоох, гэмт хэргийг устгах болон эдгээр зорилгоор гэмт хэргийн эсрэг зохих арга хэмжээ авахыг хэлнэ.

2019 оны Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн.” гэжээ.

Бидний тайлбар хийх гэж байгаа объект бол “ажиллагаа”, хууль тогтоогч энд “ажил” гэдгийг тайлбарласан нь ойлголтын зөрүү үүсгэхгүй гэдгийг Монгол хэлний их тайлбарт ажил гэдэг нь ямар нэгэн юмыг бүтээн бий болгох, бэлтгэх, боловсруулах биеийн болон оюуны үйл ажиллагаа²⁹ гэж тайлбарласнаас харж болно.

Харин 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.9 дэх хэсэгт³⁰ гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа гэж “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эсхүл мөрдөгч бие даан явуулах энэ хуульд заасан ажиллагаа”-г ойлгохоор хуульчилж нууц, ил хоёр хэлбэртэй байхаар тогтоосон.

Тэгвэл гэмт хэргийг таслан зогсоох болон илрүүлэх гэдгийг хууль тогтоогчоос тайлбарласан явдал хараахан үгүй байна.

Эрдэмтэн судлаачдын бүтээлээс үзэхэд гэмт явдалтай тэмцэх эрх зүйн арга хэмжээний³¹ хүрээнд урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, баримтжуулах (мөрдөн шалгах) талаар тогтоосон эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх, сахиулах ажиллагаа явуулдаг байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (crime prevention) гэдгийг консерватив, либерал, радикал чиг хандлагын үүднээс тус тус тайлбар өгсөн байдаг. Консерватив хандлагыг баримтлагчид боломжийг бууруулах онол буюу гэмт этгээд гэмт хэрэг үйлдэж олох ашиг нь гэмт этгээдийн төлөх төлбөрөөс бага байх ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэх нь эдийн засгийн хувьд гэмт этгээдэд ашиггүй байхаар тооцож хууль тогтоомжоо гаргах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гол арга гэж үзнэ.

²⁹ Монгол хэлний их тайлбар толь. Татсан: 2020-03-03. <https://mongoltoli.mn>

³⁰ //Төрийн мэдээлэл. 2017 он, №23

³¹ Гэмт явдалтай тэмцэх арга хэмжээний цогц тогтолцоонд эдийн засгийн; улс төрийн; эрх зүйн; сэтгэл зүйн; зохион байгуулалтын; техникийн; зэрэг арга хэмжээнүүд багтана. (Зох)

Харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх либерал загвар нь нийгмийн асуудал дээр төвлөрч олон нийт, иргэнийг өөрсдөө гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд туслах, нийгмийн эрсдэлтэй бүлгийг хөгжих боломжийг олгох арга замыг санал болгодог. Радикал хандлага нь нийгмийн гишүүн нэг бүрийн нөхцөл байдлыг дээшлүүлэх, тэдний ялгааг арилгаж нийгмийн гадуурхалт, тэгш бус байдлыг өөрчлөх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ гэж үздэг.

Эдгээр үзэл хандлагууд “гол байгаа буюу тодорхой хандлагын үзэл баримтлалыг тодорхойлох, гэмт хэрэг гэсэн ойлголтыг нэг мөр ойлгож хүлээн зөвшөөрөх, авах арга хэмжээний хэтийн төлөвлөлттэй байх, олон нийтийн үүрэг оролцоог тодорхойлох, “эрх зүй ба хууль”-ийн уялдаа харилцааг тодорхойлох” ёстой гэдэг дээр нэгддэг байна.

Гэмт хэргийг таслан зогсоох (crime suppression) нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэдэг ойлголтоос тусдаа гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны нэг бие даасан хэлбэр юм. Энэ нь олгогдсон эрх хэмжээний хүрээнд гэмт үйлдлийг зогсоох, гэмт үйлдэл үргэлжлэхээс сэргийлэх зорилго бүхий идэвхтэй үйлдэл байна.

Гэмт хэргийг таслан зогсоох ажлын хүрээнд давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хяналт тавих, цаг үеийн шинжтэй гарч байгаа гэмт хэргийн чиг хандлагад нөлөөлөх, хууль бус иргэний гүйлгээний эргэлтэд хяналт тавих зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

Үүний тулд нууц арга хэрэгсэл, техник хэрэгсэл ашиглах, эрэн сурвалжлах ажил явуулах, мэдээлэл олж авах урсгал бий болгох, далд тандалт судалгаа хийх, сэжигтэй хүмүүст хяналт тогтоох, тэдгээрийн талаар мэдээлэл цуглуулах, гэмт этгээдийг баривчлах, түүнд оролцох, гэмт этгээдийг эрэн сурвалжлаж байгаа, баривчлах гэж байгаа алба хаагчийг мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

Гэмт хэргийг илрүүлэх (deter crime and criminal); Гэмт хэргийг илрүүлэх нь дараах гурван үе шаттай:

- 1) гэмт хэрэг үйлдэгдснийг илрүүлэх;
- 2) гэмт хэрэг үйлдсэн этгээд хэн болохыг тогтоох;
- 3) гэмт этгээдийг яллах хангалттай нотлох баримт цуглуулах;

Гэмт хэрэг үйлдэгдсэн-ийг буюу хэн нэгэн этгээд хаа нэг газар ямар нэг гэмт хэрэг үйлдсэн гэдгийг гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх үүрэг бүхий субъект олж мэдэхээс гэмт хэрэг илрүүлэх ажиллагаа эхэлнэ. Энд бидний мэдэх цагдаагийн байгууллагын реактив, проактив үйл ажиллагааны талаар яригдах болдог. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага өөрийн идэвхтэй угтсан (урьдчилан) үйл ажиллагаагаар гэмт хэрэг үйлдэгдсэн талаар илрүүлэх, эсхүл иргэний гомдол, мэдээлэлд үндэслэн дараагийн шатны үйл ажиллагааг явуулдаг.

Цагдаагийн байгууллага нэгдүгээр үе шатанд дараах хоёр үйл ажиллагаа явуулна:

- 1) хэн нэг этгээдийг эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн үед гомдол гаргах, эсхүл мэдээлэл ирүүлэх (ихэвчлэн хохирогч, гэрч, магадгүй гэмт этгээд өөрөө), түүнийг хүлээн авч ажиллах реактив үйл ажиллагаа;

2) ихэвчлэн хохирогчгүй, эсхүл хохирогч гэмт явдлын золиос болсноо мэдээгүй гэмт хэрэг үйлдэгдсэн үед тэдгээрийг илрүүлэхээр цагдаагийн байгууллага проактив үйл ажиллагаа явуулах;

Гэмт хэрэг үйлдсэн этгээд хэн болохыг тогтоох-ын тулд цагдаагийн байгууллага дараах үйл ажиллагаа явуулдаг:

1) ул мөр илрүүлэх, илэрсэн ул мөрнөөс гэмт этгээдийн талаарх мэдээлэл олж авах;

2) хохирогч, эсхүл гэрч гэмт этгээдийг таних эсэх;

3) латин хэлээр *modus operandi* гэх, утгачилвал гэмт үйлдлийн аргаар нь гэмт этгээд хэн байж болохыг тодорхойлох;

Гэмт хэрэг үйлдэгдсэн газраас ул мөр илрүүлэх нь гэмт этгээдийн талаар маш их мэдээллийг олж авах бололцоог орчин цагийн шинжлэх ухааны ололт бидэнд олгож байгаа. Хамгийн түрүүнд гарын мөрний талаар яригдана. 19 дүгээр зууны сүүлч үеэс шүүхэд нотлох баримт болж хэрэглэх болсон энэ аргыг эрэл хайгуулч, бүтээлч хүмүүсийн санаачлага, зүтгэлээр бий болсон байдаг. Энэ үйл ажиллагаанд электрон төхөөрөмж, цахим орчин дахь ул мөрийг олж бэхжүүлэх ажил мөн хамаарна.

Гэмт этгээдийг нүдээр харсан, эсхүл түүний талаар тодорхой мэдээлэл бүхий хохирогч, гэрч нараас гэмт этгээдийг хэн болохыг тогтоох, таньж олуулах зэрэг үйл ажиллагааг цагдаагийн байгууллага явуулдаг.

Үйлдлийн аргаар нь гэмт этгээдийг тогтоох ажиллагаа бол зан үйлийн шинжлэх ухааны ихэнх хүн тодорхой үйлдлийг хийхдээ урьд хийж дадсан нэг арга барилаараа хийдэг гэсэн судалгаатай холбоотой. Ийм ч учраас цагдаагийн байгууллагад үйлдлийн аргын судалгаа буюу мэдээллийн сан бүрдүүлж ажилладаг.

Гэмт этгээдийг шүүхийн өмнө яллах хангалттай нотлох баримт цуглуулах;

Энэ үе шатны үйл ажиллагаа бол эрүүгийн процедурын хууль тогтоомжоор зохицуулагдана. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хууль дээдлэх зарчмынхаа хүрээнд хуулиар тавьсан шаардлагыг хангасан хуульд заасан нотлох баримтыг хангалттай цуглуулах нь цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг мөн.

Гэмт хэргийг илрүүлэх ажиллагааны эхний хоёр үе шат буюу гэмт хэрэг үйлдэгдснийг илрүүлэх, тухайн гэмт хэрэг хэн үйлдснийг тогтоох гэсэн үед шатанд тавигдах нотлох баримтын шаардлага, гуравдугаар үе шатанд шүүх хуралдаанд гэмт этгээдийн гэм бурууг нотлох хэмжээний нотлох баримтад тавигдах шаардлага гэх мэтчилэн тодорхой шалгууртай байх шаардлага бий болно. Үүнийг шийдэхийн тулд нотлох баримтын тухай хууль байж түүнийг дагаж мөрдөх замаар гэмт явдалтай тэмцэх, хохирогчийн эрхийг хамгаалах ажлын үр дүнг нэмэгдүүлэх эрх зүйн арга хэмжээ авах нь төрийн үүрэг юм.

Түүнчлэн цагдаагийн байгууллага өөрөө ул мөрөөс тодорхой мэдээлэл олж авах кримналистикийн үйл ажиллагааг явуулж байж гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийг илрүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлнэ. Тэгэхээр шинжлэн магадлах үйл ажиллагаа, цагдаагийн байгууллагын гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагааг зохих ёсоор зааг ялгааг нь тогтоох зайлшгүй шаардлага бий.

Хоёр. Цагдаагийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтаар цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн нэг болох “Нийтийн хэв журам хамгаалах” гэдгийг

- а) гудамж, талбайд; болон
- б) олон нийтийн бусад газарт; тус тус
- в) нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг
- г) сахиулах үйл ажиллагааг гэж тайлбарласан.

Энд нэгдүгээрт “юуг” сахиулах гэж байгаа талаар, хоёрдугаарт “сахиулах үйл ажиллагаа”-г тус тус тайлбарлах ёстой болж байгаа тул дугаарлан авч үзэв. “Юуг” гэсэн асуултад багтах “сахиулагдах” ёстой болж байгаа объект нь нэгдүгээрт нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт, түүний тогтоосон дүрэм журам болон тэдгээр дүрэм, журмыг хүмүүс нийтээрээ “хаана” буюу а) гудамж, талбайд; б) олон нийтийн бусад газарт; тус тус заавал дагаж мөрдөх талаар заасан тул тус бүрт нь тайлбар өгөх нь зүйтэй гэж үзэв.

Гудамж, талбай болон олон нийтийн бусад газар. Гудамж, талбайн талаар хуулиар тогтоосон нэр томъёоны тайлбар байдаггүй бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтаар “гудамж талбайд нэр өгөх” аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрхийг хуульчилжээ. Үүнээс үзэхэд гудамж ба талбай нь хот суурин газарт хэрэглэгдэх ба тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын шийдвэрээр нэртэй байх, цаашилбал нэр нь улсын бүртгэлд бүртгэлтэй байхыг шаардана. Жишээ нь: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 269 дүгээр тогтоолоор журам³² баталж Нийслэл Улаанбаатар хотын гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, барилга байгууламжид дугаар олгох журам мөрдүүлсэн байна.

Энэ журмын зорилго нь “Нийслэл Улаанбаатар хотын гудамж, талбайд нэр өгөх, барилга байгууламжийг дугаарлаж мэдээллийн санд оруулах, улмаар хотын доторхи нэр, хаягтай холбоотой ажил үйлчилгээг эрхэлдэг түргэн тусламж, гал команд, шуудан харилцаа, цагдаа зэрэг байгууллагуудын үйл ажиллагааг харилцан уялдуулах, тэдгээрийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгоход чиглэгдэнэ” гэжээ.

Энэ журамд зааснаар “гудамж” гэж “тээврийн хэрэгсэл болон явган зорчигчдын хөдөлгөөнийг нэвтрүүлж өнгөрүүлэх зурвас талбайг” ойлгох бөгөөд хотын, хорооллын, өргөн чөлөө, цэцэрлэгт гудамж гэж нийслэлийн хувьд ангилжээ.

Харин талбай гэж орчны барилга байгууламжтай зохицуулж төлөвлөсөн бөгөөд хотын гудамж, өргөн чөлөөтэй холбогдсон олон нийтийн зориулалтай тодорхой хэмжээний газрыг эзэлсэн орон зайг ойлгоно. Ийм талбайг Иргэдийн

³² НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 269 дүгээр тогтоол. Нийслэл Улаанбаатар хотын гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, барилга, байгууламжид дугаар олгох журам. Татсан: 2019-04-22. Цахим хуудас: <http://mpa.ub.gov.mn>

Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор тогтоож нэр өгдөг бол хуулиар тогтоосон нэг талбай байдаг нь Сүхбаатарын талбай юм³³.

Эдгээр нь өөрсдөө олон нийтийн газар гэсэн ойлголтод багтах бөгөөд нийтийн эзэмшлийн буюу тодорхой бүлэг хүмүүст зориулсан боловч тэр нь ямарваа хязгаарлалт тавигддаггүй газрууд, тухайлбал зам, хурдны зам, сургууль, эмнэлэг, орон сууц, оффисын барилга, зам тээврийн орчин, дэлгүүр зэрэг нийгмийн гишүүдийн хэнд ч нээлттэй бизнесийн, амьдрах орчны, зугаа цэнгэлийн зориулалтаар, эсхүл хууль ёсны зорилгоор ашиглах эрхтэй бүхий л газрууд багтана.

Амьдрах орчны олон нийтийн газар гэдэгт апартамент гэж нэрлэдэг орон сууцны барилгын хонгил, цахилгаан шат, хүлээлгийн танхим, шат зэрэг нийтээр ашиглах эрхтэй газрууд багтана.

Нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журам. Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно”³⁴.

Захиргааны хэм хэмжээний актуудын үндсэн шинж буюу “хуулиар тусгайлан эрх олгогдсон байх”, “захиргааны байгууллага”, “нийтээр заавар дагаж мөрдөх”, “гадагш чиглэсэн”, “үйлчлэл нь байнга давтагдах” шинжийн талаар болон бусад дэлгэрэнгүйг Захиргааны ерөнхий хууль болон Эрх зүйн ерөнхий онол³⁵, Захиргааны эрх зүйн ерөнхий анги³⁶, Захиргааны ерөнхий хуулийн тайлбар³⁷ зэрэг бүтээлээс тус тус үзэж болно.

Сахиулах үйл ажиллагаа. Орос хэлээр “правоохранительные”, англи хэлээр “law enforcement” гэдгийг бид хууль хамгаалах, хууль сахиулах гэх зэргээр орчуулдаг. “Правоохранительные” нь англи хэл рүү буухдаа “law enforcement” гэж бууж тэд нэг ойлголттой байгаа нь харагдаж байна.

Хурандаа генерал Ж.Авхиа, хошууч генерал А.Думбурай нарын гардан боловсруулсан Улсын Их хурлаас 1997 онд баталсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.6.3, 16 дугаар зүйлийн 16.3. 18 дугаар зүйлийн 18.2.2, 19 дүгээр 19.3.1 дэх заалтууд, нийт 7 зүйл, хэсэгт “**хууль сахиулах байгууллага**” гэж орсон. Энэ үед төрийн бодлогын хэмжээнд, хуулийн хэмжээнд “хууль сахиулах” гэдэг үг томъёологдож оржээ³⁸.

³³ Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6, 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг. //Төрийн мэдээлэл. 1994 он, №9

³⁴ Захиргааны ерөнхий хууль. //Төрийн мэдээлэл. 2015, №28

³⁵ Нямсүрэн Ч. Эрх зүйн ерөнхий онол. -Уб., 2017. 151-177 дахь тал.

³⁶ Одгэрэл П. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. 3 дахь хэвлэл. -Уб., 2016.

³⁷ Сүнжид Д нар. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (судалгаа, хэрэглээний). Уб., 2017.

³⁸ Амарсанаа Ж. Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл: бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны өнөөгийн төлөв байдал, шийдвэрлэх арга зам илтгэл хэлэлцүүлэх үед хэлсэн үгнээс. Хууль сахиулах үйл ажиллагаа: онол практикийн тулгамдсан асуудал. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын тэмдэглэлээс, -Уб.:ХСИС., 2016.

Сахиулах гэдэг нь “дагаж мөрдүүлэх: сахилга журмыг сахиулах (дүрэм журмыг дагаж мөрдүүлэх)” гэсэн утгатай³⁹. Эрх зүйн онолын бүтээлүүдэд эрх зүйг хэрэгжүүлэх хэлбэрийн нэг нь эрх зүйг сахих (хариуцлага) бөгөөд сахих гэдэг нь эрх зүйн үр дагавар бүхий хариуцлагыг хүлээх, гуйвалтгүй мөрдөхийг хэлнэ гэжээ⁴⁰.

Сахиулах нь сахих гэсэн үйлийн бусдаар үйлдүүлэх хэв бөгөөд үүнд бусдаар хийлгэх, ингэхдээ албадлага хэрэглэх гэсэн утгыг агуулж байгаа тул эрх зүйн горим журам тогтоосон норматив хэм хэмжээг сахин биелүүлэх явдлыг төрийн албадлагаар баталгаатай хангах үйл ажиллагааг ойлгоно. Өөрөөр хэлбэл, аливаа субъект эрх зүйн хориглосон хэм хэмжээг дагаж мөрдөх замаар эрх зүйг хэрэгжүүлэх ёстой бөгөөд түүнийг биелүүлээгүй бол хариуцлага хүлээлгэхээр *гэмт хэрэг, зөрчил* гэж тогтоосон тэр хэм хэмжээг сахиулдаг.

Гэмт явдал судлал (криминологи) нь хуулийг бүтээх, хуулийг зөрчих, хуулийг сахиулах үйл явцыг бүхэлд нь судалдаг⁴¹. Криминологч Роналд Акерс, Кристин Селлерс нар криминологийн онолуудыг ангилсан бөгөөд үүний нэг нь бид яагаад хуультай байх ёстой буюу ямрыг нь гэмт хэрэг гэж хуульчлах ёстой, яагаад эрүү, захиргааны хариуцлагын тогтолцоог⁴² бий болгодог, тэр тогтолцооны хүрээнд *юуг хэрхэн хийхийг* судалж байгаа тул хуулийг бүтээх, *сахиулах* хоёрыг нь нэгтгэн авч үзэж Эрүүгийн хуулийг бүтээх ба сахиулах онолууд буюу эрүүгийн тогтолцооны онол (Criminal Justice Theory) гэж нэрлэжээ⁴³.

Энд багтаж байгаа хуулийг сахиулах нь эрх зүйн хамгаалах хэм хэмжээг сахиулж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, албадлага хэрэглэх, хууль зүйн хариуцлага ногдуулах, биелүүлэх, хяналт тавих ажиллагааг зохицуулах процедурын хуулиар зохицуулагддаг.

Эрүүгийн процедурын хуулиас гадна хуулийг сахиулах талаар улс орнууд Цагдаагийн хууль эсхүл бие даасан хуулиар үйл ажиллагааг нь зохицуулж ирсэн. Манай улсад 2017 оны Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг хуульчилж өгсөн бөгөөд энэ талаарх дэлгэрэнгүйг 4, 5, 6 дугаар бүлгийн тайлбараас үзнэ үү.

Гурав. Хууль тогтоогч “олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэж хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, улс орны эрх ашигт ноцтой хор уршиг, хохирол учруулж болзошгүй аюулыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг” ойлгоно гэсэн дефинитив хэм хэмжээгээр тодорхойлсон.

³⁹ Монгол хэлний их тайлбар толь. <https://mongoltoli.mn>

⁴⁰ Баярсайхан Д. Эрх зүйн онол, УБ., 2010, 3 дахь хэвлэл, 189 дэх тал.

⁴¹ Ronald L. Akers, Christine S. Sellers, Criminological Theories – introduction, Evaluation and Application, 5th edition, 2009

⁴² Criminal Justice System гэснийг Хууль сахиулагчийн эрх зүйн байдал, Цагдаагийн алба, мөрдөх алба, маршалын албаны тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулсан тухай тайланд Эрүүгийн тогтолцоо гэж томъёолсноор авсан болно. //Хууль сахиулахын их сургууль, 2013.

⁴³ Эрдэнэбаатар Д. Хууль сахиулах үйл ажиллагааны өнөөгийн байдал, чиг хандлага илтгэл. //Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл-I, -УБ., 2016. 7-15 дахь тал.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг 2013 оны Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн байгууллагад хүлээлгэсэн.

Манай улсын хуульд туссан “нийтийн хэв журам хамгаалах” нь англи хэлнээ “Maintenance of Public Order” гэж буух ба энэ нь “public safety” гэсэн ойлголтын хүрээнд хэрэглэгддэг бол “олон нийтийн аюулгүй байдал” нь “public security” гэж бууна. Эдгээр нь Цагдаагийн албаны тухай хуульд туссан байдлаараа шууд ялгаа нь харагдаж байгаа боловч олон нийт гэсэн үгийн дараа хоёулаа монгол хэлнээ “аюулгүй байдал” гэж буудаг “safety”, “security” гэсэн үг орсон байдгаас эргэлзээ үүсдэг.

Иймд аюулгүй байдлын шинжээч Spencer Coursen-ийн тайлбарласан жишээгээр эдгээр ойлголтын ялгааг харуулахыг оролдов⁴⁴. Тэр “security” бол бидний амгалан тайван байдал (safety)-ыг хангах үйл явц гээд эдгээрийн ялгааг тайлбарлахын тулд шүхэр ашигласан. Өөрөөр хэлбэл, борооны шүхэрний халх нь бол security буюу хамгаалагч түүний дор бороо, цаснаас хамгаалагдах нь safety буюу амгалан тайван байдал юм (Зураг №1).

Зураг №1



Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон хэм хэмжээг сахиулах үйл ажиллагаа явуулах буюу эрх зүйн хэм хэмжээг зөрчих явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлдэг бол олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хамгаалах буюу харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулдаг.

Үүнийг Япон улсын Цагдаагийн байгууллагын тухай 1954 оны, Цагдаагийн байгууллагын үүргээ гүйцэтгэх тухай 1948 оны хуулиудын жишээгээр тайлбарлаж болох юм. Япон улсын цагдаагийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд Нийгмийн хэв журам хамгаалах алба (Public safety Bureau), 24 дүгээр зүйлд Аюулгүй байдлын (Security Bureau) албанд хамаарах ажил үүргийг тодорхойлсон.

Нийгмийн хэв журам хамгаалах алба нь 1) гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осолтой холбоотой иргэдийн амгалан тайван байдлыг хангахтай холбоотой асуудал; 2) эргүүл хийх, олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа; 3) гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудал; 4) хэв журам сахиулах; ажлыг тус тус хариуцдаг.

⁴⁴ Spencer Coursen. Safety vs. Security: Understanding the Difference May Soon Save Lives. Published on August 31, 2014.

Хариу Аюулгүй байдлын алба нь 1) хамгаалалтын алба; 2) эзэн хааны хамгаалалт; 3) тодорхой хүний хамгаалах; 4) мэдээллийн аюулгүй байдлыг хангах; 5) байгалийн гамшиг, бусад онцгой нөхцөл байдал үүссэн үеийн төлөвлөгөөний биелэлт болон онц байдал зарлан тогтоосон дэг журмыг сахиулах, амгалан тайван байдлыг хангах; болон 6) гадаадад улсад байгаа Японы улсын иргэн, тус улсад байгаа гадаадын иргэнийг хамгаалах, тэдгээртэй холбоотой хэрэг, зөрчлийн асуудлыг хариуцна.

Үүнээс “security” болон “safety” хоёрын ялгаа нь тодорхой харагдаж байна. Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлд цагдаагийн байгууллага нь нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрхийг, 12 дугаар зүйлд олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрхийн жагсаалтыг баталсан. Иймд эдгээр чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх үүргийн ялгаа заагийг адил мэт ойлгож болохгүй.

Харин гэмт хэрэгтэй тэмцэх нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн нь чиг үүрэг үү, аль эсхүл үйл ажиллагааны нэг хэсэг үү гэдгийг менежментийн шинжлэх ухааны үүднээс хойно хөндөж авч үзэх болно.

Дөрөв. Үндэслэл бүхий сэжиг гэдэг нэр томьёо анх удаа энэ хуульд тусгагдаж “...нөхцөл байдлыг” хэлнэ гэж тодорхойлсон бол 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлд “1.23.үндэслэл бүхий сэжиг гэж ... дотоод итгэлийг” ойлгоно гэж тусгасан.

Үүнтэй төстэй томьёолол 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172 дугаар зүйлд “үндэслэлтэй сэжиг” байгаа тохиолдолд хойшлуулшгүй ажиллагаа явуулахаар зааж байжээ.

Энэ ойлголтыг олон улсад “probable cause” гэх ба “probable” нь магадлалтай, болзошгүй, cause нь “учир зүй, шалтгаан” гэх утгатай. Хууль зүйн шинжлэх ухаанд энэ нь “тодорхой шалтгаанаар аливаа үзэгдлийг магадлалтай гэж таамаглах” гэсэн утга илэрхийлнэ.

Нийтлэг хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт нь “сэжиглэх үндэслэл мөн. Гэхдээ энэхүү сэжиглэх үндэслэл нь тодорхой баримтыг үнэн байх магадлалтай гэсэн дотоод итгэлээр хангалттай баталсан байхыг хэлнэ⁴⁵”.

Энэ утгаараа магадлалын онол, математик статистикийн шинжлэх ухаантай холбогдоно. Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл бүхий сэжиг нь мөн хуулийн 4, 5, 6 дугаар бүлэгт заасан цагдаагийн алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах үндэслэл нь болж өгнө. Иймд тодорхой ажиллагаа явуулсан тохиолдол, алба хаагчийн шийдвэр гаргасан дотоод итгэл, түүнд нөлөөлсөн нөхцөл байдал, бэлтгэлжилт зэргийг судалж статистикт дүн шинжилгээ хийж магадлалын хувьд тогтоож болох стандартыг бий болгох, алба хаагчийн үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг боловсронгуй болгодог механизм бий болгох шаардлагатай юм.

⁴⁵ Handler, J. G. (1994). Ballentine's Law Dictionary (Legal Assistant ed.). Albany: Delmar. p. 431. ISBN 0827348746.

Тав. Цагдаагийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтад цагдаагийн алба хаагчийн хамаарал бүхий этгээдийг эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн болон дагавар, үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач, зээг багтаан тайлбарлажээ.

Ийнхүү цагдаагийн алба хаагчийн хамаарал бүхий этгээдийг тодорхойлж өгсөн нь цагдаагийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан өөрийг нь болон хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд заналхийлэхээс хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах, заналхийлсэн этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх ач холбогдолтой.

Цагдаагийн албаны тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.6, 97 дугаар зүйлийн 97.2 дахь хэсгийг үзнэ үү.

Зургаа. Цагдаагийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтаар “биеийн хүч хэрэглэх” үйлдлийг тодорхойлсон. Үүнд цагдаагийн алба хаагч бусдын хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор хийх үйлдэл багтана.

Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар бүлэгт цагдаагийн алба хаагч хэрэглэх албадлагын арга хэмжээ, түүний төрлийн талаар заасан бөгөөд үүний нэг төрөл нь мөн бүлгийн 49 дүгээр зүйлд заасан биеийн хүч хэрэглэх юм.

1993 оны Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад цагдаагийн алба хаагч самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх ашиглана гэж заасан байсан.

2002, 2015 оны Эрүүгийн хуулиудаар гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах гэсэн зүйлээр гэмт хэрэг үйлдсэн, оргосон ялтныг баривчлах, төрийн байгууллагад хүргэх, гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор эрүүгийн хуулиар хориглосон үйлдлийг хийсэн бол гэмт хэрэгт тооцохгүй гэж заасан. Иймд цагдаагийн алба хаагчийн хүч хэрэглэх эрх хэмжээг зэвсэггүйгээр тулалдах мэхээр хязгаарлах үндэслэл байхгүй гэж үзсэн.

Зарим гадаад орны цагдаагийн албаны тухай хуульд, тухайлбал ОХУ-ын цагдаагийн байгууллагын тухай хуульд эрүүгийн хуулийн аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын үед цагдаагийн алба хаагч иргэний нэг адил өөрт тааралдсан зүйлийг ашиглан өөрийгөө болон бусдыг хамгаалж болохоор заасан байдаг.

4 дүгээр зүйл. Цагдаагийн алба

4.1. Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.

ТАЙЛБАР

Төрийн үзүүлж буй бүх үйлчилгээнүүдийн дотроос хамгийн чухал нь аюулгүй байдлыг хангах үйлчилгээ байх ёстой. Үүний тулд иргэдийн аюулгүй байдалд заналхийлсэн гадаадын хийгээд дотоодын ганцаарчилсан ч бай, нэгдсэн бай ч харгис хүчнийг дарж чадах өөрийн гэсэн хүчтэй байх ёстой⁴⁶.

⁴⁶ Фредрек Бастиа. Ил харагдах, үл харагдах хоёр, УБ., 2014, 160 дахь тал.

Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын үндсэн чиг үүргийг энэ зүйлээр тогтоосон. Үүнд:

- 1) гэмт хэрэгтэй тэмцэх;
- 2) нийтийн хэв журам хамгаалах;
- 3) олон нийтийн аюулгүй байдлыг хангах;

Эдгээр үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд төрийн албаны ангиллын хувьд төрийн тусгай албанд хамаарна гэдгийг тодорхойлжээ.

Манай цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрхэн тодорхойлж ирсэн талаарх эх сурвалжуудыг авч үзэхэд цагдаагийн байгууллагын чиг үүргийг Цагдаагийн байгууллагын үе үеийн дүрэм, хуулиар тогтоож иржээ. Тухайлбал:

Он	Эрх зүйн акт ⁴⁷	Чиг үүрэг
1923	Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрмийн нэгдүгээр зүйл	“Цагдан сэргийлэх хорооны албан хаагчид тогтоосон хууль дүрмийг журамлан дагаж ард олныг батлан хамгаалж амар жимрээр аж төрүүлэх тушаалыг гүйцэтгэхийг чухал зорилт болговоос зохьмой”
1926	Цагдан сэргийлэх газрын дүрмийн нэгдүгээр зүйл	“...бүх улсын дотоодын амгалан байдлыг сахиж, ард олныг батлан хамгаалахад холбогдол бүхий цагдан сэргийлэх явдал”
1928	Цагдан сэргийлэх газрын дагаж явах дүрмийн нэгдүгээр зүйл	“...цагдан сэргийлэх явдлыг гүйцэтгэх”
1934	Бүгд найрамдах Монгол Ард Улсын цагдан сэргийлэхийн тухай дүрийн нэгдүгээр зүйл	БНМАУ-ын аж ахуйг амжилттай бөгөөд албан байгууллагууд хийгээд ард нийтийн бүхий аж байдлыг амгалан тайвнаар хөгжүүлэх дор чухал холбогдох ёс журмыг сахиулан гүйцэтгүүлэх ба төвийн ба орон нутгийн эрх барих газруудаас гаргасан захирах тушаах чанар бүхий тогтоол тушаалуудыг хэрэг дээр биелүүлэн гүйцэтгүүлэх арга хэмжээг авах, ард нийтийн ба албан тушаалын хүмүүсээс хэрхэн биелүүлж буйг хянан харгалзаж, үүнчлэн ард ба бусад олон нийтийн бие ба тэдгээрийн хөрөнгө хогшлыг арчлан хамгаалахын тулд БНМАУ-ын цагдан сэргийлэх газрыг байгуулна.
1942	Улсын цагдан сэргийлэх газрын дүрмийн хоёрдугаар зүйл	“... Үндсэн хуулийн ёсоор тус улсын дотоодын ба ард түмний амгалан тайван байдлыг аюулаас сахиж хамгаалах”
1955	Улсын цагдан сэргийлэхийн дүрмийн нэгдүгээр зүйл	“...олон нийтийн журам, ард иргэдийн аюулгүй байдлыг сахин хамгаалах”
1963	Цагдан сэргийлэх байгууллагын дүрмийн нэгдүгээр зүйл	“...олон нийтийн хэв журам сахиулах, социалист өмч, ард иргэдийн эрх ашгийг хамгаалах”
1993	Монгол Улсын Цагдаагийн	“... гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах

⁴⁷Думбурай А., БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын зарим эрхийн актууд. УБ., 1988, 15, 21, 32, 42, 49, 53, 61 дэх тал. (Дүрмүүдийг авч ашигласан эх сурвалж)

	байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн”
2013	Цагдаагийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйл.	“Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага мөн”

Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хувьд 2015 онд Дотоодын цэргийн чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотойгоор орж ирсэн.

Чиг үүрэг нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хүрээг тогтоож өгснөөрөө ач холбогдолтой бөгөөд цагдаагийн байгууллагын үүргийг нийтлэг шинжээр нь бүлэглэн ангилсныг чиг үүрэг гэж байгаа юм. Эдгээр чиг үүрэгт юу юу багтахыг задалж тоочсныг үүрэг гэнэ⁴⁸.

Эндээс чиг үүрэг, гүйцэтгэх үүрэг гэсэн ойлголтуудын ялгааг нарийвчлан авч үзэх шаардлага гарна. Учир нь чиг үүрэг (function⁴⁹) бол тодорхой байгууллагын, эсхүл тодорхой ажлын байрны үндсэн зорилгыг илэрхийлдэг. Харин үүрэг (role) нь тодорхой тохиолдолд хэрэгжүүлэх хэсэгчилсэн үйлдлийг хэлдгээрээ чиг үүргээс ялгагдах гол ялгаа нь оршино. Тэгвэл зорилго гэж алс ирээдүйд хүрнэ гэж төлөвлөсөн эрмэлзэл юм⁵⁰.

Монгол Улсын Засгийн газрын “Аргачлал батлах тухай” 2018 оны 22 дугаар тогтоолд “чиг үүрэг” гэдэг нь төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэл”-ийг ойлгохоор тогтоосон. Үүнээс үзэхэд чиг үүрэг нь өөртөө хэтдээ хүрэхээр тэмүүлж байгаа зорилгоо багтаасан байх шаардлагатай бөгөөд алба хаагч гүйцэтгэх үүргийнхээ цаад зорилгыг ойлгож мэдэж байх нь үүргээ амжилттай биелүүлэхийн үндэс байна.

Тийм ч учраас гадаад орнуудын цагдаагийн албаны тухай хууль, бусад бүтээлүүдэд цагдаагийн байгууллагын чиг үүргийг *хүний амь бие, эд хөрөнгийг хамгаалах явдал* гээд энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль сахиулах буюу гэмт хэрэгтэй тэмцэх; нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг сахиулах үүрэг гүйцэтгэхээр заасан байдаг.

Гадаад орнуудын цагдаагийн байгууллагын чиг үүргийг тодорхойлж байгаа зарчим нь хүний салшгүй үндсэн эрх болох амьд явах, өмчлөх эрхийг хангах төрийн үндсэн үүрэгтэй холбогдоно. Тэгэхээр өнөөдөр хуульчилсан цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэлийн өөрийнх нь үр дүн цагдаагийн байгууллагын зорилго мөн гэж үзэж болох юм.

Иймд эдгээр үйл ажиллагааны чиглэлийн өөрийнх нь зорилго юу болох нь Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлээс эхтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр

⁴⁸ Пүрэв Б. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар. УБ., 1997, 13 дахь тал.

⁴⁹ Functio- биелүүлэх гэсэн утгатай латин үгнээс гаралтай.

⁵⁰ Монгол хэлний их тайлбар толь. Татсан: 2020-04-04. Цахим хуудас: <https://mongoltoli.mn>

бүлэг болох “Монгол Улсын бүрэн эрхт байдал”-ыг баталгаажуулсан бүлгийн дурдсан зүйлд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” хэмээн заажээ.

Энэхүү төрийн үүргийг хэрэгжүүлэх төрийн механизмын салшгүй нэг хэсэг нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, нийгмийн дэг журмыг хангах төрийн үйл ажиллагаа нь улс орныхоо тусгаар тогтнолын баталгаа болдог⁵¹ байна. Энэ нь улам нарийсаад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх Засгийн газрын, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын чиг үүрэг болж тус тус задарна.

”Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь хэрхэн улс орны тусгаар тогтнолын баталгаа болох талаар “Нийгмийн дэг журам оршин тогтнох нь” нийтлэлд⁵² ойлгомжтой тайлбарлажээ. Тухайлбал, “... Нийгэм дэг журамтай байх нь сайн хуультай, түүнийг бүгд сахихаас гадна нийтийн үйлчилгээний хүртээмж ба чанар, аюулгүй байдлын баталгаанаас ... ихээхэн хамаарч ... байдаг. Нийгмийн дэг журмыг хангахын тулд хуулиа сахиулж, шударга ёсыг тогтоох учиртай”.

Хууль бол шударга ёсыг тогтоох явдал. Шударга бус ёс үгүй болсон цагт л шударга ёсонд хүрдэг юм⁵³.

Тэгэхээр хүн бүр (цагдаагийн алба хаагч өөрсдөө багтана) өдөр тутмын амьдралдаа, бас алба хаагч нь албан үүргийнхээ хувьд дагаж сахих ёстой хэм хэмжээг биелүүлж, хэрэгжүүлж, тэрхүү хэм хэмжээг зөрчсөн хүн, албан хаагчтайгаа шударгаар хариуцлага тооцож чадаж байж нийгмийн дэг журмыг хангах төдийгүй улс орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах болно.

Энэ зүйлд заасан цагдаагийн албаны чиг үүргийг хууль тогтоогч энэ хуулийн хоёрдугаар бүлэгт задалж хуульчилсан тул дэлгэрэнгүйг тухайн бүлгийн 10-19 дүгээр зүйл, ялангуяа 10, 11, 12 дугаар зүйлийн тайлбараас үзнэ үү.

⁵¹ Совд Г, Жанцан Н, Амарсанаа Ж, Жанцан С нар., Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000, 61 дэх тал.

⁵² Жаргалсайхан Д., Нийгмийн дэг журам оршин тогтнох нь. УБ., The De facto Gazette, 2018, №63

⁵³ Фредрек Бастиа. Хууль, УБ., 2001, 31 дэх тал.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Докторант, цагдаагийн
дэд хурандаа Б.Баянмөнх
*Дотоод хэргийн их сургууль,
Монгол Улс Цахим шуудан:*
bayanmunkh@uia.gov.mn

Товчлол. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил бөгөөд энэхүү үүргийг засаг захиргааны анхан шатны нэгж хороон дээр зохион байгуулдаг албан тушаалтан бол хэсгийн байцаагч юм. Энэхүү өгүүлэлд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны хамрах хүрээний талаар товч авч үзлээ.

Түлхүүр үг: хэсгийн байцаагч, үүрэг, эрх зүйн зохицуулалт,

Үндсэн хэсэг. Цагдаагийн хэсгийн байцаагч нь ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд харьяалагддаг бөгөөд энэ албаны зорилго, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээнээс хамаарч түүний гүйцэтгэх ажил, үүрэг нь тодорхойлогдоно.

Цагдаагийн байгууллагад үндсэн чиг үүргийг практикт хэрэгжүүлдэг албан тушаалын ижил зэрэгтэй алба хаагчид цөөнгүй байдаг. Жишээ нь эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, зохицуулагч, хэв журмын офицер гэх мэт. Дээрхи алба хаагчид тусгайлан зохицуулсан хуулийг мөрдлөг болгон үндсэндээ нэг л чиглэлийн үйл ажиллагаагаа явуулдаг үндсэн үүрэгтэй.

Хэсгийн байцаагч нь засаг захиргааны анхан шатны нэгж болох хороо хариуцан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьдаг, харьяалах хорооны иргэдийн гаргасан зөрчлийн тухай өргөдөл, гомдлыг хүлээн авч шалган шийдвэрлэдэг, олон талт үйл ажиллагаа явуулдаг онцлог бүхий албан тушаалтан юм.

Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2003 оны 06 сарын 03-ны өдрийн 229 дүгээр тушаалаар батлагдсан “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын 1.1-д “Цагдаагийн байгууллагын тухай хуулиар даалгасан гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх үүргийг хэрэгжүүлэхээр тодорхой нутаг дэвсгэрийн нэгжийг хариуцуулан Цагдаагийн төв байгууллагаас томилсон цагдаагийн алба хаагчийг хэсгийн байцаагч гэнэ”⁵⁴ гэж тодорхойлсон байдаг. Энэхүү тодорхойлолт нь хүчингүй болсон Цагдаагийн байгууллагын байгууллагын тухай

⁵⁴ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ.2008. 425 дахь тал

хууль дээр үндэслэж гаргасан тул тодорхойлолтыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай болсон байна.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн амжилтад хүрэх нөхцөл нь хариуцсан хэсгийнхээ өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг өдөр тутам мэдэж үнэлэн ажлаа төлөвлөх замаар албаны цагаа ашигтай зарцуулах, үйл ажиллагаандаа илүү тохиромжтой тактикийн аргыг сонгож хэрэглэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын туршлага, шинжлэх ухаан, технологийн ололтыг өргөнөөр нэвтрүүлэх, хамтран ажиллах зүй зохистой орчинг бүрдүүлэхэд оршино.⁵⁵

Цагдаагийн хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг эрх зүйн дараах эх сурвалжаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Цагдаагийн албаны тухай хууль;
- Хэсгийн байцаагчийн ажлын заавар;
- Албан тушаалын тодоройлолт.

Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хууль⁵⁶д заасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 11, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр 8, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 8, захиргааны хяналтын чиглэлээр 8 үүргийг хүлээдэг. Тэгвэл хэсгийн байцаагч нь цагдаагийн албаны тухай хуулиар хүлээсэн дээрхи 35 үүргийн 24 буюу 68.5 хувийг шууд хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд бусад 11 буюу 31.5 хувьд заасан үүргийг шууд гүйцэтгэдэггүй боловч шаардлага гарсан үед дэмжлэг үзүүлэх, хамтран оролцох замаар үүрэг гүйцэтгэж байна.

ЦЕГ-ын даргын 2003 оны 6-р сарын 3-ны өдрийн 229 дүгээр тушаалаар батлагдсан “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”⁵⁷-ын 6-р хэсэгт 4 үндсэн чиглэлээр нийт 34 үүргийг хэсгийн байцаагчийн үндсэн үүрэг хэмээн тусгажээ. Уг зааврыг 2017 онд шинэчлэгдэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлэн шинэчлээгүй ч хүчин төгөлдөр мөрдөж байна.

“Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг Цагдаагийн байгууллагын тухай хуучин хуульд нийцүүлэн боловсруулсан боловч уг зааврын 11 заалтын агуулгыг харвал хэрэгжүүлэх боломжгүй юм. Тухайлбал, уг зааврын 6.2, 6.4, 6.5, 6.12-6.17, 6.25, 6.26, 6.28⁵⁸-т заасан үүргүүд байна. Уг үүргүүдийн агуулгыг авч үзвэл:

- хойшлуулшгүй ажиллагааг ЦБТХ-ийн 24-р зүйл, ЭБШХ-ийн 172-р зүйлийг үндэслэн явуулах;
- нууц, далд аргаар үйлдэгдсэн эзэнгүй гэмт хэргийг нөхөн илрүүлэх ажлыг бие дааж гүйцэтгэх, эрүүгийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулах;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, уг чиглэлээр сум, баг, хорооны Засаг дарга, Замын цагдаагийн албанд асуудал тавих;

⁵⁵ Ж. Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 112 дахь тал

⁵⁶ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

⁵⁷ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ.2008. 425-430 дахь тал

⁵⁸ Мөн бүтээл. 427-428 дахь тал

- мотоцикль болон тээврийн хэрэгслийг улсын техникийн үзлэг тооллогонд хамруулах, гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн талаарх хууль тогтоомж болон каратэ, самбо зэрэг зэвсэггүйгээр тулалдах арга /мэх/-ийн сургалт, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглагдаж байгаа өнгөт хувилагч болон тамга тэмдгийг бүртгэж хяналт тавих;
- шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял нь хойшлогдсон ялтны засрал хүмүүжилд болон хорих ял эдэлж суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тавих;
- нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч, туслах ажилтан (одоогийн хууль тогтоомжид байхгүй нэршлүүд)-г удирдлагаар хангаж ажлын үр дүнг тооцох;

Дээрхи үүргүүдэд хүчингүй болсон хуулийн зүйл, заалтыг дагаж мөрдөхөөр заасан, цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг хамааралгүй болсон үүрэг гүйцэтгүүлэхээр оруулсан, одоогийн хууль тогтоомжид байхгүй олон нийтийн байцаагч, туслах ажилтныг арга зүйн удирдлагаар хангах зэргийг үүрэг болгосон байна.

ЦЕГ-ын дэд даргын 2019 оны 6-р сарын 21-ны өдөр баталсан хэсгийн байцаагчийн “Албан тушаалын тодорхойлолт”-оор гурван зорилтын хүрээнд нийтдээ 20 үүргийг гүйцэтгэхээр тусгажээ. Гэхдээ 3-р зорилтын хүрээнд тусгагдсан гурван үүрэг нь үндсэн чиг үүрэгт хамаарахгүй, алба хаагчийн сахилга, ёс зүйтэй холбоотой үүрэг байна. “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ийн эрх зүйн чадамж тааруу болсон дутагдлыг албан тушаалын тодорхойлолт тодорхой хэмжээгээр нөхөж байна гэж хэлж болохоор байна.

1-р зорилт. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, үр дүнг тайлагнах. Энэ зорилтын хүрээнд нийтдээ 14 үүргийг хэсгийн байцаагч гүйцэтгэхээр заасан бөгөөд үүргийн агуулгыг багцлан авч үзвэл:

- гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулах шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг хангуулах, төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах;
- хуулиар харъяалуулсан зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авч шалгах, эргүүл хийх, найман хуулийн⁵⁹ хэрэгжилтэнд хяналт тавих, гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй сэжигтэй этгээд, газар орныг хяналтад авах;
- Цагдаагийн албаны тухай хуулийн 13.1.4-13.1.6⁶⁰-д заасан захиргааны хяналт тавих, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй болон хорих ял эдлээд суллагдсан зарим хүмүүст захиргааны хяналт тавих;
- олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд оролцох;

⁵⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Галт зэвсгийн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль

⁶⁰ Төрийн мэдээлэл. 2017.№8. Цагдаагийн албаны тухай хууль

- олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, объектын судалгаа хийх, удирдлагаас гаргасан шийдвэр, үүргийг хэрэгжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах.

Дээрхи үүргүүд нь агуулгын хувьд давхардсан, зарим үүрэг харьяаллын бус байна. Тухайлбал, 1.1, 1.11, 1.14 заалтууд нь урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахтай, 1.3, 1.12, 1.13 заалтууд нь эргүүлийн үйл ажиллагаа явуулах, 1.4, 1.5, 1.7 заалтууд захиргааны хяналтын үүрэг гүйцэтгэхтэй холбоотой байна.

2-р зорилт. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах.

Энэ зорилтын хүрээнд гурван үүргийг хэсгийн байцаагч гүйцэтгэхээр заасан нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр баг, хорооны Засаг даргатай хамтран ажиллах, ГХЗУСА33-ийн үйл ажиллагаанд оролцох, иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авах, тайлан тавих, Засаг даргын гаргасан захирамжийг хэрэгжүүлэхэд оролцох, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багт ажиллах агуулгатай байна. Дээрхи үүргүүд нь агуулгын хувьд хооронд мөн давхардсан байна. Тухайлбал, 2.1, 2.2, 2.3 заалтууд 1-р зорилтын 1.1, 1.11, 1.14 заалтуудтай агуулгын хувьд давхацжээ. Тиймээс “Албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулах шаардлага тулгарсан байна.

Хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан тодорхойлж өгсөн “Хэсгийн байцаагчийн ажлын заавар” болон “Албан тушаалын тодорхойлолт”-д заагдсан үүргүүдэд дүн шинжилгээ хийж үзвэл хэсгийн байцаагчийг олон талт үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлжээ. Цагдаагийн хэсгийн байцаагчийн гүйцэтгэж байгаа ажил үүргийг хуульд заасан байдлаар нь авч үзвэл:

Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:

1. Баг, хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч болон мөрдөгчдийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, түүнийг арилгуулах зорилгоор бичсэн мэдэгдэлийн хэрэгжилтэнд хяналт тавих.
2. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, холбогдох албан тушаалтанд мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах.
3. Хариуцсан баг, хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, нотлох баримт цуглуулах, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, баривчлах.
4. Хуулиар харьяалуулсан зарим гэмт хэрэгт хэрэг бүртгэлт явуулах.
5. Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий эрүүгийн цагдаагийн алба болон бусад байгууллагатай хамтран ажиллах.
6. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах.
7. гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн талаархи мэдээллийг нэгдсэн санд оруулах.

8. Хариуцсан хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн болон үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, түдгэлзүүлсэн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч нартай хамтран ажиллах.
9. Хариуцсан баг, хорооны нутаг дэвсгэрийн объектын болон субъектын судалгааг хийх.
10. Хариуцсан баг, хороонд оршин суудаг мансуурах, согтуурах донтой этгээдийг албадан эмчилгээнд материалжуулан хүргэх.
11. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг материалжуулан шүүхээр шийдвэрлүүлэх.

Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр:

1. Хэсгийн байцаагч өөрийн хариуцсан баг, хорооныхоо гудамж талбай, үзвэр үйлчилгээний газар, нийтийн тээврийн буудал, орон сууц зэрэг олон нийтийн эзэмшлийн газарт хууль тогтоомжоор болон төрийн эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмын хэрэгжилтэнд хяналт тавих, эргүүл хийх.
2. Хариуцсан нутаг дэвсгэрт гарсан зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, холбогдох байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах.
3. Шалгаж шийдвэрлэсэн гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээллийг нэгдсэн санд оруулах.
4. Баг, хороонд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.
5. Хариуцсан баг, хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн этгээдүүдэд хяналт тавих.
6. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.
7. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар очиж хүчирхийллийг таслан зогсоох, хүчирхийлэгчийг албадан саатуулах, хохирогчийг хамгаалах байранд хүргэж өгөх, шүүхэд эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах, хүчирхийлэл үйлдэгчид хяналт тавих.
8. Хариуцсан хорооны нутаг дэвсгэрт байгаа хараа хяналтгүй хүүхдийг асран хамгаалах байгууллагад болон нийгийн халажийн үйлчилгээнд хамруулах.
9. Баг, хорооныхоо нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын аюулгүй байдлыг хангаж байгаа гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих.
10. Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах.
11. Хариуцсан баг, хороонд ажиллаж байгаа олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр:

1. Жагсаал, цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах ажиллагаанд оролцох.
2. Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн үед хорио цээрийн дэглэмийг сахиулах ажиллагаанд оролцох.
3. Нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үеийн хамгаалалтанд оролцох.

Захиргааны хяналтын чиглэлээр:

1. Хариуцсан баг, хороонд оршин суудаг иргэн, үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, ашиглах журмын биелэлтэд хяналт тавих.
2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх.
3. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах, хэн болох нь тогтоогдоогүй цогцсыг таниулах ажиллагаа явуулах.
4. Архидан согтуурахтай тэмцэх тухай, Тамхины хяналтын тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих зэрэг үүрэг гүйцэтгэж байна.

Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийн 68.5 хувьд хэсгийн байцаагч оролцож байгаа нь түүний үүрэг оролцоог тодорхойлох нэг хүчин зүйл болж байна. Цагдаагийн албаны тухай хуульд заагаагүй боловч бусад хууль тогтоомжоор цагдаагийн байгууллагад үүрэг болгосон ажил, арга хэмжээнд хэсгийн байцаагч оролцдог болохыг нэмж хэлэх хэрэгтэй.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн хийх ёстой нэг үндсэн ажил бол объектын болон субъектын судалгаа бөгөөд энэхүү судалгаан дээрээ үндэслэн цаашид хийх урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээнийхээ чиглэлийг тодорхойлдог. Гэмт хэргийн нэг гол шалтгаан, нөхцөл болж байгаа архидан согтуурах явдалтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хариуцлагыг чангаруулах, биеэ үнэлэх явдлыг таслан зогсоох, РС-цахим тоглоомд донтогчдыг илрүүлэх, дээрх чиглэлээр гарсан төр захиргааны байгууллагуудын захирамж, шийдвэрийн биелэлтийг хангахад хэсгийн байцаагч оролцдог.

Иргэдтэй хамгийн ойр ажилладаг хэсгийн байцаагчийн ажлын үр дүнгээр цагдаагийн байгууллагын болон нийт албан хаагчдын ажлыг үнэлэх хандлага олон нийтийн дунд их байдаг. 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар Нийслэлийн 1 хороонд дунджаар 8648 хүн амьдарч оршин сууж байна. 641-1990 хүртэл хүн амтай 3, 2104-өөс 3353 хүн амтай 2, 3354-өөс 4328 хүн амтай 4, 4329-өөс 5029 хүн амтай 9, 5030-аас 6025 хүн амтай 15, 6026-аас 7033 хүн амтай 18, 7034-өөс 8064 хүн амтай 20, 8065-аас 9010 хүн амтай 20, 9011-ээс 10009 хүн амтай 11, 10010-аас 11024 хүн амтай 8, 11025-аас 12209 хүн амтай 13, 12210-аас 13381 хүн амтай 8, 13382-оос 14042 хүн

амтай 4, 14043-аас 15646 хүн амтай 4, 15647-оос 16668 хүн амтай 6, 16669-өөс 17125 хүн амтай 1, 17126-аас 18833 хүн амтай 4, 18834-өөс дээш хүн амтай 1 хороо байна. Багануур дүүргийн 2 хороо хамгийн бага хүнтэй бөгөөд тэнд 215 өрхийн 641 хүн оршин сууж байжээ.⁶¹

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэсгийн байцаагчийн үүрэг ямар байгааг сүүлийн таван жилийн байдлаар авч үзлээ. Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд хүн амын тоо, түүний өсөлт их нөлөө үзүүлнэ. Монгол Улсын хүн ам 2010 онд 2.761.0 байсан бол 2015 онд 2995.8 мянга болж, хүн амын өсөлтийн хувь 2.2% болж байна.

Хүн амын өсөлтийг сүүлийн 8 жилийн дунджаар авч үзвэл жилд дунджаар 76001 хүнээр өссөн гэсэн судалгаа гарч байгаа нь жилд дунджаар 1 дүүргийн хэмжээний хүн Монгол Улсад нэмэгдэж байна гэсэн үг юм.

Хүснэгт №1

Дүүрэг	Хүн ам 2018 он /мян/	Хүн ам 2025 он	Жилийн өсөлтийн дундаж хувь
Сонгинохайрхан	321.2	547.8	5.16%
Чингэлтэй	157.3	229.0	3.03%
Сүхбаатар	145.3	197.7	2.95%
Баянгол	226.9	254.8	2.39%
Хан-Уул	178.9	248.2	5.56%
Баянзүрх	343.6	700.0	6.36%
Налайх	37.6	47.3	3.05%
Багануур	29.5	33.0	2.63%
Багахангай	4.4	5.9	1.0%
Улаанбаатар	1444.7	2.262.1	4.59%

Үүний нэг тод илрэл замын хөдөлгөөний түгжрэл, бага насны хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа, ерөнхий боловсролын сургуульд гурван ээлжээр суралцаж байгаа, нийслэлийн төлөвлөлт алдагдсан, нийслэлийн хэмжээнд бохир усны цэвэрлэх байгууламж ачааллаа дийлэхээ байсан, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал улам хүндрэх төлөв байдал ажиглагдаж байгаагаас харж болохоор байна. Хүн амын нягтрал их байх тусам гэмт хэрэг, зөрчил гарах нөхцөл нэмэгдэх нэг хүчин зүйл болдог.

Нийслэлийн хорооны тоо нь 1993 оноос 2011 оны хооронд дөрвөн удаа өөрчлөгджээ.

Хүснэгт №2


Дүүрэг	Хорооны тоо			
	1993 он	2001 он	2007 он	2011 он
Багануур	3	4	4	5
Багахангай	2	2	2	2
Баянгол	19	20	20	23
Баянзүрх	20	20	24	28

⁶¹ Архивын баримт бичгээс.

Налайх	5	6	6	7
Сонгинохайрхан	21	21	25	32
Сүхбаатар	16	16	18	20
Хан-Уул	13	14	14	16
Чингэлтэй	18	18	19	19
Бүгд	117	121	132	152

Тиймээс хүн амын тоо, шилжилт хөдөлгөөн нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх нэг хүчин зүйл болдог учир 2012-2017 онуудын нийслэлийн хүн амын статистик тоо мэдээнд тулгуурлан харьцуулалт хийж үзлээ.

График №1



Дээрхи графикт орсон зургаан жилийн дунджаар авч үзвэл Улаанбаатар хотод 66.7 мянган иргэн нийслэлийн засаг захиргааны анхан шатны хороонд бүртгэлгүй оршин сууж байгаа нь хэсгийн байцаагчийн урьдчилан сэргийлэх ажил явуулахад хүндрэл бий болгодог байна.

Нийслэлийн хүн амын тоо, гэмт хэрэг, зөрчлийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэхгүй байгаагаас цагдаагийн хэв журмын хүч хэрэгсэл дутагдах хүндрэлтэй байдал үүсэхээр байна. Нийслэлийн цагдаагийн газар болон харьяа дүүргүүдийн цагдаагийн хэлтэст нийт 2854 алба хаагч ажиллаж байгаагийн 424 нь захиргаа удирдлага, 886 нь гэмт хэрэгтэй тэмцэх, 1544 нь нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр гүйцэтгэж байна.

2019 оны байдлаар нийслэлийн хүн ам 1444.7⁶² болж өссөн бөгөөд үүнийг хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагч нарын тоотой харьцуулбал хэв журмын нэг алба хаагчид дунджаар 9357 хүн ногдож байгаа нь ажлын ачааллыг үнэлэх нэг шалгуур болж байна.

Нийслэлийн цагдаагийн газрын харьяа хэсгийн байцаагч нарын сүүлийн таван жилд хийсэн ажлын тоо мэдээг нэг алба хаагчид ноогдох дундаж үзүүлэлтээр нь харьцуулан авч үзвэл:

⁶² <http://ubstat.mn/StatTable=11>

Хүснэгт №3

№	Хэрэгжүүлсэн ажил		2015 он		2016 он		2017 он		2018 он		2019 он	
			154 хэсгийн байцаагч	хэсгийн байцаагч /дунджаар/	154 хэсгийн байцаагч	хэсгийн байцаагч /дунджаар/	154 хэсгийн байцаагч	хэсгийн байцаагч /дунджаар/	154 хэсгийн байцаагч	хэсгийн байцаагч /дунджаар/	154 хэсгийн байцаагч	хэсгийн байцаагч /дунджаар/
1.	Илрүүлсэн хэрэг		14840	96.3	11100	72	807	2.78	798	5.1	1202	7,8
2.	Таслан зогсоосон гэмт хэрэг		Шинээр нэмсэн шалгуур								60	0,38
3.	Хариуцсан нутаг дэвсгэрийн судалгаа болон Patrol сангийн ашиглалт		34028	220.96	30468	197.8	31256	107.7	48167	312.7	Хасагдсан	
4.	Судалгаа хяналтын санд байжилт хийсэн байдал /Цахим сан/	Объект	Шинээр нэмсэн шалгуур								10067	65,3
5.		Субъект	Шинээр нэмсэн шалгуур								21217	137,7
6.	Зөрчлийн талаарх хүлээн авч шалгасан, шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл		36510	237	34884	226.5	41654	142.9	34460	223.7	42888	278,4
7.	Эрүүгийн хэрэг үүсгэсэн		1385	8.9	846	5.5	1766	6	5970	38.7	6006	3,9
8.	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан		5142	33.3	3723	24.1	6718	23.1	18629	120.9	28427	184,5
9.	Харьяаллын дагуу шилжүүлсэн		219	1.4	184	1.19	1303	4.4	1221	7.9	991	6,4
10.	Хөөн хэлэлцэх хугацаа зогсоосон		51	0.33	805	5.2	675	2.3	362	2.3	Хасагдсан	
11.	Хөөн хэлэлцэх хугацаа зогсоосон материалаас шийдвэрлэсэн		22	0.14	118	0.76	116	0.4	72	0.46	Хасагдсан	
12.	Захиргааны зөрчлийг материалжуулан шалгасан		21456	139.3	20384	132.3	31339	108	24282	157.6	8185	53,1
13.	Захиргааны журмаар түр хураагдсан эд зүйлсийг санд шивж бүртгүүлсэн		416	2.7	11894	77.2	10361	35.7	1982	12.8	Хасагдсан	
14.	Эрэн сурвалжилсан	Оршин суугаа газраас сураггүй алга болсон хүн, оргодлууд	68140	442.4	30620	198.8	3870	13.3	6208	6208	1415	9,18
15.		эд зүйл	736	4.7	1962	12.7	1004	1004	778	778	858	5,5
16.		галт зэвсэг	140	140	220	1.42	32	32	3	3	42	0,2
17.		мал	440	440	640	4.15	29	29	294	294	88	0,57
18.		тээврийн	64	64	20	0.12	60	60	54	54	20	0,12

		хэрэгсэл										
19.		Шүүхийн эрэн сурвалжлалт	Шинээр нэмсэн шалгуур								4373	28,3
20.		Үүнээс олж тогтоосон									784	5,09
21.		Мөрдөн шалгах ажиллагаанаас оргосон хүн									81	0,52
22.		Хэн болох нь тогтоогдоогүй цогцос									5	0,03
23.		Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэн, аж ахуй нэгж байгууллагатай хамтран зохион байгуулсан ажил	87060	565.3	34660	225	9901	34.1	10641	69.09	Энэ заалт ГХУСА-н төрлөөр 3 болж задарсан	
24.		Ерөнхий арга хэмжээ /ГХУС тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дах заалт/	Шинээр нэмсэн шалгуур								3048	19,7
25.		Тусгайлсан арга хэмжээ /ГХУС тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах заалт/	Шинээр нэмсэн шалгуур								3210	20,8
26.		Нэг бүрчилсэн /ГХУС тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалт/	Шинээр нэмсэн шалгуур								5204	33,7
27.		Олон нийтийн цагдаагийн ажилтанг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажилласан	49625	322.2	10402	67.5	11042	38	9820	63.7	12740	82,7
28.		Гадаад, дотоод орчинд телекамерын хяналт тавиулсан /гэрэлтүүлэг/	3393	22	4785	31	8253	28.4	9088	59.01	Хасагдсан	
29.		Шинэлэг ажил санаачилж нэвтрүүлсэн	Шинээр нэмсэн шалгуур								271	1,75
30.		Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар очиж ажилласан тоо	12549	81.4	10929	70.9	7102	24.4	9832	63.8	Хасагдсан	
31.		Хэдэн хүчирхийлэгчийг албадан саатуулсан	3480	22.5	3546	23	2903	10	2721	17.6	Хасагдсан	
32.		Хохирогчийг хамгаалах байранд хүргэж өгсөн тоо	236	1.53	147	0.95	552	1.9	297	1.9	Хасагдсан	
33.		Шүүхэд эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргасан тоо	216	1.4	168	1.09	129	0.4	240	1.55	Хасагдсан	
34.		Хүчирхийлэл үйлдэгчид хяналт	5664	36.7	8388	54.4	5644	19.4	5370	34.8	Хасагдсан	

	тавьсан тоо /бусад байгууллагатай хамтарсан/												
35.	хараа хяналтгүй хүүхдийг асран хамгаалах байгууллагад болон нийгийн халамжийн үйлчилгээнд хамруулсан байдал		1227	7.96	705	4.57	777	2.6	629	4.08	Хасагдсан		
36.	Жижүүрт хонож ажилласан бүрт		Шинээр нэмсэн шалгуур								2242	14,5	
37.	Шүүхээр баривчлуулсан хүн		8435	54.7	7405	48	3594	12.3	263	1.7	2924	18,9	
38.	Сайн дурын эмчилгээнд хамруулсан		534	3.46	167	1,08	315	1.08	1650	10.7	937	6,08	
39.	Архины албадан эмчилгээнд хүргүүлсэн		2966	19.2	1434	9.31	398	1.3	256	1.66	414	2,6	
40.	Гэмт хэргийн талаар бичсэн илтгэх хуудас		8330	54	4265	27.6	2369	8.1	674	4.3	1901	12,3	
41.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан		792	5.1	402	2.61	1490	5.1	2090	13.5	Хасагдсан		
42.	Эргүүл ажиллуулсан байдал	Хэв журмын урамшилт эргүүл, жижүүрээр ажиллуулсан	Шинээр нэмсэн шалгуур								9903	64,3	
43.		Оюутны эргүүл	Шинээр нэмсэн шалгуур								3978	25,8	
44.		Нийтийн эргүүл	Шинээр нэмсэн шалгуур								11056	71,7	
45.		Сургуулийн эргүүл	Шинээр нэмсэн шалгуур								20115	130,6	
46.	Хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн этгээдүүдэд тавих хяналт		11329	73.5	289 8	18.8	872 0	30	1925	12.5	Хасагдсан		
47.	Мэдэгдэл, зөвлөмж өгч, дүнг тооцсон байдал		15231	98.9	12213	79.3	29768	102.6	4074	26.4	62238	404,1	
48.	Торгууль	Хүн	Тасалбараар	12380	80.3	939 4	61	27912	181.2	3952	25.6	10856	70,4
49.		20000 төгрөг тутамд		114,8 сая	74567 5.3	703 495 00	45681 4.9	657 160 77	22660 7	12104 15662	785 984 1	Торгуулийн дүнг нэгтгэсэн	
50.		А.а.н. байгууллага		1437	9.3	568	3.68	480	1.6	322	2.09	101 8	6,6
51.		Албан		116	0.75	232	1.5	143	0.49	58	0.37	Хассан	

52.	тушаалтан											
	иргэн		7095	46	798 2	51.8	14257	49.1	4575	29.7		
53.	төгрөг		245,2 сая	1,6 сая	26.1 сая	16966 2.3	236. 6 сая	81588 9	473.6 сая	307 529 9	1.41 8.6 сая	921 213 0
54.	Саатуулах байранд хүргэж өгсөн		3236	21	236 9	15.3	775 2	26.7	4228	27.4	650 6	42,2
55.	Хэргийн газрын хамгаалалт		2025	13.1	183 4	11.9	415 0	14.3	4100	26.6	349 3	22,6
56.	Эргүүл, хамгаалалтанд ажилласан		6316	41	415 9	27	21708	74.8	10331	67.08	13388	86,9

Дээрхи хүснэгтэд орсон тоо мэдээнд дүн шинжилгээ хийж үзвэл 2015-2018 оны хооронд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа хэсгийн байцаагч нь нийтдээ 34 чиглэлийн ажил, арга хэмжээгээ дүн мэдээнд оруулж тооцуулж ирсэн байна. Хэсгийн байцаагч нарын хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээнүүдийг 5 жилийн дунджаар авч үзвэл дараах ажил, арга хэмжээг зонхилон хийж гүйцэтгэж байгааг харж болохоор байна. Тухайлбал:

Хүснэгт №4

№	Хэрэгжүүлсэн ажил	154 хэсгийн байцаагч		Нэг хэсгийн байцаагч	
		5 жил	1 жил	1 жил	1 сар
1.	Зөрчлийн талаарх хүлээн авч шалгасан, шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл	190396	38080	2472	224
2.	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	62639	12528	813	74
3.	Захиргааны зөрчлийг материалжуулан шалгасан	105646	21130	1372	124
4.	Эрэн сурвалжилсан /хүн, мал, эд зүйл, тээврийн хэрэгсэл, цогцос/	122980	24596	1597	145
5.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэн, аж ахуй нэгж байгууллагатай хамтран зохион байгуулсан ажил	153724	30745	1996	181
6.	Олон нийтийн цагдаагийн ажилтанг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажилласан	93629	18725	3745	340
7.	Гадаад, дотоод орчинд телекамерын хяналт тавиулсан /гэрэлтүүлэг/	25519 /4 жил/	6380 /4 жил/	41 /4 жил/	4 /4 жил/
8.	Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар очиж ажилласан тоо	40412 /4 жил/	10103 /4 жил/	65,6 /4 жил/	6 /4 жил/
9.	Шүүхээр баривчлуулсан хүн	22621	4524	31	3
10.	Сайн дурын болон албадан	9071	1814	12	2

	эмчилгээнд хамруулсан				
11.	Хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн этгээдүүдэд тавих хяналт	24872 /4 жил/	6218 /4 жил/	40 /4 жил/	4 /4 жил/
12.	Мэдэгдэл, зөвлөмж өгч, дүнг тооцсон байдал	123524	24705	1604	145
13.	Торгууль				
	Иргэн, албан тушаалтан	98952	19790	1285	116
	Аж ахуйн нэгж, байгууллага	3825	765	5	1
	Мөнгөн дүн	2400168100	480033600	3117100	310700
14.	Хэргийн газрын хамгаалалт	15602	3120	20	2
15.	Эргүүл, хамгаалалтанд ажилласан	55902	11180	725	7

Дээрхи судалгааны дүнгээс харвал нэг хэсгийн байцаагч сард дунджаар зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол 224 хүлээн авч, эрүүгийн хэргийн шинжтэй 74 материал шалгаж /татгалзсан/, 124 зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 145 хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг эрэн сурвалжилж, 181 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, харьяалах олон нийтийн цагдаагийн ажилтанд 340 удаа мэргэжил, арга зүйн заавар зөвлөмж өгч, удирдлагаар хангаж ажилласан байна.

Түүнчлэн хэсгийн байцаагч нэг сард дунджаар 145 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд мэдэгдэл, шаардлага, зөвлөмж өгч, 4 камер, гэрэлтүүлэг тавиулах ажлыг зохион байгуулж ажиллахын зэрэгцээ 2 удаа хэргийн газрын хамгаалалтанд, 7 эргүүл, хамгаалалтад ажиллаж, 117 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад гаргасан зөрчилд нь торгууль ногдуулдог гэсэн судалгааны дүн гарч байна. Энхүү судалгаагаар нэг хэсгийн байцаагч сард 3 иргэнийг шүүхээр баривчлуулж, 2 иргэнийг сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулдаг нь цөөн тоотой харагдаж байгаа хэдий ч цаг их зарцуулж хэрэгжүүлдэг ажил, арга хэмжээ юм. Хэсгийн байцаагчийн нэг сард хийж гүйцэтгэсэн ажил арга хэмжээ нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд түүний гүйцэтгэх үүргийг илэрхийлэх нэг шалгуур гэж үзэж болно.

Цагдаагийн байгууллага 2019 онд 58234 иргэн, 994 хуулийн этгээдийг 18327306.9 төгрөгөөр торгож, 28515 иргэний зарим эрхийг хасч, 15296 иргэнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулсан байна. Харин НЦУГ-ын харьяа хэсгийн байцаагч нар 1202 гэмт хэрэг илрүүлж, 60 гэмт хэргийг таслан зогсоож, зөрчлийн талаарх 42888 гомдол, мэдээлэл хүлээн авч, 8185 зөрчлийг материалжуулан шалгасан байна.

Хэсгийн байцаагчид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 11462 иргэн, аж ахуй нэгж байгууллагатай хамтран ажил арга хэмжээ зохион байгуулж, 62238 мэдэгдэл, зөвлөмжийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад өгч, үр дүнг тооцож ажилласаны зэрэгцээ 1351 иргэнийг сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулж ажилласан байна. Түүнчлэн 6506 иргэнийг саатуулах байранд

хүргэж, 3493 хэргийн газрын хамгаалалтад ажиллаж, 13388 эргүүл, хамгаалалтад ажилласан нь НЦГ-ын харьяа хэсгийн байцаагчдын үүрэг оролцоог тодорхойлж буй нэг үзүүлэлт болж байна.

Цагдаагийн байгууллагад иргэдээс ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо мэдээлэлд сүүлийн таван жилийн байдлаар /2015-2019/ судалгаа хийхэд нийт 154924 гэмт хэрэг, 7662158 зөрчил бүртгэгдэж шалган шийдвэрлэгдсэн байна. Харин Нийслэлийн цагдаагийн газрын харьяа хэсгийн байцаагчид таван жилийн хугацаанд 15973 гэмт хэрэг буюу 10.3%, 190396 зөрчил буюу 2.4%-ийг тус тус шалган шийдвэрлэсэн нь түүний үүрэг оролцоог илэрхийлэх нэг үзүүлэлт болж байна.

Сүүлийн есөн жилийн дунджаар цагдаагийн хэсгийн байцаагч нарын хийсэн зарим ажлыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №5

Он	Баривчилсан хүн	Эрүүлжүүлэгдсэн хүн	Сайн дурын эмчилгээнд хамруулсан хүн	Албадан эмчилгээнд хамруулсан хүн
2011	12380	115349	619	1836
2012	13888	118030	745	1435
2013	16505	123454	535	1216
2014	17090	119015	435	965
2015	13174	97560	359	624
2016	5380	87356	393	1148
2017	11345	86497	431	3099
2018	3352	28437	127	1249
2019	2924	6506	937	414
Дүн	96038	782204	4581	11986

Дээрхи есөн жилийн хугацаанд цагдаагийн байгууллагаас төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулан хяналт, шалгалт, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий 285, тусгай 798, нийт 1083 арга хэмжээг үе шаттайгаар явуулсан бөгөөд энэ бүх арга хэмжээнд цагдаагийн хэсгийн байцаагчид оролцсон байна. Учир засаг захиргааны анхан шатны баг, хороог хариуцсан цагдаагийн хэсгийн байцаагч нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэр дээр архи, согтууруулах ундаагаар үйлчилж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьдаг нь цагдаагийн байгууллагаас тавих захиргааны хяналтын үйл ажиллагаанд түүний оролцоог тодорхойлж байгаа нэг үзүүлэлт болж байна.

Нийслэлийн хэмжээнд тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран 1177 удаа сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, 140.700 хүн хамрагдсан байх бөгөөд энэхүү сургалтуудыг хэсгийн байцаагчид өөр өөрийн хариуцсан нутаг дэвсгэр дээрээ зохион байгуулсан байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд манай улсад зохион байгуулагдсан жагсаал, цуглааны байдалд судалгаа хийж үзэхэд: 2014 онд 115 удаагийн жагсаал, цуглааны үеийн хамгаалалт зохицуулалтанд давхардсан тоогоор 2617 цагдаагийн алба хаагч, 169 автомашинтайгаар 348 цаг, 2015 онд 140 удаагийн жагсаал, цуглааны үеийн хамгаалалтад давхардсан тоогоор 5026 цагдаагийн алба хаагч, 422 автомашинтайгаар 2740 цаг, 2016 онд 121 удаагийн жагсаал, цуглааны үеийн хамгаалалтад 2539 цагдаагийн алба хаагч, 208 автомашинтайгаар 1534 цаг, 2017 онд 128 удаагийн жагсаал, цуглааны үеийн хамгаалалтад 4818 цагдаагийн алба хаагч, 334 автомашинтайгаар 2416 цаг, 2018 онд 180 удаагийн жагсаал, цуглааны үеийн хамгаалалтад 7610 цагдаагийн алба хаагч, 668 автомашинтайгаар 3485 цагийн үүргийг тус тус гүйцэтгэж, нийт 140.000 гаруй иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Дүгнэлт. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад хэсгийн байцаагч чухал үүрэг оролцоотой бөгөөд түүний гүйцэтгэх үүргийг нарийвчлан тодорхойлох замаар үйл ажиллагааны хамрах хүрээг тодотгох шаардлагатай болжээ.

Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 11, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр 8, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 8, захиргааны хяналтын чиглэлээр 8 үүргийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд цагдаагийн хэсгийн байцаагч нь дээрхи 35 үүргийн 24 буюу 68.5% үүргийг өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт шууд хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд бусад 11 буюу 31.5%-д заасан үүргийг шууд гүйцэтгэдэггүй боловч шаардлага гарсан үед дэмжлэг үзүүлэх замаар хамтран оролцдог нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэсгийн байцаагчийн үүргийг тодорхойлох үзүүлэлт юм.

Хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан тодорхойлсон “Хэсгийн байцаагчийн ажлын заавар” болон “Албан тушаалын тодорхойлолт”-д заагдсан үүргүүдэд дүн шинжилгээ хийж үзвэл дээрхи хоёр эрх зүйн зохицуулалтаар хэсгийн байцаагчийг олон талт үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна. Түүнчлэн дээрхи эрх зүйн зохицуулалтанд тусгагдсан зарим үүрэг нь харьяаллын дагуу өөр байгууллага руу шилжсэн, зарим зүйл заалтад тусгагдсан үүргүүд нь агуулгын хувьд хоорондоо давхцсан, нэг агуулгатай үүргийг олон задалсан зэрэг нь “Хэсгийн байцаагчийн ажлын заавар” болон “Албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулах шаардлагатай болсоныг харуулж байна.

Хэсгийн байцаагч нь хариуцсан хороон дээрээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтэд түшиглэн зохион байгуулах, нутаг дэвсгэрийн судалгаа хийж, мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийх, иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хууль тогтоомжийн хүрээнд захиргааны хяналт тавих зэрэг Цагдаагийн албаны тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг хороон дээрээ зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьдаг гол албан тушаалтан мөн гэсэн дүгнэлтийг хийж байна.

Санал. Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. “Тодорхой нутаг дэвсгэр хариуцан хэсгийн байцаагчийн ажлын зааварт заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа Цагдаагийн төв байгууллагаас томилогдсон цагдаагийн алба хаагчийг хэсгийн байцаагч гэнэ” гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг хэсгийн байцаагчийн ажлын зааварт тусгаж өгөх.

2. Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх үүднээс багаар ажиллах арга барилын шинэ үзэл баримтлалын загварчлалыг гаргаж нэвтрүүлэх.

3. Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, удирдлага зохион байгуулалтанд зарчмын өөрчлөлтийг оруулсан “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг шинэчлэн боловсруулах.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧААС ЯВУУЛАХ ТОДОРХОЙ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

*ДХИС-н докторант,
ЦС-н ЦЭЗТ-н ахлах багш,
Цагдаагийн дэд хурандаа
Б.Цогтбаатар*

Товч агуулга. Энэхүү өгүүлэлд Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан цагдаагийн байгууллага, алба хаагчаас явуулах тодорхой ажиллагааны эрх зүйн зохицуулалт болон Эрүүгийн болон Зөрчлийн процессын хуульд заасан тодорхой ажиллагаануудаас ялгагдах зарим онцлогийн талаар товч авч үзлээ.

Түлхүүр үг:

- Цагдаагийн алба хаагч;
- Тодорхой ажиллагаа;

Үндсэн хэсэг. Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа” нь эрүү, зөрчлийн процессын хуульд заасан тодорхой ажиллагаануудаас ялгагдах онцлог, утга санааг ойлгох асуудал нь судалгааны бүтээлүүдэд тусгаагүй байгаа тул судлаачийн хувьд тодорхойлох шаардлага үүсэж байна. Тэгэхээр дараах хуулиудад заасан процессын шинжтэй заалтууд нь өөр хоорондоо ижил болон ялгаатай талыг гарган уг утгаар нь ойлгож байж үндэс суурь зөв тогтох юм. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хуулийн /цаашид ЦАТХ гэж товчлох/ 4 дүгээр бүлэгт заасан “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журам”⁶³ /шаардлага тавих, бичиг баримт шалгах, түр саатуулах, орон байр бусад газарт нэвтрэн орох, үзлэг хийх, эд зүйл баримт бичиг түр хураан авах, зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, эрэн сурвалжлах гэх мэт/

2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэг “Зөрчил шалган шийдвэрлэх тодорхой ажиллагаа явуулах журам”⁶⁴ /үзлэг хийх, хураан авах, битүүмжлэх, мэдүүлэг авах, мэдээлэл баримт бичиг гаргуулан авах, хэв хэлбэр авч шинжилгээ хийлгэх/

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар хэсэг “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах журам”⁶⁵ 22-27 дугаар бүлгүүд /хураан авах, үзлэг хийх, мэдүүлэг авах, шинжилгээ хийлгэх, туршилт, таньж олуулах гэх мэт/

Эдгээр зарим талаар ижил нэртэй, явагдах процесс нь ойролцоо арга ажиллагаануудын талаа та бүхэн тухайн салбарын хичээл бүр дээр заалгаж үзсэн

⁶³ Төрийн мэдээлэл. 2017. №8

⁶⁴ Төрийн мэдээлэл. 2017. №24

⁶⁵ Төрийн мэдээлэл. 2017. №23

байгаа боловч эдгээрийн ялгааг сайн гаргаж ойлгоогүйгээс практик хүндрэл учирч болох юм. Цагдаагийн албаны хуульд эдгээр ажиллагааг ямар нөхцөлд, хэрхэн бусад процесстой нөхцөлдөх болон ялгамжийн талаар зааж өгөөгүй байна.

Сүүлийн жилүүдэд буюу 2017-2020 онд хуульд заасан тодорхой ажиллагаа явуулсан асуудалтай холбогдон цагдаагийн ажилтнууд сахилын хариуцлага хүлээх мөн эрүүгийн хариуцлага хүлээх, хорих ял авч шоронд хүргэгдэх явдал нэмэгдэж байгаа нь Цагдаагийн ерөнхий газраас хийсэн судалгаагаар тодорхой харагдаж байна. Энэ нь нэг талаар 2002 оны Эрүүгийн хуульд Цагдаагийн ажилтан Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэгт шалгагддаг байсныг 2015 оны шинэ Эрүүгийн хуульд Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргээс гадна, цагдаагийн ажилтны хувьд хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр ял шийтгэх нийт 24 зүйл хэсгийг оруулж өгсөн байгааг анхаарахгүй байхын аргагүй юм шүү!!!

Онцлог: Цагдаагийн албаны тухай хуулийн хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журам”⁶⁶ бол НИЙТЛЭГ байдлаар бүх цагдаагийн алба хаагч нарт өдөр тутмын цагдаагийн үндсэн үүрэг хэрэгжүүлэх, зөрчил эсхүл гэмт хэрэг шалгахаас үл хамаарч уг гурван тохиолдолд зэрэгцээ, хосолсон, өмнөх болон дараагийн үе шатанд зэргээр тухайн өрнөж буй нөхцөл байдлаас хамаарч, сонгон хэрэглэгдэж, байнгын байдалтай явагдаж байдаг, нийтлэг бөгөөд туслах чанарын үүрэг гүйцэтгэдэг онцлогтой юм.

Мөн процессын шинжтэй 2 хуулийн ажиллагаанууд нь голчлон болж өнгөрсөн нөхцөл байдал дээр, яг тухайн хуульд заасан чиглэл бүхий ажиллагааг /гэмт хэрэг эсхүл зөрчил/, тухайн хуулийн зохицуулалтын дагуу явуулдаг нийтлэг шинжийг агуулдаггүй боловч нэг нь нөгөөдөө иш татсан хэлбэрээр зохицолддог байна.

Жишээ нь дээр авч үзэхэд: Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Дорж хариуцсан нутаг дэвсгэрт эргүүл хийх явцдаа /өдөр тутмын нийтлэг ажил/ шинээр нээгдсэн “Баялаг” нэртэй дэлгүүрт орж үзэхэд 8 нэрийн хүнс болон архи зарж байв. Дорж тухайн өглөөний рапорт дээр “.. 9 дэгээр хороонд 2 хүн архины хордлогоор нас барсан” тухай цахим сангийн мэдээлэлтэй танилцсан ба өмнө байгаагүй шинээр нээгдсэн Баялаг дэлгүүрийн архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг шалгаж үзэх дүгнэлт хийсэн байна. Үүнийг ЦАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан “үндэслэл бүхий сэжиг” гэж практик амьдралд ойлгох нь илүү дөхөм юм. Ингээд үндэслэл бүхий сэжгийн хүрээнд мөн ЦАТХ-н 27 дугаар зүйлийн 27.2-т заасан “Хуулийн этгээдийн баримт бичгийг шалгах” нэртэй тодорхой ажиллагааг явуулсан байна.

Баялаг дэлгүүрийн эзэн Цэцгээ гэгч “Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулах” тухай тусгай зөвшөөрлийг эхээрээ энэ байна, манайд канон байхгүй” гэх тул мөн зүйлд заасны дагуу баримт үйлдэж 72 цагийн хугацаатай эхээр нь ЦАТХ-ийн 30 дугаар зүйлд заасан “Эд зүйл баримт бичиг түр хураан авах” тодорхой ажиллагааны хүрээнд түр хураан авч эрх бүхий байгууллагаар

⁶⁶ Төрийн мэдээлэл. 2017. №8

шалгуулахад “манай зөвшөөрлийг хуурамчаар үйлдсэн байна” гэх хариу ирсэн байна.

Энэ нь Баялаг дэлгүүрийг “архи согтууруулах ундааг зохих зөвшөөрөлгүй худалдсан” зөрчлийнхөн хувьд Зөрчлийн тухай хуульд заасан тохирох зүйл хэсгээр шалган шийдвэрлэх шаардлага илрэн гарч буй учир зөрчлийн гомдол мэдээллийн бүртгэлд оруулан прокурорын хяналт дор Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан тодорхой ажиллагаа буюу дэлгүүрт үзлэг хийж архины тоо хэмжээ, хаяг шошго тогтоох, тэдгээр архийг битүүмжлэх, шинжилгээнд хүргүүлэх, дэлгүүрийн эзэн Цэцгээгээс зөрчлийн холбогдогчоор мэдүүлэг авах зэрэг тодорхой ажиллагаа явагдах юм. Гэтэл энэ зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дэлгүүрийн ажилчдын бичиг баримтыг үзэж шалгах зэрэг ЦАТХ-д 25-р зүйлд заасан “Хүний бичиг баримтыг шалгах” тодорхой ажиллагаа зэрэгцээ хэлбэрээр явагдаж байдаг онцлогтой.

Мөн хуурамчаар үйлдсэн тусгай зөвшөөрөл нь архи зарах эрх олгосон баримт бичиг тул Эрүүгийн хуулийн 23.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжийг агуулж байх тул гэмт хэргийн тоо бүртгэлд оруулан мөрдөгчид цохогдох ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу прокурорын хяналтын дор Мөрдөн шалгах ажиллагаа буюу Цэцгээгээс гэрч, сэжигтнээр мэдүүлэг авах, хуурамч гэх тусгай зөвшөөрөлд үзлэг хийх, уг зөвшөөрлийг эргэж олгохгүйгээр эд мөрийн баримтаар хураан авах, цаас хор гарын үсэг, тамга тэмдэг, бичиглэл онцлог тогтоох зэргээр шинжээч томилон хүргүүлэх, өөрөө хуурамч баримт үйлддэг эсэхийг тогтоохоор Цэцгээгийн гэрт үзлэг, нэгжлэг хийх зэргээр тодорхой төрлийн мөрдөн шалгах ажиллагаануудыг явуулдаг. Мөн энэ мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгч өнгөт хэвлэгч, хэвлэлийн эх бэлтгэл хийдэг газрын судалгаа хийж, дээрх тусгай зөвшөөрлийг хаана хийсэн байж болох газар орныг олж судлахаар, сэжиг таамгийн хүрээг багасгахын тулд ЦАТХ-д 37-р зүйлд заасан “Биечилсэн судалгаа”, мөн хуулийн 38-р зүйлд заасан “Эрэн сурвалжлах ажиллагаа” зэрэг тодорхой ажиллагааг зэрэгцээ хэлбэрээр явагдаж байдаг онцлогтой. Иймд сэдвийн тодорхойлолт хэсгийг дахин нягтлан үзээрэй.

Цагдаагийн албаны тухай хуулийн дараах нэр томъёог байна. Үүнд:

“гэмт хэрэгтэй тэмцэх”⁶⁷ гэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулахыг;

“нийтийн хэв журам хамгаалах” гэж гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хууль тогтоомж, нийгээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг сахиулах үйл ажиллагааг;

“олон нийтийн аюулгүй байдлыг хангах” гэж хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, улс орны эрх ашигт ноцтой хор уршиг, хохирол учруулж болзошгүй аюулыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг;

“үндэслэл бүхий сэжиг” гэж цагдаагийн алба хаагч өөрт ил болсон тодорхой үйл явдал, мэдээ баримт, тухайн нутаг дэвсгэрийн онцлог, гэмт хэрэг, зөрчлийн

⁶⁷ Төрийн мэдээлэл. 2017. №08.

гаралтын түвшин, сэжигтэй хүн, хуулийн этгээдийн байдал, үйл ажиллагаа зэргийг үнэлэн энэ хуульд заасан ажиллагааг гүйцэтгэх шаардлагатай гэх дүгнэлтэд хүрэх нөхцөл байдлыг;

“биеийн хүч хэрэглэх” гэж цагдаагийн алба хаагч өөрийн бие махбод, мэргэжлийн тусгай бэлтгэлийг ашиглан бусдын хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор биеэр хийх үйлдлийг хэлэхээр тус тус заажээ. Өөрөөр хэлбэл хуульд заасан тодорхой ажиллагаа явуулахдаа дээрх нэр томъёонд заасан утгыг баримтлан ажиллах шаардлагатай юм.

Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаанд тавигдах дараахи нийтлэг шаардлага тавигдаж байна. Үүнд:

- Хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах.
- Хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд арга хэмжээ авах болсон үндэслэл, шалтгааныг тухайн этгээдэд мэдэгдэж, авсан арга хэмжээтэй холбогдон хүн, хуулийн этгээдэд үүсэх эрх, үүрэг, өмгөөлөгч авах, өөрийнхөө эсрэг тайлбар, мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгөх.
- Баривчлагдсан, түр саатуулагдсан насанд хүрээгүй этгээдийн 18 насанд хүрсэн гэр бүлийн гишүүн, эсхүл төрөл садны хүнд энэ тухай мэдэгдэх.
- Бусад эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглоно.
- Үүргээ гүйцэтгэхдээ бусадтай хүндэтгэлтэй харьцаж, бусдыг үл тоосон, заналхийлсэн, доромжилсон үг хэллэг, үйл хөдлөл хэрэглэхгүй байж, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх.
- Үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн албан тушаал, цол, нэрийг хэлж, шаардсанаар өөрийн албаны үнэмлэхийг үзүүлэх.
- Албан үүргээ гүйцэтгэх үедээ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрэмт хувцас, албаны өрөө, тээврийн хэрэгсэлд дуу-дүрсний бичлэг хийх техник, хэрэгслийг суурилуулан ашиглаж болно.
- Хуульд заасан тодорхой ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу даруй хийж гүйцэтгэх ба хийгдэж буй хаагчийн ажиллагаа тус бүрийн хамрах хүрээ нь тухайн ажиллагааг хэрэгжүүлэх хуульд заасан үндэслэлээр хязгаарлагдана зэрэг шаардлагаар тодорхойлсон байдаг.

Цагдаагийн алба хаагчийн үндэслэл бүхий сэжиг нь хуульд заасан ажиллагааны явцад батлагдаагүй нь тухайн алба хаагчид хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

Хүн, хуулийн этгээдэд шаардлага тавих:

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээдэд тодорхой үйлдлээс татгалзах, эсхүл үйлдэл хийх шаардах,

- Нийтийн хэв журмыг зөрчсөн, зөрчиж болзошгүй согтуурсан, мансуурсан хүнийг олон нийтийн газрыг тодорхой хугацаанд орхин явахыг шаардах,
- Гэмт хэрэг, зөрчлийн ул мөрийг бэхжүүлэх, бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг хангах, тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнд учирсан саадыг арилгах зорилгоор хүнийг тодорхой байр, газрыг орхин явахгүй байх, эсхүл өөр газар шилжин байрлахыг шаардах,
- Гэмт хэрэг, зөрчлийн тухай гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай хуулиар хориглосноос бусад баримт эд зүйлийг гаргаж өгөхийг шаардаж болно.

Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь хоёр болон түүнээс дээш тооны хүнд шаардлага тавих тохиолдолд хүн тус бүрд хэлэх үүрэг хүлээхгүй. Цагдаагийн алба хаагчийн шаардлагыг тухайн хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.

Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаагийн шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, эсхүл хуулийн дагуу явуулж байгаа ажиллагаанд нь саад учруулсан бол албадан гүйцэтгэж, гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Тайлбар авах

“Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадна гэсэн хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хүнээс тайлбар авна”⁶⁸ гэсэн заалт нь Эрүүгийн болон Зөрчлийн процессын хуультай зөрчилдөж байгаа тул цаашид хуульд нэмэлт оруулж өөрчлөн найруулах шаардлага үүссэн.

Хүний бичиг баримт шалгах

Дараах тохиолдолд хүний нэр, хаяг, тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тодруулах зорилгоор бичиг баримтыг шалгана:

- Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн цаг хугацаанд тухайн газар, эсхүл түүний ойролцоо байсан, эсхүл гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл өгч чадна гэх үндэслэлтэй; /гэмт хэрэг зөрчлийн гэрчээс мэдүүлэг авахын өмнө байж болно/
- Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, завдсан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр төлөвлөж байгаа гэх үндэслэлтэй; /зөрчлийн холбогдогч болон гэмт хэргийн сэжигтэн яллагдагчийн бичиг баримт шалган тодруулж байж бусад ажиллагаа явах/
- Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн газар, хамгаалалтын бүсээс тээврийн хэрэгсэл, хүнийг гаргах, эсхүл нэвтрүүлэх; /хуульд заасан эрх бүхий албан тушаалтан хэргийн газарт нэвтрэх, бусад оролцогчийг ялган тогтоох, хамааралгүйг тусгаарлах, явуулах/
- Эрх нь хязгаарлагдсан, эсхүл албадлагын арга хэмжээ авагдсан хүн хүлээсэн үүргээ зөрчсөн гэх үндэслэлтэй;

⁶⁸ Төрийн мэдээлэл. 2017. №8

- Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан ирүүлэхээр даалгасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа гэх үндэслэлтэй; /сэрдэгдсэн гэрч буюу зөрчлийн холбогдогч/
- Хууль тогтоомжид заасны дагуу хамгаалалтад байгаа объектод нэвтрэх хүнийг бүртгэх;
- Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, химийн хорт бодист хордсоны улмаас өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон хүний нэр, хаягийг тогтоох; /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/
- Гэмт хэрэг, зөрчлийн газарт үйлдэл дээрээ баригдсан этгээдийн нэр, хаягийг тогтоох; /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/
- Хуульд заасан журмын дагуу тээврийн хэрэгслийг түр зогсоосон бол тээврийн хэрэгслийг жолоодож яваа хүний жолоодох эрхийн үнэмлэх, зөвшөөрлийг шалгах; /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/
- Хуульд заасан насны хязгаарт хүрсэн эсэхийг тогтоох зэрэг тохиолдолд бичиг баримт үзэж шалгана.

Шалгалтын хэлбэр нь:

- Нүүр болон нийтэд ил харагдах биеийн бусад хэсгийг хаасан зүйлийг авах, халхлах аливаа үйлдэл хийхгүй байхыг шаардах,
- Нэр, хаяг, зөвшөөрөл, бүртгэлийг шалгах, бичиг баримт нь гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан, эсхүл үйлдэх замаар олж авсан, эрэн сурвалжлагдаж байгаа эсэх талаар төрсөн үндэслэл бүхий сэжгийг тодруулах зорилгоор цахим сангаас болон бусад арга хэрэгслээр холбож шалгах.
- Шалгуулагчаас нэгээс хоёр алхмын зайтай зогсоож, ажиллагааг дуустал түүнийг гарын алгаа ил харагдахаар байрлуулж, тухайн газраас явахыг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагад очиж шалгуулах шаардлага тавьж болно.
- Шалгуулагч хүн бичиг баримтаа шалгуулах, эцэг, эхийн болон өөрийн нэр, төрсөн огноог хэлэх үүрэгтэй.

Хүний бичиг баримтыг шалгасан цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа шаардлагатай бол дараах ажиллагааг явуулна:

- Амиа хорлохыг завдсан, өөртөө болон нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй, эсхүл сэтгэцийн эмнэлгээс оргосон хүнийг эмнэлгийн байгууллагад хүлээлгэн өгөх; /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/
- Оргон зайлсан болон эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх баримт, үндэслэл бүхий сэжиг байгаа бол баривчлах, цагдаагийн байгууллагад хүргэх; /эрүүгийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/

- Хараа хяналтгүй, оршин суугаа газрын хаяг, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тодорхойгүй, эсхүл согтуурсан, мансуурсны улмаас өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй болсон хүнтэй хамт яваа бага насны хүүхэд, эрх зүйн чадамжгүй хүнийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх; /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/
- Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсний улмаас өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон хүнийг хамгаалах хүнд, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэлтэй бол холбогдох байгууллагад хүлээлгэн өгөх, эсхүл Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд заасан журмын дагуу арга хэмжээ авах; /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/
- Зөрчил үйлдсэн хүний нэр, хаяг тодорхойгүй бол нэр, хаягийг тогтоох, зөрчлийг шалгаж шийдвэрлэх зорилгоор түр саатуулах; /зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан ирүүлэхээр даалгасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд баривчлах, эсхүл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгөх; /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/
- Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн бол зөрчлийг газар дээр нь шалгаж шийдвэрлэх, эсхүл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллагад хүргэх;
- Зөрчлийг гарсан газарт нь шуурхай шийдвэрлэх боломжгүй, эсхүл хүний бичиг баримтыг шалгах болсон бусад үндэслэлийг тухайн газарт шалгаж тогтоох боломжгүй бол цагдаагийн байгууллагад хүргэх. /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/

Түр саатуулах

Гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүний нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно. /байранд хүргэснээс цаг тооцох, ар гэрт нь даруй мэдэгдэж тэмдэглэх, үндэслэл арилмагц суллах/, /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/ Практик дээр журам гарсан эсэх, хэрэгжилт, алдаа дутагдал ямар байгаад үнэлэлт өгч цаашид судлах шаардлагатай/

Хуулийн этгээдийн баримт бичиг шалгах

Хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа гэх үндэслэл байгаа эсхүл тийм гомдол, мэдээлэл хүлээн авсан бол баримт бичиг нь хууль ёсны эсэхийг шалгах, хуулбарлан авах, эх хувийг 72 цаг хүртэлх хугацаанд түр хураан авах зэргийг сонгон хэрэгжүүлж болно.

Цагдаагийн алба хаагч хуулийн этгээдийн баримт бичгийг биечлэн шалгах явцад дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд энэ хуульд заасан тодорхой ажиллагааг явуулна:

- Албадан ирүүлэхээр даалгасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүн тухайн хуулийн этгээдийн байр, агуулах сав, эзэмшил газарт байгаа гэх; /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/
- Хүний амь нас, эрүүл мэндэд шууд хохирол учруулах эд зүйл, эсхүл хуулиар хязгаарласан, хориглосон эд зүйлийг хууль бусаар хадгалсан, үйлдвэрлэсэн, худалдсан гэх; /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/

Орон байр, бусад газарт нэвтрэн орох

Цагдаагийн алба хаагч хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчил, тэдгээрийн талаарх гомдол, мэдээллийг шалгахдаа бусдын орон байр, тээврийн хэрэгсэл, ажлын байр, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, ач холбогдол бүхий баримт, мэдээллийг гаргуулан авах эрхтэй.

Доор дурдсанаас бусад тохиолдолд бусдын орон байранд оршин суугч, эзэмшигчийнх нь зөвшөөрөлгүйгээр нэвтрэн орохыг хориглоно:

- Гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн хүнийг мөрдөн хөөж баривчлах, эсхүл гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдал үүссэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа;
- Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодит аюул байгаа;
- Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хоригдлыг мөрдөн хөөж баривчлах;
- Сэжиг бүхий этгээд оргон зайлах, гэмт хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, үрэгдэх бодит аюул тулгарсан.

Дээрхээс бусад тохиолдолд цагдаагийн алба хаагч бусдын орон байранд нэвтрэн орохдоо оршин суугч, эзэмшигчийн зөвшөөрлийг заавал авсан байна. /дээрх 4 нь тохиолдол нь эрүүгийн процессын өмнө болон зэрэгцээ явагддаг/

Цагдаагийн албаны тухай хуулийн 28.4. “Тухайн орон байранд хамтран оршин суугч, эсхүл хамтран эзэмшигч этгээдийн аль нэг нь зөвшөөрөл өгсөн бол энэ хуульд заасан бусдын орон байранд нэвтрэх үндэслэл болно”, 28.5 “Орон байранд нэвтрэх зөвшөөрөл өгсөн этгээдийг оршин суугч, эзэмшигч биш гэж мэдэх боломжгүй байсан бол энэ хуулийн 28.2-т заасныг зөрчсөн гэх үндэслэл болохгүй” гэж заасан.

“Орон сууц”⁶⁹ гэж “хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

⁶⁹ Орон сууцны тухай хууль 3 дугаар зүйл.

Мөн Улсын дээд шүүхийн тогтоолд “орон байр”⁷⁰ гэдэгт “хүн байнга буюу түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно. Орон байр нь хөдөлгөөнтэй, түр шинжтэй байж болно” гэж зааж өгсөн.

“агуулах сав”⁷¹ гэдэг нь эд хөрөнгийг байнга буюу түр хадгалах зориулалттай байшин, пин, амбаар, илүү гэр, гэрийн болон тээврийн чингэлэг, бүх төрлийн агуулах, зоорь, автомухлаг, хөргөх ба эд бараа зөөх төхөөрөмжтэй автомашин, граж, албан тасалгаа, үйлдвэрлэлийн эд хөрөнгийг байнга буюу түр хадгалах зориулалттай байр, түүнчлэн хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан болон тусгай зориулалтын автомашины кабин, багаж, онгоц, галт тэрэг, далайн хөлгийн ачаа хадгалах сав зэргийг хамааруулан ойлгоно. Мал, гэрийн тэжээвэр амьтныг бусдын халдлагаас хамгаалж зориулалтын цоож, бэхэлгээ хийсэн хашаа, байр, савыг “агуулах сав” гэдэгт хамааруулж болно.

Орон байр, бусад газарт нэвтрэн ороходоо хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюулгүй арга, хэрэгсэл ашиглаж, хүний нэр төрд хүндэтгэлтэй хандана. /аль болох хор аюул, хохирол хамгийн бага түвшинд байхаар тооцон ажиллах/

Нэвтрэн ороход оршин суугч, эзэмшигч саад учруулбал эсэргүүцлээ зогсоохыг шаардах, шаардлагыг үл биелүүлбэл албадлагын арга хэмжээ хэрэглэхийг анхааруулна. Анхааруулгыг үл хэрэгссэн, эсэргүүцэл саад учруулсан үйлдэл нь албадлага хэрэглэх үндэслэл болно.

Нэвтрэн ороход эд зүйл, цоож, түгжээ, байгууламжийн хэсгийг эвдэх, дохиолол, хяналтын систем, цахилгааныг салгах, нохой, бусад амьтныг номхотгох техник, хэрэгсэл ашиглах зэргээр учрах саадыг арилгаж болно. Уг арга хэмжээ авсан, эсхүл эзэмшигчийнх нь эзгүйд нэвтрэн орсон бол эвдэрсэн эд хөрөнгийн хэвийн байдлыг сэргээх, түр хугацаагаар хамгаалах арга хэмжээ авна.

Оршин суугч, эзэмшигчийн эзгүйд орон байр, бусад газарт нэвтрэн орсон бол тэдгээрт даруй мэдэгдэх, боломжгүй бол 24 цагийн дотор мэдэгдэх арга хэмжээ авах ба боломжгүй бол түүний оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ. /харилцаа холбооны хэрэгслээр мэдэгдэх, шууд холбогдох боломжгүй бол мессеж, мэйл, шуудан, дуут шуудан илгээх гэх мэт/

Үзлэг хийх

Цагдаагийн алба хаагч энэ хуульд заасан үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд хүний бие, тээврийн хэрэгсэлд үзлэг хийнэ. /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө голчлон явагддаг ба зарим тохиолдолд зэрэгцээ явагддаг/

Үзлэгийг гадна талаас нь харах, гараар тэмтрэх, тусгай багаж ашиглах, эсхүл далд байгаа зүйлийг ил гарган шалгах замаар энэ хуульд заасан үндэслэлийн хүрээнд хийж гүйцэтгэнэ. Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг оролцуулна. Эзэмшигчийг оролцуулах боломжгүй бол хөндлөнгийн гэрчийг байлцуулж, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ. Үзлэгийг

⁷⁰ Монгол улсын дээд шүүхийн тогтоол. 1.9., 2006.05.29. Дугаар 28. УБ хот

⁷¹ Мөн тэнд

эзэмшигчийн эзгүйд хийсэн тохиолдолд даруй эзэмшигчид, боломжгүй бол баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ. Үзлэг хийх үед хуульд заасан үндэслэл илэрсэн тохиолдолд хэв загвар, дээж авах, битүүмжлэх, хураан авах ажиллагааг явуулна.

- Тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд шаардлагатай бол эд ангийг салгаж болно.
- Хүний биед үзлэг хийхэд өмссөн хувцас, биедээ авч яваа эд зүйлийг хамтад нь үзнэ.
- Хүний биед үзлэг хийх үед уг этгээдийг нүцгэлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд үзлэгийг ижил хүйсийн эрх бүхий албан тушаалтан хийнэ. Шаардлагатай бол хүний эмч, сувилагчийг оролцуулж болно. /эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, бусдаас тусгаарлагдсан орчинд/

Нийтлэг үзлэг: Цагдаагийн байгууллага, алба хаагч нийтийг хамарсан арга хэмжээ, онц чухал объектын хамгаалалтын үүрэг гүйцэтгэх үед тухайн объект, арга хэмжээ болж байгаа газарт нэвтрүүлэхийг хориглосон эд зүйл байгаа эсэхийг тогтоох зорилгоор тухайн газарт нэвтрэх хүний бие, биедээ авч яваа эд зүйлд биечлэн болон тусгай техник, хэрэгсэл ашиглан үзлэг хийж болно. /эзэмшигчийг өөрийн биед болон тээврийн хэрэгсэлд агуулагдаж байгаа шаардлагатай эд зүйлийг харуулах, ил гарган шалгуулахыг санал болгож, шаардлагатай тохиолдолд өөрийн биеэр/

Эд зүйлсийн байршлыг өөрчлөх болон далд байгаа эд зүйлийг ил гаргахгүйгээр албаны нохой, тусгай техник ашиглан шалгасныг үзлэг хийсэнд тооцохгүй.

Хүнийг баривчлах, түр саатуулах үед тухайн хүний болон цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, нотлох баримтыг олж илрүүлэх, бэхжүүлэх зорилгоор хүний бие болон түүний зорчиж байгаа тээврийн хэрэгсэлд үзлэг хийнэ. /үүрэн холбооны хэрэгсэл, цахим төхөөрөмж зэрэг мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах хэрэгсэлд прокурорын зөвшөөрөлгүйгээр үзлэг хийхийг хориглоно/

Эрүүгийн болон зөрчлийн процессын үзлэг нь тухайн чиглэсэн хэрэг зөрчлийн нотлох баримтыг олж тогтоох зорилго агуулж байдаг бол уг үзлэг нь нийтлэг өдөр тутмын үүрэг гүйцэтгэх болон онцгой байдлын, гамшгийн зэрэг тодорхой нөхцөл байдал үүссэн үед нийтлэг хэрэгжүүлэх шинжийг агуулж байдаг онцлогтой юм.

Эд зүйл, баримт бичиг түр хураан авах

Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ үүрэн холбооны хэрэгсэл, бусад шаардлагатай эд зүйл, тээврийн хэрэгсэл, цахим төхөөрөмж, баримт бичгийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр түр хураан авч болно. Хураан авах ажиллагааг эхлэхийн өмнө хураан авах эд зүйл, баримт бичгийг сайн дураар гаргаж өгөх, байгаа газрыг нь зааж өгөх боломжийг тухайн хүнд олгоно. /эрүүгийн болон зөрчлийн процессын өмнө явагддаг/

Хураан авсан эд зүйлийн төрөл, шинж байдал, тоо ширхгийг тусгасан жагсаалт үйлдэх ба эд зүйл, баримт бичгээ хураалгасан, эсхүл ажиллагаанд байлцсан хүний гарын үсэг, эсхүл хурууны хээгээр баталгаажуулж, хувийг эд зүйлийн

эзэмшигч, эсхүл түүний өмгөөлөгчид даруй гардуулна. /Эзэмшигчийг оролцуулах ба боломжгүй бол хөндлөнгийн гэрчийг байлцуулж, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ/. Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшиж байгаа албан байр, дипломат төлөөлөгчийн газрын ажилтан, түүний гэр бүлийн гишүүний оршин сууж байгаа орон байранд хураан авах ажиллагааг гүйцэтгэх бол түүний болон гэр бүлийн гишүүний Монгол Улсын зохих төрийн захиргааны байгууллагад хандаж гаргасан хүсэлтийг үндэслэн прокурор, хуульд заасан төлөөлөл байлцуулна.

ДҮГНЭЛТ.

Дээрх нөхцөл, шаардлага, онцлог зэргийг цаашид улам тодорхой нарийн судлан тодорхойлох шаардлагатай юм. Цагдаагийн алба хаагчийн хувьд “эрсдэл бүхий” гэж хэлж болохоор цаашид алба ажилтанд албан ажлынхан хувьд, эрх зүйн үр дагавар үүсгэн, сахилгын, зөрчлийн, эрүүгийн хариуцлага хүлээлгэх байдалд тулж болзошгүй олон талт нөхцөл нь энэ “тодорхой төрлийн ажиллагааг” хэрхэн зөв хийсэн, болж өнгөрсөн нөхцөл байдлыг хэрхэн зөв тайлбарласан, үүнд хууль хэрэглээний чадварыг хэрхэн ашигласан зэргээр тодорхойлогдож олон олон ажилтыг авран хамгаалах учиртай гэсэн дүгнэлтэд хүрлээ.

САНАЛ

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа” нь Эрүү, зөрчлийн процессын хуульд заасан тодорхой ажиллагаануудаас ялгагдах онцлог, утга, хэрхэн яаж уялдах талаар холбогдох хуулиудад нэмэлт оруулж тодорхой болгох. Энэ нь цаашид цагдаагийн алба хаагч ажил үүргээсээ шалтгаалан ял хариуцлага хүлээх нөхцөл байдалд тулж ирэхэд шүүх, шүүгч хууль хэрэглээний хувьд алба ажилтныг цагаатгах талын нотолгоонд суурилах боломж олгох юм.

2. Дээрх ойлголтыг онолын хувьд илүү тодорхой болгох, хичээлийн программд бие даасан салбарын /эрүү, зөрчил, цагдаагийн эрх зүй/ хичээлүүдээс гадна ялгагдах онцлог, практик хэрэглээнд хэрхэн хэрэглэх талаар сонсогч оюутныг дадлагажуулан шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгүүлж хэвшүүлэх, практик ажилтнуудад нэмэлт сургалт оруулах шаардлагатай гэсэн саналтай байна.

**НИЙСЛЭЛИЙН ЗАРИМ ХОРООНД ГАРЧ БУЙ ЗӨРЧИЛ,
ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ, ТҮҮНИЙГ
БАГАСГАХ ЗАРИМ АРГА ЗАМ**

*ДХИС-ын Цагдаагийн сургуулийн,
ЦС-ийн ЦЭЗТ-ийн багш, цагдаагийн
хошууч Д.Бямбахүү*

Товч агуулга. Энэхүү өгүүлэлд нийслэлд гарч байгаа зөрчил, тэр дундаа хамгийн их архи согтууруулах ундаа, худалдаа үйлчилгээний цэг төвлөрсөн Баянзүрхи дүүргийн 7-р хороонд гарч байгаа зөрчил, түүний шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, түүнийг бууруулах арга замын талаар товч авч үзлээ.

Түлхүүр үг:


- Зөрчил
- Согтууруулах ундаа
- Хяналт

Үндсэн хэсэг. Баянзүрх дүүргийн 7-р хороог сонгосон нь тус хороо нь Нийслэлийн А зэрэглэлийн бүсэд оршдог, 16.68 га талбай бүхий газар нутагтай. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг 182 аж ахуйн нэгжтэй. Архи согтууруулах ундаа, худалдаа үйлчилгээний цэг нийт 42 байдаг. Мөн бүх арилжааны банкуудын салбар, үүрэн телефоны оператор байгууллагуудын салбарууд байрлан үйл ажиллагаа явуулдаг. Үүнийг дагаад хүний урсгал хөдөлгөөн ихтэй. Өдөрт 1 аж ахуйн нэгж, байгууллагаар дунджаар 50 орчим иргэн үйлчлүүлдэг. Мөн хүн олноор дамжин өнгөрдөг тул явуулын гар дээрх жижиглэнгийн худалдаа ихтэй. Тэнэмэл иргэд хараа хяналт сул хүүхдүүд ихээр ирдэг.

Тухайн хороо нийт 7179 иргэнтэй ба үүнээс эрэгтэй 3363, эмэгтэй 3816, бусад аймаг дүүрэгт бүртгэлтэй боловч түр оршин сууж байгаа 51 иргэн байна. Тус хороонд бүртгэлтэй боловч хаягандаа оршин сууж амьдардаггүй 218 иргэн, гадаад улсад ажиллаж амьдарч байгаа 745 иргэн бүртгэгдсэн ба үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил нь олон нийтийн газарт бүртгэгдсэн байна.


2019 онд БЗД-ийн 7-р хороонд ирсэн нийт гэмт хэрэг, зөрчлийн талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээлэл 3853 ба үүнээс гомдол, мэдээллийн төрлөөр нь авч үзвэл 3340 буюу 86.6% нь зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, 294 буюу 7,6% нь хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн талаарх гомдол, мэдээлэл, 133 буюу 3,4% нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, 86 буюу 2,2% нь зарлан мэдээллэх шинжтэй гомдол, мэдээллүүд эзэлж байна. Үүнээс харахад зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл ихэнх буув 87 хувийг эзэлж байна.

График 1



Нийт гомдол, мэдээллийн 1043 буюу 27%-ийг материалжуулан шалгасан, 460 буюу 12%-ийг хэлтэс тасгийн хяналтад авч шийдвэрлэсэн, 410 буюу 12% нь давхардсан мэдээлэл, 373 буюу 11% нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй, 105 буюу 10%-ийг нь харьяаллын дагуу шилжүүлсэн, 372 буюу 10%-ийг нь зөрчлийн тухай хуулиар торгосон, 343 буюу 9% нь мэдээлэл батлагдаагүй, 287 буюу 7% нь мэдээлэл буцаагдсан, 242 буюу 6%-ийг нь ар гэрт нь хүлээлгэж өгсөн, үлдсэн хувиудад бусад төрлийн арга хэмжээ авсан байна. Үүнээс харахад материалжуулан шалгахаар гомдол, мэдээлэл илүүтэй ирдэг бөгөөд хуурамч мэдээлэл, давхардсан мэдээлэл мөн их ирдэг байна.

График 2



2019 онд БЗД-т нийт 6168 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнээс 7-р хороонд 847 зөрчил бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн зөрчлийн 353 буюу 41.6 хувь нь олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах, 106 буюу 12.5 хувь нь хүний биед халдах зөрчил, 79 буюу 9.3 хувь нь хуурамч дуудлага мэдээлэл өгөх, 74 буюу 8.7 хувь нь танхайрах зөрчил, 76 буюу 8.9 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдийн амгалан тайван байдлыг алдагдуулах, 50 буюу 5.9 хувь нь худалдаа үйлчилгээний журам зөрчих зөрчил, 43 буюу 5.07 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил, 27 буюу 3.1 хувь нь хулгайлах

зөрчил, 14 буюу 1.6 хувь нь гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх тухай хууль зөрчих зөрчил, бусад зөрчил нь 22 буюу 0.2 хувийг эзэлж байна

График 3



2018 онд БЗД-т нийт 3668 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнээс 7-р хороонд 389 зөрчил бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн зөрчлийн 75 буюу 19.2 хувь нь худалдаа үйлчилгээний журам зөрчих зөрчил, 58 буюу 14.9 хувь нь танхайрах зөрчил, 51 буюу 13.1 хувь нь хулгайлах зөрчил, 57 буюу 14.6 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдийн амгалан тайван байдлыг алдагдуулах, 49 буюу 12.5 хувь нь олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах, 42 буюу 10.7 хувь нь хүний биед халдах зөрчил, 15 буюу 3.8 хувь нь тамхины хяналтын тухай хууль зөрчих зөрчил, 4 буюу 1.02 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил болон бусад зөрчлүүд эзэлж байна.

График 4



2017 онд БЗД-т нийт 12052 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнээс 7-р хороонд 2517 зөрчил бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн зөрчлийн 1547 буюу 61.4 хувь нь


худалдаа үйлчилгээний журам зөрчих зөрчил, 693 буюу 27.5 хувь нь танхайрах зөрчил, 162 буюу 6.4 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдийн амгалан тайван байдлыг алдагдуулах, 162 буюу 6.4 хувь нь олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах, 40 буюу 1.5 хувь нь цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх зөрчил, 27 буюу 1.07 хувь нь хулгайлах зөрчил, 10 буюу 0.3 хувь нь хүний биед халдах зөрчил, 2 буюу 0.07 хувь нь хуурамч дуудлага мэдээлэл өгөх, 9 буюу 0.3 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил, бусад зөрчил нь 22 буюу 0.8 хувийг эзэлж байна.

График 5




Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах зөрчил 2018 онд 49, 2019 онд 353 бүртгэгдсэн нь 7,2 дахин өссөн ба олон нийтийн амгалан тайваныг алдагдуулах гэмт хэрэг тус хороонд 2018, 2019 ондуудад бүртгэгдээгүй тоон үзүүлэлт харагдаж байгаагаас үзэхэд тухайн гэмт хэргийг зөрчлийн шатанд нь илрүүлсэнтэй холбоотой гэж үзэж болно.

График 6



Хулгайлах зөрчил 2018 онд 51 бүртгэгдсэн бол 2019 онд 27 бүртгэгдсэн нь 1,8 дахин буурсан байна. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих зөрчил 2018 онд 75 бүртгэгдсэн бол 2019 онд 50 зөрчил бүртгэгдсэн нь 25 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Иймээс энэ төрлийн зөрчлийг тогтворжуулан барих шаардлагатай.


График 7



Танхайрах зөрчил 2018 онд 58 бүртгэгдсэн бол 2019 онд 74 бүртгэгдсэн нь 32%-аар өссөн ба олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг хорооны хэмжээнд 2019 онд Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хэмжээнд 2018 онд 1 гэмт хэрэг, 2019 онд бүртгэгдээгүй буюу 100 хувь, дүүргийн хэмжээнд 2018 онд 4 гэмт хэрэг, 2019 онд бүртгэгдээгүй байгаа нөхцөлд дүгнэлт хийхэд тухайн гэмт хэргийг зөрчлийн шатанд нь илрүүлсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Хүний биед халдах зөрчил 2018 онд 42, 2019 онд хүний биед халдах зөрчил 106 бүртгэгдсэн нь 3 дахин их өссөн байна. Иймээс энэ өсөлтийг саармагжуулах шаардлагатай байна.

График8



2019 онд нийт үйлдэгдсэн зөрчлийн 409 буюу 86% нь олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явсан, 66 буюу 14% нь нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулсан зөрчил эзэлж байна. Үүнээс үзэхэд олон нийтийн газарт үйлдэгдэж буй зөрчил нь ахуйн хүрээнд үйлдэгдэж буй зөрчлөөс 5 дахин их үйлдэгддэг байна.

График 9



2018 онд зөрчил гаргагчийн 28% нь ажилгүй, 1% нь оюутан, 7% нь төрийн бус байгууллагын ажилтан, 64% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. 2019 онд зөрчил гаргагчийн 35% нь ажилгүй, 1% нь оюутан, 10% нь төрийн бус байгууллагын ажилтан, 52% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1% нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч байна. Дээрхээс харахад зөрчил үйлдэж буй хүмүүс нь ихэнх нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй иргэд байна.

График 10





График 11



2015 оны 07 сарын 09 А/609 тоот “Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг түр тогтоох тухай” гэх захирамжийг хүчингүй болгож Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 2015 оны 06 сарын 11-нд хүчингүй болгосон 7.8 Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газар 00-06 цагт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно гэх заалтыг сэргээхэд тухайн хороонд үйлдэгдсэн зөрчил 48-53 хувиар буурах магадлалтай байна.

Зөрчлийг үйлдэгдсэн цагаар нь авч үзвэл 2018 онд 00:00-09:00 цагийн хооронд нийт зөрчлийн 48 хувь, 09:00-18:00 цагийн хооронд нийт зөрчлийн 22 хувь, 18:00-00:00 цагийн хооронд 30 зөрчлийн хувь бүртгэгдсэн бол 2019 онд 00:00-09:00 цагийн хооронд нийт зөрчлийн 53 хувь, 09:00-18:00 цагийн хооронд 26 хувь, 18:00-00:00 цагийн хооронд 21 хувь нь үйлдэгдсэн байна. Үүнээс үзэхэд зөрчил нь шөнийн цагаар илүүтэй үйлдэгдэж байгаа нь согтууруулах ундаагаар үйлчилдэг газар

ажилладаг байх цагаар үйлдэгддэг нь харагдаж байна. Тиймээс эдгээр газруудад хяналтыг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.

График 12





График 13




Баянзүрх дүүргийн 1,3,7 дугаар хорооны иргэд, оршин суугчдын дунд 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 33 дугаар сургуулийн хурлын зааланд зохион байгуулсан “Эрүүл, аюулгүй, амар тайван орчин” сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт нийт 98 хүн оролцсоноос 90% нь одоо мөрдөгдөж байгаа цагийн хуваарьт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн бол 84% нь баар цэнгээний газрууд 04:00 цаг хүртэл ажиллаж байгаа нь ая тух алдагдуулж, дуу чимээ ихтэйгээс амарч чадахгүй байна гэсэн байна. Мөн 95 хувь нь нийтийн орон сууцанд үйл ажиллагаа явуулж байгаа баар цэнгээний газрыг 00:00 цагаас хэтрүүлэхгүйгээр хаах санал өгч, 84 хувь нь зориулалтын тусдаа байртай байсан ч 00:00 цагт хаах хэрэгтэй гэж үзсэн, харин 14 хувь нь зориулалтын байртай газрууд 04:00 цаг хүртэл ажиллаж болох юм гэж үзсэн байна.

Мөн цагийн хуваарьт өөрчлөлт оруулахтай холбогдуулан Улаанбаатар хотын захирагчийн албанаас 2018 оны 05 дугаар сард 9 дүүрэг тус бүр дээр иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, албаны сайтаар санал асуулга авсан бөгөөд хэлэлцүүлэгт оролцсон 2706 аж ахуйн нэгж, иргэний 72.4 хувь нь буюу 1912 хүн одоогийн цагийн хуваарийг дэмжсэн, 27,3 хувь буюу 740 хүн дэмжээгүй. Харин сайтаар авсан санал асуулгад 637 хүн оролцсоноос 11.6 хувь нь одоогийн цагийн хуваарийг дэмжсэн, 88.4 хувь нь дэмжээгүй буюу согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудыг шөнийн 00:00 цагаас хэтрүүлэхгүйгээр хаах санал өгсөн.

БЗД-ийн 7-р хорооны камерийн судалгаа


Судалгаанд оролцсон нийт аж ахуй нэгж байгууллага 150, тухайн байгууллагын аюулгүй байдал нууцлалын улмаас камерийн хяналтын судалгааг өгөхөөс татгалзсан 7 ААНБ байна. Тухайлбал, Капетрон банк, Худалдаа хөгжлийн банк зэрэг. Камерийн хяналтгүй 10 ААНБ, үйл ажиллагаа нь зогсож хаагдсан 12 ААНБ байна.

График14



Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгж байгууллагуудын 112 камерын бичигч төхөөрөмжинд, 673 нь дотор камертай, 190 нь гадна камертай ажиллаж байгаагаас нийт 16 камер ажиллахгүй байна.

График15



Аж ахуй нэгжүүдийн гадна орчны хяналын камерийн хувьд 183 нь үйл ажиллагаа нь хэвийн ажилладаг, 143 нь шөнө өдрийн турш ажиллагаатай, 40 нь өдрийн ажиллагаатай, 7 нь ажилладаггүй байна. Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах зөрчил 2018 онд 49, 2019 онд 353 бүртгэгдсэн нь 7,2 дахин өссөн ба олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг тус хороонд 2018, 2019 онуудад бүртгэгдээгүй тоон үзүүлэлт харагдаж байгаагаас үзэхэд тухайн гэмт хэргийг зөрчлийн шатанд нь илрүүлсэнтэй холбоотой гэж үзэж болно.

Зөрчлийг үйлдэгдсэн цагаар нь авч үзвэл 2018 онд 00:00-09:00 цагийн хооронд нийт зөрчлийн 48 хувь, 09:00-18:00 цагийн хооронд нийт зөрчлийн 22 хувь, 18:00-00:00 цагийн хооронд 30 хувь нь бүртгэгдсэн бол 2019 онд 00:00-09:00 цагийн хооронд нийт зөрчлийн 53 хувь, 09:00-18:00 цагийн хооронд 26 хувь, 18:00-00:00 цагийн хооронд 21 хувь нь үйлдэгдсэн байна. Үүнээс үзэхэд зөрчил нь шөнийн

цагаар илүүтэй үйлдэгдэж байгаа нь согтууруулах ундаагаар үйлчилдэг газрууд ажилладаг байх цагаар үйлдэгддэг нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгж байгууллагуудын 112 нь камерын бичигч төхөөрөмжинд, 673 нь дотор камертай, 190 нь гадна камертай ажиллаж байгаагаас нийт 16 камер ажиллахгүй байна. Аж ахуй нэгж байгууллагуудын барилга, байгууламж тэдгээрийн гадна орчинд гадна камер нэмэх шаардлагатай 65, дотор камер нэмэх шаардлагатай 52 аж ахуй нэгж байгууллага байна. Нийт аж ахуй нэгж байгууллагууд нь камерын хяналтын үйл ажиллагааг 94 буюу 72% нь интернетэд холбогдон давхар эрх бүхий албан тушаалтан нь хянаж шалгаж байгаа бол 37 буюу 28% нь интернетэд холбогдоогүй өөрийн байран дээрээс хянадаг байна. Тус хорооны гадагш болон дотогшоо чиглэсэн замуудад 9 өндөр үзүүлэлттэй сайн чанарын камерын хяналтыг суурилуулбал тухайн бүс нутаг үйл ажиллагааг хяналтад авч гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд нилээд ач холбогдолтой.

Дүгнэлт. Нийслэлийн дасаг даргын 2015 оны 07 сарын 09 А/609 тоот “Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг түр тогтоох тухай” гэх захирамжийг хүчингүй болгож Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 2015 оны 06 сарын 11-нд хүчингүй болгосон 7.8 Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газар 00-06 цагт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно гэх заалтыг сэргээхэд тухайн хороонд үйлдэгдсэн зөрчил 48-53 хувиар буурах магадлалтай байна.

Судалгаанаас хархад аж ахуй нэгж байгууллагууд нь бие биенээ хянах асуудал төдийлөн байхгүй байна. Мөн тухайн хороонд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагаас 24 нь өөрийн объектод байх ба бусад нь түрээслэгчид байна.

Хэсгийн байцаагчийн бүртгэл судалгааг баяжуулах, түүнийг шалгах гэх мэт уламжлалт сэтгэлгээ, ажил дүгнэх үзүүлэлтийг өөрчилж түүнд хэрхэн дүгнэж шинжилгээ хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашигласан, ямар дүнд хүрсэн зэргээр нь дүгнэж байх, өөрөөр хэлбэл бүртгэл, судалгааг шалгалтын үед гаргаж харуулдаг, нэр төдий хөтөлж аргацаадаг байдлыг таслан зогсоох хэрэгтэй.

Хорооны нутаг дэвсгэрт гэрэлтүүлэг хангалтгүй зарим газруудад иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд хог хаягдлаа замбараагүй асгах дутагдал зөрчлүүд гарч байна. Энэ нь гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх нөхцөл бүрдсэн ба дээрх 20 цэгүүдэд гэрэлтүүлэг болон камержуулах, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай болжээ.

Засгийн газрын 2011 оны А/153 дугаар тогтоол “Цагдаагийн байгууллагын зарим ажил үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-т зааснаар 4000 хүн амд 1 хэсгийн байцаагч ногддог байна. Харин 7-р хорооны нутаг дэвсгэрт 7179 иргэн оршин суудаг, ба 182 аж ахуйн нэгжээр өдөрт дунджаар 50 иргэн үйлчлүүлдэг гэж үзэхэд 9100 орчим иргэн үйлчлүүлдэг буюу дамжин өнгөрдөг байна. Үүнээс үзэхэд тухайн хороонд 4 хэсгийн байцаагч ажиллах тооцоо гарч байгааг харгалзан үзэх шаардлага бий болжээ гэсэн дүгнэлтийг хийж байна.

Санал. БЗД-ийн 7-р хороонд гарч байгаа зөрчлийг бууруулах дараахи саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Түрээслэгч иргэн, байгууллагуудыг 3 удаа зөрчил гарган арга хэмжээ авагдсан тохиолдолд тэр объектод дахин тухайн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгохгүй байх талаар хууль тогтоомжинд тусган эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх;
- Тус хорооны гадагш болон дотогшоо чиглэсэн замуудад 9 цэг буюу нэг цэгт 360 градус эргэдэг ажиглалтын камер, хяналтын 2 камераас бүрдсэн бүрдэлтэй байх ба уг систем нь дүр төрх таних, ухаалаг хайлт хийх програм хангамжтай байна. Тухайн нутаг бүслэн хаах, гэмт хэрэгтнийг илрүүлэх, мөшгөхөд техник технологийг ашиглах;
- Эргүүлийн алба хаагчдийг хурууны хээ уншигч төхөөрөмжөөр хангаж цахим сан бүрдүүлэх;
- Түрээслэгч иргэн, байгууллагуудыг хариуцлагатай болгох болон аж ахуй нэгжүүдийн хяналтыг сайжруулахын тулд албан мэдэгдлийг тухайн объектын эзэнд өгч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах;
- Дээрх судалгаанд хамрагдсан камерын хяналтыг интернетэд холбоогүй 37 аж ахуй нэгж байгууллагын камерын хяналтын төхөөрөмжийг интернетэд холбуулах арга хэмжээ зохион байгуулах. Мөн интернетэд холбогдсон аж ахуй нэг байгууллагуудын камерын хяналтын системийг шуурхай удирдлагын төвд холбуулах арга хэмжээг авах;
- Баян цээлийн гудамж буюу аж ахуй нэгж төвлөрсөн газарт 2018 онд 347 буюу 72 хувь нь 2019 онд 203 буюу 64 хувь гэмт хэрэг үйлдэгдэж байгаа тухайн гудамжийг гурван хэсэгт хуваан 18-24 цаг 00-06 цаг гэсэн хуваарьтай эргүүлийн чиглэлийг тогтоон ажиллуулж, 9 цэгт дүр төрх таних болон ухаалаг хайлт хийх программ хангамжтай камерын хяналтын систем ажиллуулах;
- Аж ахуй нэгж байгууллагуудын барилга, байгууламж тэдгээрийн гадна орчинд 65 камер, дотор 52 камерыг тодорхой үе шаттайгаар суурилуулах үйл ажиллагааг тус хорооны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлөөс зохион байгуулах;
- Дүүргийн иргэдийн төлөөлөгчийн хурлын дэргэд криминологийн судалгаа хийдэг орон тооны бус нэгжийг байгуулан нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг судалж цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх;

ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫГ БЭЛТГЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч Э.Дашигаадан*

Товчлол: Өнөөгийн глобалчлагдсан ертөнцөд улс, үндэстнүүд хоорондоо улам өргөн харилцах болж, даяаршин эдийн засаг, нийгмийн нэгдмэл орчинг бий болгон, мэдээлэл, холбооны хэрэгслээр холбогдон, хил хязгааргүй мэт орчинд нүүрлэж байгаа олон төрлийн эрсдэлийн нэг нь зохион байгуулалттай гэмт хэрэг билээ. Энэхүү өгүүлэлд гэмт хэрэгтэй тэмцэхэд алба хаагчдыг бэлтгэхэд Цагдаагийн Академиудын Олон Улсын Холбооны хамтын ажиллагааг сайжруулах талаар авч үзсэн болно.

Түлхүүр үг: Зохион байгуулалттай гэмт хэрэг, Цагдаагийн академи, Цагдаагийн Академиудын Олон Улсын Холбоо, Олон улсын хамтын ажиллагаа.

Нэг. Үндсэн хэсэг

Энэ зууны 1930-аад оны эхэн үе бол дэлхий дахинаа олон улсын нөхцөл байдал хүндэрсэн, бүс нутаг, БНМАУ-ын дорнод хил орчим гадаадын түрэмгий бодлогын аюул бодитой нүүрлэсэн, дотоодод ангийн тэмцэл хурцадсан, лам нарын бослого, хөдөлгөөн идэвхжсэн, ард иргэд олноор дүрвэн нүүж байсан, шинэ тутам байгуулагдсан Монгол Улсын бодлого, үйл ажиллагаа эрсдэл, сорилтой учирсан түгшүүртэй он жилүүд байлаа⁷².

Энэ үед эх орны тусгаар тогтнолыг сахин бэхжүүлэх, улсын хилийг хамгаалах, ард иргэдийн амгалан тайван байдлыг хангах зорилгоор 1934 онд Дотоодыг хамгаалах газрын даргын тушаалаар “Төв сургууль”-ийг байгуулан Монгол Улсад дотоод хэргийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг албан ёсоор бэлтгэж эхэлсэн.

Өнөөдөр Дотоод хэргийн их сургууль нь Монгол улсын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын хүний нөөцийг бэлтгэх үүрэгтэйгээр Удирдлагын академи, Ахисан шатны боловсролын сургууль, Цагдаагийн сургууль, Хилийн албаны сургууль, Онцгой байдлын сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Эрх зүй Нийгмийн ухааны сургууль, Ахлагчийн сургууль гэсэн 8 бүрэлдэхүүн сургууль, Шинжлэн магадлахуйн институт болон Ахлах сургуультайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус Их сургуулийн Цагдаагийн сургууль нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мэргэжилтэн бэлтгэх зорилгоор 85 жилийн хугацаанд Монгол Улсын Цагдаагийн байгууллагын бүхий л боловсон хүчнийг анхан, давтан сургалтаар

⁷² Дотоод хэргийн их сургууль-85 түүхийн хураангуй. УБ., 2019, 16 тал

бэлтгэж байна⁷³.

Дээд боловсролтой цагдаагийн алба хаагч бэлтгэх сургалт нь олон жилийн туршлага, үр дүнд суурилсан мэргэжлийн сургалтын арга зүйн өөрийн онцлог бүхий тогтолцоог бүрдүүлж, боловсролын талаар баримталж буй бодлогын өөрчлөлт, сургалтын технологи, арга зүйн хөгжлийн түвшин, хөтөлбөрийн зориулалт, зорилго, суралцахуйн үр дүнг хэрэгжүүлэх бодит нөхцөлийг бүрдүүлэхэд ач холбогдол бүхий сургалтын үзэл баримтлал, технологид суурилсан сургалтын арга зүйн тогтолцоог бид бүхэн шинэчлэн, тогтмол сайжруулан ажиллаж байна⁷⁴.

Сургалтын технологи, арга зүйг олон улсын жишигт ойртуулах, академик сургалт давамгайлсан хөтөлбөрөөс прагматик буюу чадваржуулах сургалт давамгайлсан хөтөлбөрт шилжих, чадваржуулах сургалтын шинэ технологийг судлан нутагшуулах, мэдээллийн технологийн ололтод тулгуурласан цахим сургалтын технологийг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөн хэрэгжүүлж байна.

Тухайлбал, мэргэжлийн үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлэх чадвар эзэмшүүлэх чадамжид суурилсан модуль сургалт, мэргэжлийн мэдлэг, чадварыг цогцоор нь эзэмшүүлэх, хичээлүүдийн сэдвүүдийн уялдаа холбоог харгалзан зохион байгуулах блок сургалт, захиалагч байгууллагыг түшиглэн мэргэжлийн үйл ажиллагааны бодит орчинд мэргэжилтэн-багшийг дагалдуулан сургах клиник сургалт, бодит нөхцөл байдалд ойртуулан зохиомжилсон орон зайд мэргэжлийн үйл ажиллагааг бие даан болон багаар хэрэгжүүлэх сургалтын тоглолт, орон зай, цаг хугацаанаас үл хамааран зохион байгуулах мэдээллийн технологид суурилсан цахим /online/ сургалт зэрэг сургалтын технологиудыг өмнөх туршлага дээрээ тулгуурлан хөгжүүлж, ижил төрлийн сургалт явуулдаг гадаад, дотоодын их, дээд сургуулиудын туршлагыг судлан нутагшуулах, шинээр нэвтрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж уламжлалт гэмт хэргүүдтэй тэмцэх чадвартай цагдаагийн байгууллагын алба хаагчдыг бэлтгэж байна.

Гэвч өнөөдөр дэлхий нийтийн өмнө тулгарч байгаа гол асуудал үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг нь дэлхий дахины энх тайван, аюулгүй байдалд заналхийлж, хүний эрхийг зөрчин, улс орнуудын эдийн засаг, нийгэм, соёл, улс төр, иргэдийн хөгжлийг доройтуулж байна. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай мөнгө угаах, терроризм, мансууруулах бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, хүн худалдаалах, цахим гэмт хэргүүд зах зээлийн орон зайд дасан зохицож, нуугдмал хэлбэртэйгээр, улс орны хил хязгаарыг үл харгалзан үйлдэгдэж, аливаа соёл, нийгэм, хэл болон газар зүйн саад бэрхшээлийг үл хамааран⁷⁵ үйлдэгдэж байгаа тул тусгаар улс бүрийн Хууль сахиулах байгууллагуудын тэмцэх нэн тэргүүний асуудал болсон нь та бид нарт тодорхой билээ.

⁷³ Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны үйл ажиллагааны тайлан

⁷⁴ Цагдаагийн сургуулийн 2019 оны үйл ажиллагааны тайлан

⁷⁵ Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнтэй тэмцэх асуудал судалгааны ажлын тайлан. УБ. 2013. 12 дахь тал

Даяаршлын үр дүнд тээвэр, худалдаа, харилцаа холбоо сайжирсан нь гэмт этгээдүүдэд хууль бус үйл ажиллагаагаа хил давуулан хэрэгжүүлэх боломж, бололцоог олгож, гэмт бүлэглэлүүдийн гарт олон мянган хүн эдийн засаг, эрүүл мэндээрээ хохирч, амь насаа алдаж, иргэдийн сэтгэл санаанд асар их хор уршгийг учруулж олсон асар их ашиг орлого нь улс, гүрнүүдийн эдийн засгийг доголдуулах, санхүүгийн тогтолцоог нураах хүртэлх эрсдэлийг дагуулж байна.

Энэ төрлийн гэмт үйлдэл нь аль нэг улсын хил, хэл, соёл, нийгэм, газар зүйн хилийг даван үйлдэгдэж байгаа тул олон улсын хууль сахиулах байгууллагуудыг хамтран хариу арга хэмжээ авахыг шаардаж байна.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн дэлхийн статистик судалгааг дурдах нь илүүц биз, харин Монгол Улсын хувьд шинэ тутам үйлдэгдэж байгаа гэмт хэрэг бөгөөд тус улсад үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын талаар товч танилцуулбал:

1. Монгол Улсын Хар тамхи, мансууруулах бодистой холбогдсон гэмт хэрэгт 2019 байдлаар 196 хэрэгт 335 хүн холбогдон шалгагдсан байна. Үүнээс Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт энэ төрлийн 172, хөдөө орон нутагт 24 гэмт хэрэг бүртгэгдсэн. Энэ нь 2018 оны мөн үетэй харьцуулахад 65 нэгж буюу 33.2 хувиар, холбогдогч нарын тоо 77 нэгж буюу 22.9 хувиар өссөн байна.

2019 онд гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүмүүсийн 284 нь буюу 86.4 хувь нь 19-35 насны залуус байгаагаас 18 буюу 5.2 хувь нь 15-18 насны хүүхдүүд байна. 17 хүүхдээс 13 нь ерөнхий боловсролын дунд сургуулийн 10-12 дугаар ангийн хүүхдүүд байна. Нийт 335 хүн гэмт хэрэгт холбогдсоноос 48 нэгж буюу 14.2 хувь нь давтан үйлдсэн байна. Энэ онд бүртгэгдсэн нийт холбогдогчдын 49 хувийг 19-25 насныхан, 43 хувийг 26-35, долоон хувийг 36-45, үлдсэн нэг хувийг 46-55 насныхан эзэлж байна.

Судлаачдын үзэж байгаагаар 1100 орчим хүн уг бодисыг хэрэглэдэг гэсэн дүгнэлт хийсэн нь манай орны үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүрч хэрэглэгчдийн тоо, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын төрөл ч өсөн нэмэгдэх хандлагатай тул Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гадаад хамтын ажиллагаа болон дотоодын мэргэжлийн байгууллага, салбар хоорондын оролцоог бэхжүүлэх, уялдуулах зорилгоор “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2. Мөнгө угаах гэмт хэргийн улмаас ФАТФ буюу Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах олон улсын байгууллагын ээлжит хурлаар 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Монгол улсыг "Саарал жагсаалт"-д оруулсан нь ахуйн нэгж, иргэн мөнгөн гуйвуулга, макро эдийн засагт хүндрэл учирч эхэлж, гаднын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны хэмжээ саарч байна.

Мөн Засгийн газрын 2017 оны 143 дугаар тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, саарал жагсаалтаас гарах талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Гэвч зөвхөн 2019 оны эхний хагас жилд л Монгол Улсад авилга, албан тушаалын гэмт хэргийн улмаас 11.9 их наяд төгрөгийн хохирол⁷⁶ буюу 4 орчим тэрбум ам.долларын хохирол учирсан байна.

3. Өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж буй компьютерын хэрэглээг дагаад компьютер, компьютерын сүлжээг ашиглан үйлдэгдэх гэмт хэргийн гаралт ихэссээр байна. Ганцхан жишээ дурдахад 2019 оны 10 дугаар сард хууль сахиулах байгууллагын ажилтнууд Улаанбаатар хотын 4 зочид буудалд байрлан цахим гэмт хэрэг үйлдэж байсан гадаад улсын 738 иргэнийг саатуулан⁷⁷, Монгол Улсаас албадан гаргаж, одоог хүртэл мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

Магадгүй Монгол Улсад үйлдэгдсэн зохион байгуулалттай гэмт хэргийн ашиг, орлогоор гадаад улсад үйлдэгдэж байгаа террорист халдлагыг санхүүжүүлэх нөхцөл байдал үүсч байна гэдгийг үгүйсгэх аргагүй юм.

Дээр дурдсан гэмт хэргийн тухай товч мэдээллээс үзэхэд манай улсын үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх арга туршлага, гадаад улсын хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүйгээс дээрх төрлийн гэмт хэрэг, хохирол, хор уршиг жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа нь ганц Монгол Улсын өмнө тулгарсан асуудал биш билээ.

Бид Олон улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр болон олон талт гэрээ байгуулан, НҮБ болон бусад байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааг сайжруулах конвенциудад нэгдэн орж зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэж байгаа ч төдийлөн өндөр үр дүнд хүрэхгүй байна.

Хоёр. Дүгнэлт, санал

Бид ирээдүйд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чадвар чадамж бүхий тэмцэх арга туршлага дутмаг байгаа тул, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарч буй шалтгаан нөхцөлийг тогтоон, түүнийг арилгах талаарх зохицуулалт арга, туршлага хамтран тодорхойлох, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, гадаад орнуудын сайн туршлага, аргыг судлах, суралцах, техник технологийг практикт нэвтрүүлэх шаардлагатай байгааг улс орон бүр тодорхойлсон. Гэвч бид энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх алба хаагчдийг нэн түрүүн бэлтгэж, сургаж дадлагажуулах шаардлагатай байна.

Үүний тулд гэмт хэрэгтэй тэмцэх чиглэл бүхий Хууль сахиулах байгууллагуудын хамтарсан олон холбоог байгуулан боломжит байдлаар тэмцэж байгаа билээ. Үүний нэг илрэл бол Цагдаагийн Академиудын Олон Улсын Холбоо билээ.

Цагдаагийн Академиудын Олон Улсын Холбоотой хамтын ажиллагааг сайжруулах замаар гэмт хэрэгтэй тэмцэх боловсон хүчнийг бэлтгэх ажлыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Тиймээс дараахи саналыг дэвшүүлж байна. Үүнд:

⁷⁶ Өдрийн сонин. 2019 оны 07 сарын 30-ны өдрийн дугаар.

⁷⁷ <http://eagle.mn/r/64552>

1. Амжилт олсон туршлага, судалгааны ажлуудыг хуваалцах замаар цагдаагийн боловсрол олгох байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх,
2. Цагдаагийн боловсрол олгох байгууллагуудын захирал, сургагч, оюутнуудыг солилцооны хөтөлбөрт хамрагдах боломжоор хангах,
3. Хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу удирдах албан тушаалтнуудын менежментийн чадамжийг дээшлүүлэх зорилтын дор нэгдэж өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулж байгаа. Иймд бид цаашдаа:
 - Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн хичээлийн хөтөлбөрүүдийг солилцон, судлах,
 - Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх шинэлэг санаа, техник төхөөрөмж, арга туршлагаасаа суралцах,
 - Энэ чиглэлийн сургалтаар мэргэшсэн багш, сонсогчдыг бүс нутгийн хэмжээнд нь болон хөгжингүй орнуудад солилцон, сургах,
 - Бүс нутгийн хэмжээнд 2 ба түүнээс дээш Цагдаагийн Академиуд хамтран ажиллах талаарх “Санамж бичиг” байгуулан дээрх төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн сургалтын үйл ажил ажиллаг хамтран явуулах санал дэвшүүлж байна.

Ном зүй

1. Дотоод хэргийн их сургууль-85 түүхийн хураангуй. УБ., 2019, 16 тал,
2. Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны үйл ажиллагааны тайлан,
3. Цагдаагийн сургуулийн 2019 оны үйл ажиллагааны тайлан,
4. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнтэй тэмцэх асуудал судалгааны ажлын тайлан. 2013 он
5. Өдрийн сонин. 2019 оны 07 сарын 30-ны өдрийн дугаар,
6. <http://eagle.mn/r/64552>

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЗАРЧИМ**

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Мөрдөх арга зүйн тэнхимийн ахлах багш
цагдаагийн хошууч Б.Эрдэнэбат

Товч агуулга. Эрүүгийн багц хуулийн шинэтгэлийн бодлогын хүрээнд хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарчмын зарим асуудлыг судлах, Эрүүгийн процессын ажиллагаа шуурхай байх зарчмын мөн чанарыг тодорхойлох.

Түлхүүр үг. Эрүүгийн процесс, Эрүүгийн багц хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрх зүйн зарчим, Эрүүгийн процессын хуулийн зарчим, Эрүүгийн процессын ажиллагаа шуурхай байх зарчим

Үндсэн хэсэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд "...нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн" гэж заажээ. Манай төрөөс нийгмийн дэг журмыг хангах зорилгоор олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна. Ийм арга хэмжээнүүдийн нэг бол төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх талаар явуулж буй ажиллагаа юм. Гэмт хэрэгтэй тэмцэх нь юуны өмнө гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гарсан гэмт хэргийг илрүүлэх, бүртгэх, мөрдөн байцаах, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоож, түүнд хуульд заасан хариуцлага хүлээлгэх, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах явдлаар илрэн гарна. Ийнхүү гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрөөс явуулж буй олон талт үйл ажиллагаа нь гэмт хэргийг илрүүлэх, бүртгэх, мөрдөн байцаах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, түүнд ял оногдуулах зэрэг ажиллагаа нь гагцхүү хуулиар зохицуулагдсан эрүүгийн процессийн хүрээнд явагддаг онцлогтой.

Эрүүгийн процесс нь эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж, улмаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага болон прокурор, шүүхээс хэрэгжүүлдэг, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий олон талт цогц үйл ажиллагаа мөн. Монгол Улсын Эрүүгийн процесс нь дараах онцлог шинжтэй. Үүнд:

1. Энэ ажиллагаа нь гэмт хэргийн талаар мэдээлэл авагдсан үеэс эхэлж хэргийг мөрдөх, хянан шийдвэрлэх ажиллагааны туршид үргэлжлэн явагддаг.

2. Уг ажиллагаа нь тус тусдаа салангид биш харин өөр хоорондоо уялдаа холбоо бүхий цогц байдлаар явагддаг. Тухайлбал, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хэрэгт нотолбол зохих байдлыг тогтоохын тулд ЭБШ тодорхой ажиллагааг явуулж хангалттай нотлох баримт бүрдүүлбэл сэжигтэнг яллагдагчаар татаж, түүнд ял сонсгох бөгөөд шүүх гагцхүү тухайн яллагдагчид сонсгосон ялын хүрээнд хэргийг хэлэлцдэг.

3. Энэхүү ажиллагаа нь ЭБШХ-аар тодорхойлогдсон тодорхой зорилт, журамтай. ЭБШХ-ийн 6 дугаар зүйлд “Аливаа хэргийг шуурхай илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ял шийтгэлийг

шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангахад оршино” гэж ЭБШХ-ийн зорилтыг тодорхойлсон юм.

4. Монгол Улсын Эрүүгийн процесст төрийг төлөөлж тусгай зарчим, журмын дагуу байгуулагдсан тодорхой байгууллага, тухайлбал хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, прокурор, шүүх оролцож, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийгээд хяналт тавих, эрүүгийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх зэрэг үйл ажиллагаа явуулж оролцоно. Үүнээс гадна эрүүгийн процесст сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, өмгөөлөгч, гэрч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгчид, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд оролцдог.

5. Эрүүгийн процесст төрийг төлөөлөн оролцогч байгууллагын үйл ажиллагааны арга хэрэгсэл, хэлбэр, уг ажиллагааг явуулах газар, цаг хугацааг нь ЭБШХ-аар тогтоогдсон байдаг.

6. Эрүүгийн процесс нь хэргийн бодит үнэнийг тогтоох зарчимд үндэслэгдэж явагддаг.

7. Энэ бүхнээс үзвэл Монгол Улсын Эрүүгийн процесс нь хуулиар тогтоогдсон арга, хэрэгсэл, хэлбэр бүхий төдийгүй, тодорхой журмын дагуу явагддаг төрийн байгууллага, тодорхой албан тушаалтан, хүмүүсийн өвөрмөц үйл ажиллагаа юм⁷⁸.

Монгол Улсад Ардчилсан хувьсгал ялснаас хойш хийгдсэн шинэчлэл нь төрөөс баримтлах гадаад, дотоод бодлого, үндсэн хуулийн байгуулал, нийгэм соёл, эдийн засаг, эрх зүй⁷⁹, улс төр, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны гээд бүхий л чиглэлд хийгдсээр ирсэн ба одоо ч үргэлжилж байгаа билээ.

Үүний тод жишээ нь Эрүүгийн багц хуулиудад хийх шинэчлэлийг үе шаттайгаар явуулж⁸⁰, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилго нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх гэж тодорхойлсон байх ба судлаач миний бие тухайн хууль /эрх зүй/-ийн мөн чанар, нийгмийн ач холбогдол, үзэл санааг зарчмуудаар нь дамжуулан судлахыг зорилоо.

Францийн соён гэгээрүүлэгч Ш.Монтескьо 250 гаруй жилийн өмнө бичсэн “Хуулийн амин сүнс” бүтээлдээ “Хууль ард олны тусын тулд бүтээгддэг⁸¹” гэж дурдан хуулийн амин сүнс нь “Зарчим” гэж тодорхойлсон⁸² байна.

⁷⁸ Ц.Амарсайхан нар. Процессын эрх зүй, онол-туршлага. УБ., 2013, 2014 он. 273 тал

⁷⁹ Монгол Улсын Их Хурлын Тогтоол "Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл" 1998 он

⁸⁰ Монгол Улсын Их Хурлын Тогтоол “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 2017 он

⁸¹ Шарль Монтескьо. Хуулийн амин сүнс, Франц хэлнээс орчуулсан Т.Төмөрхүлэг УБ., 2009 он, 5 дахь тал

Зарчим гэдэг нь /латин хэлнээс principium-үндэс, эхлэл/ эрх зүйн шинжлэх ухаанд тухайн үйл ажиллагаанд зайлшгүй удирдамж болгох үзлүүдийн нийлбэрийг буюу Үндсэн хууль болон бусад хуулиудад бэхжиж тусгалаа олсон бөгөөд ЭБШ ажиллагааны ерөнхий журам, зохион байгуулалтыг тодорхойлж улмаар уг ажиллагааны мөн чанарыг илэрхийлж буй нийтлэг заалт мөн⁸³ гэж манай орны судлаачид үзсэн байна.

Харин эрх зүйн зарчмыг эрх зүйн иж бүрэн номлол буюу төсөөлөл, баримтлал, зан үйлийн ерөнхий суурь юм. Уг зарчим нь эрх зүйн тодорхой журмаас иш татсан тухайн журмын гаргасан нийтлэг үндэслэлийг тодорхойлсон заалт⁸⁴ буюу бүх субъектуудыг хамаарч эрх зүйн зохицуулалтын бүх хүрээнд үйлчилж байдаг хамгийн том нийтлэг хэм хэмжээ байдаг⁸⁵ гэж тодорхойлсон байна.

Зарчмууд нь хууль зүйн ач холбогдол бүхий асуудлыг шийдвэрлэх гол үндэслэл учраас эрх зүйн бүрэлдэхүүн нэг хэсэг⁸⁶ болж улс орон бүр тухай орны түүхэн уламжлал, эдийн засаг нийгэм, улс төрийн байгууламж, дэглэм, тогтолцоо, тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, эрх зүй, төрийн мөн чанартай холбоотой өөр өөр байдаг байна.

Эрүүгийн процессийн зарчим нь хоорондоо нягт холбоо бүхий, анхдагч, тулгуур заалт учраас түүний агуулгыг дэлгэрүүлэн тодорхойлдог эрх зүйн бусад хэм хэмжээнүүдээс ач холбогдол, үйлчлэл багтаамжийн хувьд ямагт илүү өргөн хүрээтэй байдаг.

Зарчим нь эрх зүйн бусад хэм хэмжээг удирдан чиглүүлэх, заавал дагуулах, “засаглал-захирах” шинжийг өөртөө агуулахаас гадна, зөрчигдсөн үед хамгаалагдах эрх зүйн арга хэрэгсэл нь тодорхой байдаг. Иймээс эрүүгийн процессийн ажиллагааны зарчмыг Үндсэн хуулийн заалтын “хуулбар”, аль эсхүл ерөнхий тунхаглал, үзэл баримтлал мэтээр хандаж болохгүй.

Монгол Улсын Үндсэн хуулинд эрх зүйн ерөнхий зарчмыг заан тодорхойлсон байдаг бөгөөд тэр нь ардчилсан нийгэм, төрийн мөн чанар, хүний эрх, эрх чөлөөний баталгаа болж өгнө. Бүхий л эрх зүйн хэмжээний эх сурвалж болсон Үндсэн хуульд туссан энэхүү зарчим нь салбар хуулиуд, түүний дотор ЭБШХ-д өөрийн хэв шинжээ хадгалан хэлбэржиж, үйлчилдэг.

Эрүүгийн процессийн энэхүү зарчим нь эрх зүйн хэмжээний нэгэн адил өөрийн бүтэц (гипотез, диспозит, санкц)-тэй, ингэж баймааж амьдрал - практикт хуулийн заалттай нэгэн адил үйлчилдэг юм.

Дээр дурдсанчлан эрүүгийн процессийн зарчим нь хоорондоо амин уялдаатай учраас нэг нь зөрчигдвөл нөгөө нь бас хэрэгжихгүйд хүрнэ. Ийм тохиолдолд байцаан шийтгэх ажиллагаанд ноцтой алдаа гарах нь ойлгомжтой⁸⁷.

Эрүүгийн процессын зарчим нь тухайн ажиллагааны зорилтыг ханган биелүүлэхэд ямагт тус дөхөм үзүүлдэг ба дараах үндсэн шинжүүдийг өөртөө

⁸² С.Нарангэрэл. Хуулийн амин сүнсний эрэлхийлэл. УБ., 2016 он, 8 дахь тал

⁸³ Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002 он, 10-11 тал

⁸⁴ С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. УБ хот., 2007 он, 641 дэх тал

⁸⁵ Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол., УБ., 2017 он, 99 дэх тал

⁸⁶ Дворкин. О правах всерьез. научная статья

⁸⁷ Ц.Амарсайхан нар. Процессын эрх зүй, онол-туршлага. УБ., 2013, 2014 он. 275 тал

агуулдаг байна. Үүнд:

1. Хууль зүйн хэлбэрийг олсон төдийгүй зайлшгүй дагаж биелүүлэх шинжтэй байна. Өөрөөр хэлбэл зарчим нь Үндсэн хууль, Эрүүгийн процессын хууль болон бусад ердийн хуулиудад тусгагдана.

2. Энэ нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, хэрэг шийдвэрлэх зэрэг төрөөс гүйцэтгэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, баримтлал болно.

3. Зарчим нь эрүүгийн процессын ажиллагааны явцад хийгдэж буй үйлдэл, үйл ажиллагаа, хуулийн дагуу явагдаж байгаа эсэхийн үндсэн шалгуур болохын зэрэгцээ эрх зүйн хийдлийг шийдвэрлэх хууль зүйн үндэс болно.

4. Зарчим нь манай төрийн улс төрийн бодлого, мөн чанарыг илэрхийлнэ.

Нэг үгээр хэлэх юм бол өөр хоорондоо уялдаа холбоо бүхий бүхэл бүтэн тогтолцоо болгон авч үздэг байна⁸⁸.

Нэг үгээр хэлэх юм бол эрүүгийн процессын ажиллагааны зарчим гэдэг нь тухайн эрх зүйн хэм хэмжээгээр илэрхийлэгдсэн бөгөөд мөрдөн шалгах, хянах, шүүн таслах үйл ажиллагаанд удирдлага болгох үндсэн үзэл санаа болно⁸⁹. Эдгээр зарчмууд дээр үндэслэн Эрүүгийн процессын эрх зүйн тодорхой хэм хэмжээнүүдийг хэрэгжүүлж, түүнд зохицуулан эрүүгийн процессын ажиллагаанд оролцогчид өөрсдийн үйл ажиллагааг явуулна. Эцсийн эцэст Эрүүгийн процессын ажиллагааны гол чиглэл, систем, шат, шинж чанар нь түүний үндсэн зарчмуудаар тодорхойлогддог болохоор тэр нь улс төр, хууль зүйн чухал ач холбогдолтой юм.

Тухайн үндсэн зарчмуудыг биелүүлэлгүйгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтуудыг амжилттай шийдвэрлэж чадахгүй юм.

Манай улсын эрдэмтэн судлаачдаас Д.Жаргалсайхан “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бодит үнэний зарчим”, Д.Зүмбэрэлхам “Гэм буруугийн презумпцийн зарчмыг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх онол, практикийн зарим асуудал” зэрэг сэдвээр хуул зүйн ухааны докторын сэдэв хамгаалан нарийвчлан судалсан байна.

Тухайн судлаачид, эрдэмтдийн үзэж байгаагаар Эрүүгийн процессын хуулийн зарчим нь ямар ч хөдөлгөөнгүй, хувирч өөрчлөгдөдгүй зүйл биш бөгөөд тухайн улсын нийгэм, эдийн засгийн байдалтай уялдуулан процессын эрх зүйд үндэс болгон суулгасан агуулгын хэмжээнд өөрчлөгдөж болдог байна⁹⁰.

Бүх зарчим эрүүгийн процессийн шат болгонд нэгэн зэрэг заавал хэрэгжих учиргүй. Зарчим нэг бүрийн үйлчилгээ эрүүгийн процессийн тухайн үе шатны зорилго, чиглэлээс хамаарна. Эрүүгийн процессийн зарчмыг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

1. Хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах үндэс суурь болсон зарчим (энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт тусгагдсан.)

⁸⁸ Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 2004 он, 59-60 тал

⁸⁹ Б.Чимэд. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 1987 он, 21 тал

⁹⁰ Пикалов И.А. Уголовный процесс Российской Федерации (краткий курс): Учебное пособие, 2005. 52

2. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үндэс суурь болсон зарчим (энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар бүлгийн “Дөрөв”-т зүйлд тусгагдсан.)
3. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгалаа олсон эрүүгийн процессийн ажиллагааны бусад зарчим.

Эхний хоёр хэсэгт багтсан зарчмыг зарим эрдэмтэд тулгуур зарчим хэмээн нэрлэсэн байдаг. Гуравдахь бүлэгт туссан зарчим нь Үндсэн хуулийн зарчимд тулгуурласан байдаг, гэхдээ өөрийн онцлогийг илэрхийлнэ. Жишээлбэл, нотлох баримтыг шүүх (шүүгч), прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч зөвхөн дотоод итгэлээрээ үнэлэх, шүүн таслах, ажиллагаа тасралтгүй, амаар явагдах зарчим зэргийг энд дурдаж болно.

Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн зарчмыг доорх байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. ЭХХШТА хууль ёсны байх,
2. ЭХХШАГ заавал явуулах ,
3. Хүний халдашгүй байх эрхийг хангах,
4. Иргэний орон байрны халдашгүй байдлыг хангах,
5. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууцыг хамгаалах,
6. Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх,
7. Шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэх,
8. Хэрэг, маргааныг шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулах,
9. Шүүгч хараат бус байж хууль захирагдах,
10. Хууль, шүүхийн өмнө тэгш байх,
11. Шүүх хуралдааны ажиллагааг нээлттэй явуулах,
12. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийг өмгөөлүүлэх эрхээр

хангах,

13. Шүүн таслах ажиллагааг Монгол хэлээр явуулах,
14. Гэм буруугүйд тооцох⁹¹ зэргээр тодорхойлсон байна.

Судлаач миний үзэж байгаагаар Эрүүгийн процессын хуулийн “Шуурхай байх” зарчмыг орхигдуулсан байна.

Тодруулбал Хууль тогтоогчид Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шуурхай явуулахын тулд байцаан шийтгэх ажиллагаа явуулах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн тоог нэмэгдүүлэх” гэсэн зорилт тавьж байсан ба аль ч цаг үед мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулан гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ял хариуцлагыг шударгаар оногдуулах, гэм буруугүй нэг ч хүнийг хилсээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхын тулд алив гэмт хэргийг түргэн шаламгай, бүрэн гүйцэд илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоон, нотолж, хэргийг эцэслэн шийдвэрлэх явдал байсаар ирсэн билээ.

⁹¹ Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй /Альбом схем/. УБ хоот., 2018 он, 17 тал

Эрүүгийн процессын ажиллагаа шуурхай байх зарчим

Үйлдэгдсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага зайлшгүй хүлээлгэх нь хэргийг хэр зэрэг хурдан илрүүлж, мөрдөн шалгах ажиллагаа явуулан, хянаж, шүүхээр шуурхай авч хэлэлцэхээс ихээхэн хамаардаг. Иймээс ч мөрдөн шалгах ажиллагаа нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруутгүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилго⁹²той гэж хуульд заасан байна.

Процессын ажиллагааг шуурхай явуулснаар нэг талаар гарсан гэмт хэрэг, үргэлжилсэн болон бэлтгэгдэж буй гэмт хэргүүдийг цаг тухайд нь таслан зогсоох баталгаа болно. Нөгөө талаар хэргийн бодит үнэнийг тогтоох нөхцөл нь аливаа гэмт хэргийг түргэн шаламгай бүрэн илрүүлэх явдал юм. Энэ учраас Эрүүгийн процесс хуульд хэргийг түргэн шуурхай илрүүлэх, бодит үнэнийг тогтоох хоёр гол асуултыг эрүүгийн процессын ажиллагааны үндсэн зорилтын 2 тал болгож заасан байна.

Хэргийг түргэн мөрдөн шалгаж, шүүхээр авч шийдвэрлэснээр хэргийн улмаас нийгэм, иргэдэд учирсан хохирлыг гүйцэд арилгуулах, процесст оролцож буй иргэдийн (яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч (эрхийг тууштай хамгаалах явдлыг хангана. Ялангуяа цаг хугацаа хожих нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд онц чухал ач холбогдолтой юм. Үүнд: Нотлох баримтыг түргэн, шуурхай олж илрүүлэх, бэхжүүлэн бататгах явдал орно. Зарим ажиллагаануудыг цаг хугацаа алдаж хийх нь (үзлэг, нэгжлэг) тэдгээрийг ерөөсөө хийгээгүй байсантай адил юм. Ийм учраас хууль мөрдөн шалгах зарим ажиллагаануудыг яаралтай, хойшлуулшгүй тохиолдолд⁹³ хийхийг зориуд заасан байдаг болно.

Процессыг шуурхай явуулах зарчим нь 1.1 дүгээр зүйлд заасан зорилтоос гадна тусгай хэм хэмжээнүүдэд мөн тусгалаа олсон байдаг. Хуульд хөнгөн хэрэгт мөрдөн байцаалт явуулах хугацааг 14 хоног, хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах хугацааг 1 сарын дотор⁹⁴ гэж тус тус зааж тогтоосон байдаг. Үүнээс гадна сэжигтнийг баривчлах хугацааг 48 цагаар тусгаж өгсөн нь тодорхой төрлийн мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах зарчмыг хангаж байна.

Гэвч хэрэг бүртгэлтийн хугацаа, түүнийг сунгах журмыг боловсронгуй болгох нь эзэн холбогдогч тогтоогдоогүй байгаа гэмт хэргийг илрүүлэх ажиллагаанд саад болж байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн зарчмыг, тэр дундаа шуурхай байх Эрүүгийн процессын зарчмыг нарийвчлан судлах талаар ажиллагааг явуулах саналтай байна.

⁹² ЭХХШТХ-ийн 1.1 дүгээр зүйл

⁹³ ЭХХШТХ-ийн 1.26. “хойшлуулшгүй тохиолдол” гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг

⁹⁴ ЭХХШТХ-ийн 31.13 дугаар зүйл. Мөрдөн байцаалтын хугацаа

Ашигласан материал

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 20017 он
2. Монгол Улсын Их Хурлын Тогтоол "Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл" 1998 он
3. Монгол Улсын Их Хурлын Тогтоол “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 2017 он
4. Б.Чимэд. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 1987 он
5. Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002 он
6. Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 2004 он
7. Пикалов И.А. Уголовный процесс Российской Федерации (краткий курс): Учебное пособие, 2005.
8. С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. УБ хот., 2007 он
9. Шарль Монтескьо. Хуулийн амин сүнс, Франц хэлнээс орчуулсан Т.Төмөрхүлэг УБ., 2009 он
10. Ц.Амарсайхан нар. Процессын эрх зүй, онол-туршлага. УБ., 2013, 2014 он.
11. С.Нарангэрэл. Хуулийн амин сүнсний эрэлхийлэл. УБ., 2016 он
12. Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол., УБ., 2017 он
13. Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй /Альбом схем/. УБ хоот., 2018 он
14. Дворкин. О правах всерьез. научная статья

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ АЖИЛЛАГААНД ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ, ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЭХ АСУУДАЛ

ДХИС-ийн докторант З.Эрдэм
ХААН банкны Комплаенсийн газрын
захирал, хууль зүйн магистр П.Орхон

Товч агуулга: Илтгэлд Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд дэвшилтэт техник зохицуулалтын технологи /Regulatory Technology/ нэвтрүүлэх, эдгээр дэвшилтэт зохицуулалтын технологийн давуу тал болон бусад улсад нэвтрүүлсэн туршлагын талаар бичсэн.

Түлхүүр үг: Зохицуулалтын технологи /цаашид РегТек/, Финтек, мөнгө угаах, гэмт хэрэг, мэдээлэл технологийн шийдэл

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх РегТек шийдэл

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр эрдэмтэн судлаачид болон мэргэжлийн байгууллагынхан санал бодлоо солилцох зорилгоор зохион байгуулж буй энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурал яг цагаа олсон арга хэмжээ гэж үзэж байна. Учир нь Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-ын салбар болох Ази-Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаахтай тэмцэх тогтолцоонд харилцан үнэлгээ хийж хангалтгүй гэсэн дүн тавьснаар Монгол Улсыг “саарал” жагсаалтад оруулах аюул нүүрлээд байна. Саарал жагсаалтад орон нь ямар олон сөрөг үр дагавар дагуулахыг энд дурдах нь илүүц биз.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлаар мөнгө угаахтай тэмцэхэд Монгол Улсад тулгамдаж буй асуудал, бэрхшээл, тэдгээрийг шийдэх арга зам, бусад улсын туршлага, нэвтрүүлэх боломжит шийдлийн талаар хэлэлцсэнээр улс орны мөнгө угаахтай тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох, улмаар улс орны эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлнө гэдэгт итгэж “Мөнгө угаах угаах гэмт хэрэгтэй тэмцэх РегТек шийдэл”-ийн талаар танилцуулахаар илтгэлээ бэлтгэлээ.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын санхүүгийн салбарт нэвтэрч буй техник, технологийн шинэчлэл нь хөгжил дэвшилд чухал байр суурийг эзэлж байна. Төлбөрийн карт, интернет банк, биткойн, блокчейн зэрэг нэр томъёог санхүүгийн мэргэжилтнүүдээс гадна энгийн иргэд ч өдөр тутамдаа хэрэглэдэг, мэддэг болсон. Санхүүгийн хэрэгсэл бүгд цахим хэлбэрт шилжиж бэлэн мөнгөн дэвсгэртээс цахим мөнгө, цахим хэтэвч, интернет зээл гэх болж.

Санхүүгийн зах зээл дахь бүтээгдэхүүн үйлчилгээг авч буй хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага мөн адил өөрчлөгдөж байна. Хэрэглэгч нэг дор санхүүгийн бүхий л төрлийн үйлчилгээг дэлхийн аль ч өнцөг бүрээс түргэн, шуурхай авахыг хүсэж байна.

Дээрх санхүүгийн салбар дахь мэдээлэл технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, цахим өөрчлөлт нь манай улсыг ч орхилгүй нөлөөлж, аль хэдийн нэвтрээд эхэлсэн байгаа. Өнөөдөр томоохон арилжааны банкууд, үүрэн холбооны операторууд, банкнаас бусад санхүүгийн байгууллагууд өөрсдийн цахим бүтээгдэхүүн, цахим хэтэвч, гэх мэт дижитал технологид суурилсан бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлээд эхэлсэн. Үүгээр ч зогсохгүй цахим банк хүртэл зах зээлд гарахаар ажиллаж байна. Магадгүй тун удахгүй улс орны мөнгөн дэвсгэрт жаазлагдан айл гэрийн хойморт мөнхрөх биз ээ. Монголбанкнаас 2017 онд нийтэлсэн мэдээллээр Монголын эдийн засаг ойролцоогоор 890 тэрбум төгрөг бэлнээр эргэлдэж байгаа нь нийт мөнгөний нийлүүлэлтийн 6% гаруйг л эзэлж байгааг дурдсан байдаг.

Нэгэнтээ бизнес, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ ийнхүү цахим хэлбэрт шилжиж эхэлсэн тул үүнтэй зэрэгцэн мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хяналтын механизмыг илүү боловсронгуй болгох, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Мөнгө угаах нь санхүүгийн харилцаанд оролцогчид, нийгэм болон улс орны эдийн засгийн аюулгүй байдалд маш том хохирол учруулах, сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэлтэй гэмт үйлдэл юм. Иймээс өнөө цагт дэлхий дахинд энэхүү мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх шаардлага, стандартаа улам чангатгахын хэрээр мөнгө угаах хэргийг үйлдэх арга улам бүр нарийсаж, тус гэмт хэргийн тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна.

Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь 20 сая төгрөг, түүнтэй тэнцэх хэмжээний валютаас дээрх бэлэн мөнгөний, гадаад гүйлгээний болон сэжигтэй гүйлгээний тайланг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүргийг хүлээсэн байдаг.

Гэтэл дээрх мэдээллийг мэдээлэх үүрэгтэй этгээдийн ажилтан гар аргаар шүүн, илрүүлж тайлагнан гэдэг тун төвөгтэй даалгавар. Учир нь банк, санхүүгийн байгууллага, үл хөдлөх хөрөнгийн зууч, нотариат зэргээр дамжин өдөрт сая сая гүйлгээ, хэлцэл хийгдэж байгаа бөгөөд үүнээс сэжигтэй гүйлгээг илрүүлж хугацаа алдалгүй холбогдох хууль сахиулах байгууллагад түргэн шуурхай мэдээлэхэд хиймэл оюун ухаанд суурилсан мэдээлэл технологийн шийдэл зайлшгүй хэрэгтэй болж байна.

Үүний дагуу олон улсад РегТек /Regulatory Technology, RegTech/ хэмээх шийдлийг ашиглан, үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн байна. Нэг ёсондоо хууль тогтоомж, зохицуулагч байгууллагаас тавьсан шаардлагын хэрэгжилтийг мэдээлэл технологи, хиймэл оюун ухаан ашиглан програмын түвшинд хянах, заасан өгөгдлийн дагуу сэжигтэй гүйлгээ илрүүлэх, тайлан бэлтгэх зэрэг үүрэг гүйцэтгэх хяналтын механизм, шийдэл юм.

Анх 2007 онд РегТек гэсэн нэр томъёог АНУ-д бий болсон байна. Тухайн үед АНУ-ын зохицуулагч байгууллага өөрсдийн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийг хангалттай хянаж чадаагүйгээс санхүүгийн хямрал үүссэн гэж үздэг. Энэхүү

хямралын дараа зохицуулагч байгууллага богино хугацаанд маш олон шинэ зохицуулалтыг бий болгосон. Энэ бүх зохицуулалтыг дагаж мөрдөхөд санхүүгийн байгууллагад олон тооны мэргэжилтэн, хуульчид хэрэг болсон. Харин энэ олон хуульч, хүн хүчний зардлыг бууруулах зорилготой мэдээлэл технологийн компани болон комплаенсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллага хамтран РегТек шийдлийг бий болгожээ. 2016 оны 9 дүгээр сард АНУ-ын нэгэн сонинд “РегТек бол бодит юм байна!” гэсэн нийтлэл гарсан байдаг.

ФинТек нь санхүү, мэдээлэл технологи ашиглан гаргасан бүтээгдэхүүн бол РегТек нь байгууллагын үйл ажиллагааг програмын тусламжтайгаар хуульд нийцүүлэх хяналтын шийдэл юм.

РегТекийг аливаа зохицуулагч байгууллагын хяналтанд үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас гадна хяналт тавих эрх бүхий зохицуулагч байгууллага өөрөө, түүнчлэн цагдаа, тагнуул зэрэг хууль хяналтын байгууллага хэрэглэх боломжтой. Зохицуулагч байгууллагад зориулсан технологийн шийдлийг олон улсад CapТек /Support technology, SupTech/ гэж нэрлэдэг.

Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд тавигдах хяналт нь өөрөө өндөр зардалтай, эргээд өндөр торгуультай, маш хариуцлагатай үйл ажиллагаа байдаг. Олон улсад мөнгө угаахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн үндэслэлээр 2017 оны байдлаар 300 гаруй тэрбум ам. долларын торгуулийг банк, санхүүгийн байгууллага хүлээсэн байдаг. Энэ тоо жил ирэх тусам улам нэмэгдэж, үүнтэй холбоотой мөнгө угаахтай тэмцэх тогтолцооны зардал өөрөө өдрөөс өдөрт нэмэгдэж байна.

Монгол Улсын Зөрчлийн тухай хуулиар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн тохиолдолд зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэмцэх хэмжээний хөрөнгө орлогыг хураахаас гадна зөрчил гаргасан этгээд, байгууллагыг 1 саяас 200 сая хүртэлх төгрөгөөр торгох заалттай. Ийм ч учраас банк, санхүүгийн байгууллага үйл ажиллагаандаа хяналт тавьж хуульд нийцүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байгаа.

Дээрх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах гол шийдэл нь РегТекийг нэвтрүүлж, хяналтын дүрмүүдийг зөв тохируулах явдал гэж судлаач миний бие харж байна.

РегТекийн гол зорилго нь хууль тогтоомж, дүрэм журам, зохицуулагч байгууллагын шаардлагыг биелүүлэх явцад хүний хийх боломжгүй үйлдлийг хиймэл оюун ухаан, програм ашиглан хийхэд оршино. Олон улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн дараах төрлийн РегТек шийдлүүд бий. Үүнд:

1. Харилцагч таньж мэдэх:

Харилцагч таньж мэдэх ажиллагааг хуульд заасан шаардлагын дагуу богино хугацаанд, үнэн зөв бодит мэдээллийг нэгдсэн сүлжээнээс түргэн хугацаанд гаргаж авах шийдэл.

2. Өгөгдөлд дүн шинжилгээ хийх, тайлан мэдээ боловсруулах:

Зохицуулагч байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу олон төрлийн хяналтыг хийхээр заасан байдаг. Тэгвэл

РегТек ашиглан эдгээр гүйлгээнд хяналт тавьж, тайлан мэдээг богино хугацаанд зохицуулагч байгууллагад хүргүүлэх шийдэл.

3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах:

Өнөөдөр мянга мянган хакерууд өдөр тутамд санхүүгийн байгууллагын сүлжээнд халддаг. Тэгвэл эдгээр олон мянган халдлагаас РегТек шийдлээр хамгаалж болдог байна.

4. Гүйлгээний хяналт:

Банк санхүүгийн байгууллага өдөрт сая сая санхүүгийн гүйлгээ дамжуулдаг. Эдгээр гүйлгээнд хүн 24 цагийн турш хяналт тавих ямар ч боломжгүй эсвэл маш их хүн хүч зардал шаардсан ажил болно. Үүнийг РегТек шийдлээр өдрийн 24 цаг хяналт тавих боломжтой.

Зохицуулагч байгууллагын зүгээс СапТек ашиглан дээр заасан ажиллагаан хяналтаа хэрэгжүүлдэг болдог. Тухайлбал, сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд гүйлгээ хийгдсэн даруйд оруулан хадгалснаар, зохицуулагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан энэхүү мэдээллийн санд хандаж шаардлагатай мэдээллийг шуурхай авах боломж бүрдэнэ. Ингэснээр мөнгө угаах гэмт хэргийг цаг алдалгүй түргэн шуурхай илрүүлэх, таслан зогсооход чухал ач холбогдолтойгоор зогсохгүй эргээд хууль хяналтын байгууллагын уялдаа холбоо сайжрах давуу талтай. Ийм төрлийг РегТек шийдэл АНУ, Их Британи зэрэг улсад илүүтэй хөгжсөн байдаг.

РегТек нийлүүлдэг томоохон компани:

- “Truillo” компани дэлхийн 40 гаруй улсын 4 тэрбум харилцагчийг таньж мэдэх шийдлийг боловсруулан борлуулдаг.
- “Adibe Financial” банк, брокер, хеджийн сан болон хөрөнгө оруулалтын санд зориулсан үүлэн технологийг ашиглан өгөгдлийг боловсруулах шийдлийг нийлүүлдэг.
- “NEX Regulatory Reporting” компани нь Европын холбооны шаардлагын дагуу төрөл бүрий тайланг боловсруулах шийдлийг нийлүүлдэг байна.

Тэгвэл Монгол Улсад ч энэхүү технологи өөрийн хөгжлийг эхлүүлсэн. Үүнд “Моннэп Дата ХХК” Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд заасан өндөр эрсдэлтэй этгээдийг таньж мэдэхэд ашиглагдах програмын шийдлийг зах зээлд нийлүүлж байна.

РегТекийг нэвтрүүлсэн гадаад улсын туршлага

1. Австри Улс

Австри улс нь 2014 онд мэдээллийн нэгдсэн сүлжээ буюу ABACUS платформ нэвтрүүлсэн. Австри Улсын банк, санхүүгийн байгууллага энэхүү системээр дамжуулан зохицуулагч байгууллагадаа бэлэн мөнгөний болон сэжигтэй гүйлгээг тайлагнах ажиллагааг нэгдсэн нэг програмын шийдлээр гүйцэтгэдэг байна. Мөн гүйлгээ хийх бүрөд харилцагчаас олон материал шаардах ажиллагааг халж улсын бүртгэлийн нэгдсэн системийг ашиглан харилцагч таньж мэдэх ажиллагааг гүйцэтгэдэг байна.

2. Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ нь Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын 2019 оны харилцан үнэлгээнд зориулж “Эрсдэлийн үнэлгээний тогтолцоо”-гоо шинэчилж байна. Энэхүү ажлын хүрээнд гүйлгээний хяналтын систем, сэжигтэй гүйлгээ илрүүлэх дүрэмтэй нэгдсэн мэдээлэл технологийн шийдлийг улсын хэмжээнд боловсруулж, мэдээлэх үүрэгтэй этгээд нь эдгээр програм хангамжийг заавал ашиглах үүргийг хүлээлгэсэн байна.

3. Англи Улс

Англи улс 2015 онд РегТек Сэнд Бокс инновацийг нэвтрүүлж зах зээлийг эрчимжүүлсэн. СэндБокс буюу хүүхдийн элсний хайрцаг гэж хөрвүүлж болох энэхүү технологи нь шинээр гаргаж буй Финтек бүтээгдэхүүнийг туршиж, өөрөөр хэлбэл ашиглаж үзэх байдлаар нэвтрүүлэх эсэхийг шийдвэрлэж, зөвхөн амжилттай туршигдсан тохиолдолд зах зээлд жинхлэн нэвтрүүлэх тогтолцоог бүрдүүлсэн.

4. Монгол Улс

Монгол Улсад зарим банкууд 2014 оноос РегТек шийдлийг нэвтрүүлж эхэлсэн. Үүгээр өдөр тутамд хийгдэж буй сая сая гүйлгээнд програмын тусламжтайгаар хяналт тавьж, өндөр эрсдэлтэй харилцагчийн гүйлгээнд тусгай хяналт тавих, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, эрх бүхий зохицуулагч байгууллагад тайлагнах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Гэвч арилжааны банкууд тус бүрийн ашиглаж буй эдгээр програмд нэгдсэн нэг шийдэл бүхий хяналтын дүрмийг боловсруулах, үүнд хяналт тавих арга хэмжээ дутагдаж байгааг анхаарах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ. Монгол Улсад РегТек хөгжих үндэс суурь байна гэж судлаач миний бие үзэж байна. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд цагдаа, тагнуул, авилгатай тэмцэх газар зэрэг хууль сахиулах байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн алба зэрэг зохицуулагч байгууллага болон банк, санхүүгийн байгууллага хамтын ажиллагааны тухай ярьдаг. Гэтэл дээрх байгууллагууд дээр нэмж комплаенсийн чиглэлээр мэргэшсэн байгууллага болон мэдээлэл технологийн байгууллага хамтран РегТек буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нэгдсэн хяналтын механизмыг бий болгох боломж бидэнд байна.

Өнөөдөр Монгол Улс мэдээлэл технологийн эрин зуунд хөл нийлүүлэн алхаж хүн бүр л ФинТекийн талаар ярьж байна. Тухайлбал, харилцаа холбооны 2017 оны тайлангаас харахад Монгол Улсад 3,786,000 утасны хэрэглэгч байна эдгээрээс 2,347,000 нь ухаалаг утас хэрэглэж байна. Бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжиж байгаа цагт хяналтын механизм үргэлж даган хөгжих шаардлагатай байдаг. Монгол Улсын хувьд техник технологийн дэд бүтэц хангалттай хэмжээнд хөгжсөн байгааг дээрх үзүүлэлт харуулж байна.

Иймээс РегТек хөгжүүлэхийн тулд:

Нэгдүгээрт: Улсын хэмжээнд РегТек хөгжүүлэх нэгдсэн бодлого барьж, энэ талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай. Мөнгө угаах өндөр эрсдэлтэй салбар түүний дотор үл хөдлөх хөрөнгийн зууч, үнэт эдлэлийн арилжаа

эрхлэгч, нотариат, хуульч, нягтлан бодогч нарт хуулиар тогтоосон хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна. Иймд эдгээр мөнгө угаах гэмт хэрэгт өртөх өндөр эрсдэлтэй салбарт РегТек шийдлийг анхнаас нь нэвтрүүлэх, энэхүү системээр дамжуулан хяналтаа хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг нэг мөр бий болгох нь үр дүнтэй арга гэж үзэж байна.

Хоёрдугаарт: Засгийн газар болон РегТек шийдэл хөгжүүлэгч нарын хамтын ажиллагаа нэн чухал. Засгийн газрын зүгээс энэ чиглэлээр ажиллаж буй иргэн, байгууллагад дэмжлэг үзүүлж, мэдээлэл технологийн хяналтын шийдлийг хамтран боловсруулах нь чухал ач холбогдолтой.

Гуравдугаарт: Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланд дурдсанаар 2010-2015 онд Санхүүгийн мэдээллийн албанд нийт 863 сэжигтэй гүйлгээний тайлан хүргүүлсэн байдаг. Эдгээрийн 850 нь арилжааны банкуудаас, үлдсэн 13 нь бусад байгууллагаас хүргүүлсэн байна. Ийм учраас РегТек шийдлийг улсын хэмжээнд, үр дүнтэйгээр нэвтрүүлж, хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд үр дүнгээ өгөх болно.

Эцэст нь дүгнэж хэлэхэд ХХI зуун өөрөө техник, технологийн эрэн үе. Дээр дурдсан хяналтын үр дүнтэй техник, технологийн шийдлийг нэвтрүүлэх нь зөвхөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх төдийгүй, олон улсын байгууллагаас тавьж буй шаардлагыг хангаж, улс орны гадаад харилцаа, эдийн засаг, олон улсын худалдаа, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтад нүүрлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх хяналтын хамгийн үр дүнтэй шийдэл нь РегТек болно гэдэгт судлаач миний бие бүрэн итгэж байна.

УДИРДАХУЙН УХААНЫ ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ
ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА**

Докторант, цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбат

Хураангуй: Энэхүү өгүүлэлд төрийн захиргаа удирдлагын ухаан, Төрөөс баримтлах гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын чиглэлээр судлаач эрдэмтдийн сүүлийн үеийн өгүүлэл, эрдэм шинжилгээний илтгэлүүдийг харьцуулан сэргээн, Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэх захиргааны удирдлагын үүсэл хөгжил, өнөөгийн байдлын талаар судлан удирдлагын үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Science of Public Administration буюу төрийн захиргааны ухаан, “public administration” буюу бидний “төрийн захиргаа” хэмээн нэрлэж байгаа ойлголтыг “нийтийн захиргаа” гэж, Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг,

1. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ОЙЛГОЛТ

Европ, Америкийн орнуудад “public administration” буюу бидний “төрийн захиргаа” хэмээн нэрлэж байгаа ойлголтыг “нийтийн захиргаа” гэж нэрлэдэг. Ингэж нэрлэхийн учир нь нэгд, төрийн захиргаа, төрийн удирдлага гэсэн ойлголтыг нийтийн, олон нийт гэсэн “public” гэдэг нэр томъёогоор нэрлэж ирсэн уламжлалтай холбогдох ба хоёрт, “нийтийн” гэсэн тодотгол нь төрийн байгууллагаас гадна бусад ашгийн бус байгууллагуудыг хамаарч байгаа гэсэн утгыг агуулж байгаа юм.

Ингэж “нийтийн захиргаа” хэмээн нэрлэж байгаа нь энэхүү ойлголтыг хэрэглэж ирсэн өрнөдийн уламжлалаас гадна нийтийн захиргааны (**public administration**) эрхэлдэг ажлын онцлогтой бас холбоотой⁹⁵. Аль нэг байгууллага эсвэл цөөн хүний сонирхолд нийцсэн явцуу шинжтэй биш харин бүх иргэдийн сонирхолд нийцсэн юмуу уг сонирхлыг зохицуулах, эрх ашигт нь ямар нэг хэмжээгээр үйлчлэх зорилго бүхий нийтийн шинжтэй асуудлууд (байгаль орчныг хамгаалах, хүмүүсийн аюулгүй аж төрөх нөхцлийг хангах, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ үзүүлэх гэх мэт) улс орон бүрт байдаг. Энэхүү нийтийн шинжтэй асуудлуудын талаар шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагууд, иргэдийн өөрийгөө удирдах байгууллагууд, зарим тохиолдлолд иргэд өөрсдөө шууд оролцдог. Гэхдээ ийм нийтлэг ажил үүргийг голлон хэрэгжүүлдэг, нийтийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг, олон нийтэд үйлчилдэг ажлыг голлон эрхлэгч нь төрийн байгууллага учраас “нийтийн захиргаа” хэмээн нэрлэдэг байна.

⁹⁵ А.Цанжид Төрийн захиргаа.УБ.,2009

Өрнөдийн улс төр судлалд “public administration” гэсэн нэр томъёогоор илэрхийлэгдэх ойлголтыг монголын эрдэмтэд “төрийн захиргаа” хэмээн орчуулан хэрэглэж байна. Төрийн захиргаа буюу “public administration” хэмээх ерөнхий нэр томъёо маань хэрэглэгдэж байгаа нөхцөл байдал, хам утгаасаа хамаарч хэд хэдэн янзаар ойлгогдож байна. Эрдэмтэн А.Цанжид гуайн үзэж байгаагаар энэ нэр томъёо нь нэг биш утгатай юм.⁹⁶ Эл нэр томъёоны анхны утгыг нь авч үзвэл Төрийн захиргаа гэдэг нь төрийн байгууллага гэдэг утгатай. Тиймээс үүнийг “аппарат” (оросоор: бюрократия, англиар: bureaucracy, apparatus) гэсэн явцуу утгаар нь авч үзэх нь элбэг байдаг. Ялангуяа энгийн ойлголтын түвшинд ийм утгаар хэрэглэх нь манай оронд түгээмэл юм гэж үзжээ. Харин төрийн захиргаа гэдэг ойлголтын өөр нэг утга нь **“төрийн удирдлага”** гэсэн утгатай. Тэгэхдээ “төрийн” гэсэн тодотголоор илэрхийлэгдэж байгаа утга нь уг удирдлага хүний нийгмийн амьдралын янз бүрийн салбаруудын дотроос чухамхүү төрийн салбар дахь удирдлагын тухай яригдаж байгаа хэрэг гэдгийг тодруулан зааж байгаа юм.

Энэ утгаараа төрийн захиргаа гэдэг нь төрийн үйл ажиллагааны хүрээний удирдлага гэсэн агуулгатай ажээ. Тиймээс “төрийн захиргаа”, “төрийн захиргааны удирдлага” гэсэн ойлголтууд нь адилхан утгаар хэрэглэгддэг байна.

Мөн эрдэмтэн Я.Долгоржав гуайн тэмдэглснээр “public administration” гэсэн ойлголт нь хэд хэдэн утгаар ойлгогдох ба үгийн явцуу утгаар нь авч үзвэл энэ нь төрийн захиргаанд ажиллаж байгаа түшмэдийн мэргэжлийн үйл ажиллагааг илэрхийлнэ. Америкийн нэвтэрхий толь бичигт үүнийг “Төр засгийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бүх төрлийн үйл ажиллагаа” хэмээн тодорхойлсон нь монгол хэлний “төрийн захиргаадалт” хэмээх ойлголттой таарна⁹⁷ гэж үзсэн байна.

Тэрээр төрийн захиргаадал гэдэг бол түшмэл хүн ноогдсон үүргээ хууль дүрмийн дагуу хэрэгжүүлэх ажиллагаа юм гэжээ. Францын улс төр судлаач Р.Грегори “Францын иргэний алба” хэмээх нэгэн сэдэвт бүтээлдээ “Төрийн удирдлага гэдэг бол төрийн сонирхолд нийцүүлэн хөгжлийг цэгцлэхэд чиглэсэн нийгмийн онцгой үйл ажиллагаа бөгөөд тэнд төрийн түшмэл эрх мэдлийн (гүйцэтгэх) гол төлөөлөгч болж байдаг” хэмээн бичсэн нь чухамхүү төрийн захиргаадалд түлхүү анхаарсныг харуулж байна. Гэвч төрийн захиргааг төрийн захиргаадал буюу түшмэдийн үйл ажиллагаа төдийгөөр ойлгож болохгүй харин эрх мэдэл, албан тушаалын чандлан тогтоосон шатлал, эрэмбэ, элдэв нөөц бүхий захиргааны байгууллагуудын зохистой тогтолцоо бөгөөд тэдгээр эрх мэдлээр нь дамжин төр, засгийн шийдвэрийг биелүүлэх хариуцлага дээрээсээ доошоо бууж ирдэг юм.

Үүнийг монгол хэлний “төрийн захиргааны удирдлага” товчоор “төрийн захиргаа” гэсэн утга түүний агуулгад нийцэж очно гэж үзжээ.

⁹⁶ А.Цанжид Төрийн захиргаа.УБ.,2009

⁹⁷ Я.Долгоржав “Төрийн захиргааны удирдлага, түүний тойронд өгүүлэхэд” Төрийн захиргаа сэтгүүл. УБ.,2002

Д.Эрдэнэбаатар “Төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулах ажилд хууль сахиулах байгууллагын оролцоо”

Манай оронд “*нийтийн захиргаа*” гэдэг нэр томъёог хэрэглэж хэвшээгүй бөгөөд харин “*public administration*” хэмээх ойлголтыг тойрч, түүний үндсэн агуулгыг тодотгосон шинжтэй бусад олон нэр томъёо, туслах ойлголтууд бий болсон ч тэр бүхнийг нэгтгэсэн “төрийн захиргаа” гэсэн нэр томъёо уламжлал болон хэрэглэгдэж ирсэн ба “нийтийн захиргаа” гэсэн ойлголттой адил утгаар хэрэглэгдэж байна

2. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэх захиргааны удирдлага

Цагдаа гэдэг нь төрөөс хариуцуулсан хууль, нутаг дэвсгэрт хуулийг сахиулах, нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, энэ зорилгоор хүч хэрэглэх эрх хуулиар олгогдсон төрийн төлөөлөгч гэсэн ерөнхий ойлголт байдаг. Үүнийг “constabulary, gendarmerie, police force, police department, police service, law enforcement agency” гэх зэргээр янз бүрээр нэрлэж ажилтнуудыг нь “police officers, troops, sheriffs, constables, rangers, peace officers” гэх зэргээр нэрлэдэг⁹⁸

Үүнээс “Police service” гэдгийг сүүлийн үед манайд хэрэглэж байгаа, ‘service’ гэдэг үг нь элдэв янзийн үйлчилгээний утга агуулах боловч үндсэн утга нь засгийн газраас олон нийтийн төлөө бий болгосон тогтолцоог хэлдэг. Гадаад орнуудын цагдааг ихэвчлэн “Police service” гэх зэргээр нэрлэж байгааг хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах алба гэж ойлгох нь зөв болов уу. Энэ утгаараа Цагдаагийн албаны тухай хууль болж өөрчлөгдсөн байна.

1705 оноос баруун Европт Police science буюу цагдаа судлалын ухааныг үүсгэн орчин үеийн цагдаагийн ойлголтын талаар судалж хөгжүүлж ирэхдээ цагдаагийн албаны хөгжилд хамгийн чухал хоёр зүйл бол нэгдүгээрт democratic control буюу иргэний хяналт, хоёрдугаарт political neutrality буюу улс төрөөс ангид байх явдал гэж үзсэн байдаг.

Дэлхийн улс орнуудад цагдаагийн албаны төвлөрсөн, төвлөрсөн бус, холимог зэрэг загварууд байдаг байна.

Эх газрын баруун Европын улсууд болон зүүн Европын улсууд хууль сахиулах төвлөрсөн загварыг баримтладаг (Европт зөвхөн Бельги улс л Англи-Америкийн загвартай). Тэгэхдээ баруун Европын улсуудын төвлөрсөн цагдаагийн байгууллагуудыг бүрэн төвлөрсөн, цөөн тооны үндэсний цагдаа, холбооны эрх мэдлийн хүрээнд бүсчилж төвлөрүүлэх, төвлөрсөн бус орон нутгийн цагдаагийн загвар гэж ангилж үздэг.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа 1945 онд Япон улсад Америкийн загварыг нэвтрүүлж цагдаагийн байгууллагыг 1600 гаруй хуваан хот тосгонд нь өгсөн боловч 1954 оны реформоор үндэсний нэг цагдаагийн байгууллагатай болж төвлөрүүлсэн байна. Мөн хамгийн сүүлийн жишээ нь Нидерланд улс 26 бие даасан мужийн цагдаагийн байгууллагатай байсан бол 1993 оноос хөтөлбөр хэрэгжүүлэн 2012 оноос бүрэн төвлөрсөн цагдаагийн байгууллагатай болсон.

⁹⁸ Д.Эрдэнэбаатар “Төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулах ажилд хууль сахиулах байгууллагын оролцоо”

Төвлөрсөн бус цагдаагийн тогтолцооны сонгодог жишээ болох 18,000 гаруй бие даасан цагдаагийн байгууллагатай Америк хүртэл 9/11-ний үйл явдлын дараагаас цагдаагийн төвлөрсөн тогтолцоо бий болгох талаар судалж байгаа бөгөөд энэ маш урт хугацааны процесс⁹⁹.

Энэ утгаараа Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан улс үндэсний нэгдмэл хөгжлийн зорилгод нийцүүлэн, дэлхийн улс орнуудын цагдаагийн хөгжлийн чиг хандлагыг баримтлан цагдаагийн байгууллагын удирдлагын үндсэн зарчмыг нэгдмэл төвлөрсөн байхаар заасан байна.

Гэмт явдал гэдэг нь иргэн, нийгэм, төрийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд хохирол учруулдаг нийгэмд аюултай үзэгдэл юм.

Тийм учраас төр энэ асуудлыг дотоод бодлогынхоо нэг чухал салбар гэж үзэж гэмт хэрэгтэй тэмцэхэд тодорхой чиглэсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлж ирсэн.

Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлого нь эрх зүйн нэгдсэн бодлогоос урган гардаг учраас эрх зүйн бодлогын асуудлыг авч үзэх зайлшгүй шаардлагатай. Төрөөс эрх зүйн үр ашигтай бодлогыг боловсруулах, улс орны алсын болон ойрын ирээдүйд эрх зүйн хөгжлийн үзэл баримтлалыг үндэслэх явдал хууль зүйн шинжлэх ухааны тулгамдсан зорилтуудын нэг юм.

Эрх зүйн бодлого нь төрөөс улс орондоо ардчилсан шинэчлэл хийх үндсэн үзэл баримтлалын нэгдэл бөгөөд эрх зүйн хэм хэмжээнд тусгагдан хэрэгждэг. Манай улсын өөрчлөн байгуулалтын бодлого нь бүхэлдээ эрх зүйт төрийг төлөвшүүлэхэд чиглэгддэг. Хуулийн засаглалын хүчээр хэрэгжиж байгаагаараа онцлог юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг “Хүн, төр, нийгэм, байгууллага, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх, эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор нийгэмд аюултай ямар нэгэн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, журмыг тогтоох зэргийг гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого гэдэг.”¹⁰⁰

Мөн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судалж тогтоосны үндсэнд урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үр өгөөжтэй арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг төгөлдөржүүлэх талаар төрөөс баримталж буй чиглэл, удирдамж” гэж тодорхойлж болох юм. Төрийн гадаад, дотоод бодлого нь юуны өмнө Үндсэн хууль олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон бусад салбар хуулиудын тусламжтайгаар хэрэгждэг.

Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого нь Үндсэн хуулийн суурь зарчмуудаас урган гардаг. Тухайлбал, Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, 3-р зүйлд “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно”, 4-р зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил хязгаар халдашгүй дархан байна”, 5-р зүйлд “Төр нь нийгмийн

⁹⁹ P.J. Ortmeier, Joseph J.Davis “Police Administration-A Leadership Approach”, N.Y, USA., 2012

¹⁰⁰ Төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх талаар баримтлах бодлогын баримт бичиг

болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, 6-р зүйлд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл төрийн хамгаалалтад байна”, 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан оюуны өв, төрийн хамгаалалд байна”, 16-р зүйлд “Монгол Улсын иргэн Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”, гэж тус тус заасан нь Эрүүгийн бодлогын агуулга, чиглэл болох ёстой.¹⁰¹

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн эрх зүйн зохицуулалтыг Цагдаагийн албаны тухай хуульд дараах байдлаар томъёолж өгсөн байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах; гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх; гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах; хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах; хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах; гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах; хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах; Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах; шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах; гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах; гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажилд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусалцаа авах, татан оролцуулах.

Цагдаагийн байгууллага энэ хуулийн 10.1.5, 10.1.6-д заасан ажиллагаа явуулахад шаардлагатай тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, тусгай техник, арга хэрэгсэл ашиглах, халхавчийн байгууллага, нууц гүйцэтгэх болон туслагч, туслах ажилтныг ажиллуулна.

Цагдаагийн төв байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд дараахь үүрэг гүйцэтгэнэ: гэмт хэрэг үйлдсэн газраас ул мөр, баримт сэлт илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх, адилтгал хийх үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, заавар, зөвлөмж боловсруулах, боловсронгуй болгох, биелэлтийг хангах; хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах аргачлал, бодлого боловсруулж хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх; энэ хуулийн 61.1-д заасан мэдээллийн сан үүсгэх, ашиглах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах; гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшин, хэв журмын нөхцөл байдлын талаар мэдээлэл боловсруулах, цагдаагийн байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах; олон улсын эрүүгийн цагдаагийн

¹⁰¹ Монгол улсын Үндсэн хууль

байгууллага-Интерполын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улсын цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс хүлээн авсан мэдээ, мэдээллээр цагдаагийн байгууллагыг хангах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авахаар хуульчлан зааж өгсөн байна.

3. Санал дүгнэлт

Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, харилцан уялдаа бүхий цогц арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын хэмжээний эрүүгийн нөхцөл байдлыг дүгнэвэл 14,1 гэмт хэрэг тутамд нэг хүн нас барж, 2,6 гэмт хэрэг тутамд нэг хүн гэмтжээ.

Өөрөөр хэлбэл хоногт дунджаар 57 гэмт хэрэг бүртгэгдэж, 4 хүн нас барж, 22 хүн гэмтжээ. Сүүлийн 12 жилийн дундаж 20886 гэмт хэргийн 45,7 хувь нь орон нутагт 54,2 хувь нь нийслэлд бүртгэгдсэн нь хотжилттой холбоотойгоор төвлөрсөн суурин газарт цаашид өсөх хандлагатай байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд дараах арга хэмжээг авч удирдлага зохион байгуулалтаар ханган, хэрэгжүүлэх шаардлага бий болж байна. Үүнд:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн талаар санал боловсруулах хуульд заасан үүргийн дагуу гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын баримт бичгийг санхүү эдийн засгийн судалгаа тооцоололтой шинэчлэн бартуулж хэрэгжүүлэх;

2. Зохион байгуулалттай, улс дамнасан гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах дагнасан байгууллагын бүтэц, тогтолцоог бий болгох хэрэгцээ байгаа нь харагдаж байна,

3. Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг уламжлалт байцаалтын аргаар нотолж бус эд мөрийн баримтаар нотлох үйл ажиллагааг хөгжүүлэх шаардлага тулгарч байна;

4. Гэмт хэргийн үйлдлийн арга улам нарийсч байгаа энэ цаг үед гэмт хэргийг илрүүлэх орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэт техник хэрэгслийг нэвтрүүлэх, криминалистикийн шинжилгээний суурин болон явуулын лаборатори, бичил ул мөрийг илрүүлэх, шинжлэх зориулалттай тоног төхөөрөмжийг ашиглах шаардлагыг нөхцөлдүүлж байна;

5. Шинээр батлагдсан Эрүүгийн хууль 2017 оны 07 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж буй хуульд хохирлын доод хэмжээг заагаагүй, үүнтэй холбоотойгоор үйлдэл бүрт хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж байгаа нь ачааллыг одоогийнхоос даруй 3 дахин нэмэгдүүлэх нөхцлийг бий болгож байх тул хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;

6. Алба хаагчдын гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны арга зүй, ур чадварыг дээшлүүлэх, сэтгэлгээний хандлагыг өөрчлөх давтан сургалтуудыг тогтмолжуулах;

7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож буйтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх ажлыг криминологийн шинжлэх ухааны үндэслэлтэй, шат дараалалтай хэрэгжүүлэх шаардлагатай бий байна;

Ном зүй

А.Цанжид Төрийн захиргаа.УБ.,2009

1. Я.Долгоржав “Төрийн захиргааны удирдлага, түүний тойронд өгүүлэхэд” Төрийн захиргаа сэтгүүл. УБ.,2002/2
2. Монгол менежмент төв “Орчин үеийн төрийн удирдлага”хуудас12
3. Hood. Ch. “Public Management for all seasons?”\ Public Management, Vol. 69, No 1, 1991
4. Отгонбаяр Нямаев “Дэлхийн улс төр, эрх зүйн сэтгэлгээний дээж бичиг-I” УБ., ред: Г. Энхтуяа, Ш. Гаваа, “БТМ” ХХК-ийн хэвлэх үйлдвэр, 2013., х 6-180-р тал
5. Д.Таванжин “Монголын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт” УБ., 2000 он
6. Я.Долгоржав “Төрийн захиргааны удирдлага, түүний тойронд өгүүлэхэд” Төрийн захиргаа сэтгүүл. УБ.,2002/2
7. Б.Чимид. “Үндсэн хуулийн үзэл баримтлал:нийтлэг асуудал”УБ.,2004он
8. Ж.Долгорсүрэн. “Цагдаагийн эрх зүй”. УБ., 2004 он
9. Д.Таванжин. “Цагдаагийн эрх зүй”. УБ., 2006 он
10. П.Одгэрэл. “Захиргааны эрх зүйн ерөнхий анги”.УБ.,2008 он
11. С.Жанцан. “Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол” 1 боть.УБ.2009 он
12. Ж.Долгорсүрэн, Д.Булган. “Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс”.УБ.,2014 он
13. Д.Эрдэнэбаатар.”Хууль сахиулах үйл ажиллагааны өнөөгийн байдал,чиг хандлага”. /илтгэл/ УБ.,2017 он.
14. Д.Булган. “ Цагдаагийн захиргааг тодорхойлох зарим асуудал”. /илтгэл/. УБ., 2017 он.
15. Ч.Баатар. “Хууль сахиулахуйн инноваци, аюулгүй байдал хамгаалалтын үйл ажиллагааны тулгамдсан зарим асуудал”. илтгэл. 2014 он
16. S.Schiavo-Campo and P.S.A. Sundaram., To Serve and to Preserve:Improvering Public Administration in A Competitive World. Ц.Даваадулам., Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг, Glossary of concepts and terms in goverence,2010 он
17. P.J. Ortmeier, Joseph J.Davis “Police Admiistration-A Leadership Approach”, N.Y, USA., 2012
18. МУ-ын ЦЕГ, “Монгол улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”. УБ., 2018 он.

**ЦАГДААГИЙН ТАКТИК ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН
ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

**ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ СӨРӨГ ТУСГАЙ АЖИЛЛАГААНЫ
СУРГАЛТ, БЭЛТГЭЛЖИЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ**

/ОХУ-ын Үндэсний гвардийн жишээ нь дээр/

Доктор, цагдаагийн хурандаа З.Цэрэнбат

Жаргах цагт сэрэмж хэрэгтэй

Зовох цагт хатуужих хэрэгтэй

Дайсан үгүй гэж ирт мэсийг биеэс бүү холдуул

Даруй хортой хэмээн нөхрийг бүү сөнөө

Оюунтүлхүүр судраас

Товч агуулга: ОХУ-ын Үндэсний гвардийн цэргийн терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагааны сургалт, бэлтгэлжилтийн удирдлага, зохион байгууллалтын талаар дурьдсан.

Abstract: National Guard of the Russian Federation the management of negative counter-terrorism training, the management, the organization and the results of its preparation.

Түлхүүр үгс: ОХУ-ын Үндэсний гвардийн цэрэг, терроризмтой тэмцэх чиг үүргийн сургалт, бэлтгэлжилт, хөгжлийн чиг хандлага.

Keywords : National Guard of the Russian training, preparation and development trends of terrorism.

Үндсэн хэсэг. Дэлхийн улс орнууд терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагааны онол практикийн асуудлыг эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан нэгдмэл бодлого, тогтолцоо, удирдлага, зохион байгуулалттайгаар тэмцэхэд чиглэсэн сургалт, бэлтгэлжилтийг тасралтгүй, өндөр ачаалалтай хийсээр л байна.

Манай улсад терроризмын аюул, заналхийлэл шууд нүүрлээгүй ч терроризмын эсрэг тэмцэлд холбогдох байгууллагууд, ард иргэдийг урьдчилан бэлтгэх, нийгмийн дэг журмыг хангах ажлыг эрчимжүүлэх, олон нийтийн хүч дэмжлэгийг авч ажиллах нь тулгамдсан асуудал хэвээр байна.

Терроризм - хаана хяналт, шалгалт сул, сонор сэрэмжгүй назгай байдал ноёрхож, ард иргэд, холбогдох байгууллага нь түүний эсрэг тэмцэх бэлтгэлгүй байна, тэнд орон зайгаа олон цэцэглэн хөгжиж, нутагшидаг.

Манай улс нь хуучин ЗХУ (ОХУ)-д өөрийн бүхий л мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж, тэдний техник тоног төхөөрөмж, зэвсэг, хэрэгслийг ашиглан, сурган заах арга зүй, сургалт, бэлтгэлжилтийн тогтолцоогоор явж ирсэн уламжлалтай.

Энэ уламжлал нь дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа террористуудтай тэмцэх сөрөг тусгай ажиллагааны сургалт, бэлтгэлжилтийг үр дүнтэй зохион байгуулахад илүү бидэнд ойр, хэрэгжүүлэхэд оновчтой байх гэсэн үзэл хандлагаар тухайн улсын үндэсний гвардийн цэргийн сургалт бэлтгэлжилтийг жишээ болгов.

НЭГ: ТЕРРОРИЗМТАЙ ТЭМЦЭХ ҮНДСЭН ХҮЧ- ҮНДЭСНИЙ ГВАРДИ

Улс орны дотоод аюулгүй байдал, терроризмтай тэмцэх төрийн бодлого, тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үүрэг гүйцэтгэх чадавхи, харилцан ажиллагааны өнөөгийн нөхцөл байдалд эрдэмтэн, судлаачдын баг 1990 оноос хойш судалгаа хийсний үндсэн дээр цаашид энэ бүтэц, тогтолцоогоор явах боломжгүй гэдгийг тогтоосон¹⁰².

ОХУ-ын Үндэсний гвардийн цэрэг нь ерөнхийлөгчийн зарлигаар анх 2016 оны 4 дугаар сарын 5-ны өдөр Дотоодын цэргийн үндсэн бүтэц дээр БХЯ-ны цэргийн цагдаа, армийн агаарын болон тэнгисийн цэргийн флотын хүч хэрэгсэл, онцгой байдлын зарим ангийг нэгтгэн “Үндэсний гвардийн цэргийн алба” болгон өөрчлөн зохион байгуулсан.


ОХУ-ын Төрийн дум 2016 оны 7 дугаар сарын 22-ны өдөр (№ 226) Үндэсний гвардийн цэргийн албаны эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэлийг тогтоон, Үндэсний гвардийн тухай хуулийг батлан, ерөнхийлөгч 2016 оны 7 дугаар сарын 29-ны өдөр батламжилжлан гарын үсэг зурсан.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн дэг журмыг хамгаалах, улсын онц, онц чухал объектыг хамгаалах, терроризмтай тэмцэх зэрэг үндсэн чиг үүрэг бүхий байгууллагуудыг нэгтгэн “Үндэсний гвардийн цэргийн алба ” болгон өөрчлөн зохион байгуулсан явдал нь дэлхий улс, орнууд дотоод аюулгүй байдлаа хангаж байгаа нийтлэг чиг хандлага, орос орны өнөөгийн шинэ орчин нөхцөлд тохирсон түүхэн ач холбогдолтой шийдвэр болсон гэж судлаачид үздэг¹⁰³.

¹⁰². Чернявский А.Г., Олейник С.А, Дефиниция «Международный терроризм» в международном праве // Юридическая наука и практика: Вестник Нижегородской академии МВД России. 2018. № 4 (44) С. 322-327.

¹⁰³ Олейник С.А., Самодуров Д.И., Олейник Е.П. Международно-правовые основы борьбы с терроризмом. Роль в борьбе с терроризмом Федеральной службы войск национальной гвардии Российской Федерации // Государственная служба и кадры. 2017. № 1. С. 97-100.

ХОЁР: ҮНДЭСНИЙ ГВАРДИЙН БҮТЭЦ, ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРЭГ



Үндэсний гвардийн цэргийн алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ



Сүүлийн 3 жилийн судалгаагаар Үндэсний гвардийн тусгай хүчний дайчид бусад хүчний байгууллагатай хамтран 200 гаруй террор ажиллагаа үйлдэхээр бэлтгэж байсныг илрүүлэн аюулгүй болгон, нууц, далд аргаар галт зэвсэг сум, галт хэрэгсэл бэлтгэн, ашиглахаар завдсан 500 орчим террористуудыг устгасан.¹⁰⁴

ГУРАВ: ТЕРРОРИЗМТАЙ ТЭМЦЭХ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТ, БЭЛТГЭЛЖИЛТ

Орчин үеийн терроризм нь тухай улсын геополитик, улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын онцлогоос нь хамааран илэрч үзэгдэх хэлбэр, загвар, хөнөөлийн хүрээ, учруулах аюул нь өөр өөр байгаа бөгөөд урьдчилан төсөөлөх боломж хомсхон байна.

Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд терроризмын эсрэг тэмцэх сөрөг тусгай ажиллагааны сургалт, бэлтгэлжилтийг зохион байгуулахдаа судалгаанд суурилсан бодлого, тогтолцоо, хөтөлбөр, сургалтын материаллаг бааз, орчин дээр цагийн байдлын янз бүрийн нөхцөлд, алба хаагчдыг өндөр ачаалалтай тогтмол явуулснаар аливаа террори хэлбэрийн аюулаас урдчилан сэргийлэх, саармагжуулах, устгах боломжтой гэж судлаачид үзэж байна.

¹⁰⁴ Росгвардия смотрит в будущее Интервью Андрей Сорокин В интервью журналу «Национальная оборона» директор Федеральной службы войск национальной гвардии – главнокомандующий войсками национальной гвардии РФ генерал армии Виктор ЗОЛОТОВ №8 август 2019

ОХУ-ын Үндэсний гвардийн цэргийн албаны сургалт бэлтгэл нь Дотоодын цэрэг, тусгай хүчний сургалтын уламжлалт сурган **заах арга зүйд тулгуурлан** орчин үеийн цэргийн боловсролын хөгжлийн чиг хандлага, боловсролд инновацийг нэвтрүүлэх **цогц бодлогын хүрээнд** судалгаа, сургалт бэлтгэлийг ОХУ-ын Үндэсний гвардийн цэргийн дээд сургуулиудад мэргэжилтэн болон бакалаврын түвшинд сургалтыг дараах чиглэлээр үе шаттайгаар зохион байгуулж байна. Үүнд:

1. Армийн генерал И.К. Яковлевын нэрэмжит Новосибирск хотын

Үндэсний гвардын цэргийн дээд сургууль

- Мэргэжлийн чиглэл: 40.05.01 Үндэсний аюулгүй байдлын эрх зүйч (Командын анги) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил
- Мэргэжлийн чиглэл: 45.05.01 Орчуулга ба орчуулагч (Тагнуулын факультет) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил

2. Улаан тугийн одонт Холбооны улсын Саратов хотын Үндэсний гвардын цэргийн дээд сургууль

- Мэргэжлийн чиглэл: 40.05.01 Үндэсний аюулгүй байдлын эрх зүйч (Командын анги) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил

3. Холбооны улсын Санкт-Петербург хотын Үндэсний гвардын цэргийн дээд сургууль

- Мэргэжлийн чиглэл: 40.05.01 Үндэсний аюулгүй байдлын эрх зүйч (Командын анги) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил,
- Мэргэжлийн чиглэл: 40.05.02 Албаны үйл ажиллагааны сэтгэл зүй (Ёс зүй, сэтгэл судлалын хангалтын анги) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил,

4. Холбооны улсын Перм хотын Үндэсний гвардын цэргийн дээд сургууль

- Мэргэжлийн чиглэл: 23.05.02 Тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн ашиглалтын мэргэжилтэн (Техникийн хангалтын факультет) Дээд боловсролын түвшин- Мэргэжилтэн-5 жил,
- Мэргэжлийн чиглэл: 23.05.02 Албаны үйл ажиллагааны сэтгэл зүйч (Ёс зүй, сэтгэл судлалын хангалтын анги) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил,
- Мэргэжлийн чиглэл: 17.05.02 Артиллер, ракетын болон буудлагын зэвсэгийн мэргэжилтэн (Артиллерийн зэвсэглэлийн факультет) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил,
- Мэргэжлийн чиглэл: 09.05.02 Тусгай зориулалтын холбоо, математик, мэдээлэл технологийн системийн ашиглалтын мэргэжилтэн (Автоматик системийн удирдлагын факультет) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил,
- Мэргэжлийн чиглэл: 11.05.02 Тусгай радио техникийн ашиглалт, автомат удирдлага, ашиглалтын мэргэжилтэн (Автомат системийн удирдлагын факультет) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил,

- Мэргэжлийн чиглэл: 09.05.02 Тусгай зориулалтын холбоо, математик, мэдээллийн технологи, системийн ашиглалтын мэргэжилтэн (Автоматик системийн удирдлагын факультет) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил,
- Мэргэжлийн чиглэл: 06.05.02 Цэргийн биологи, нохой сургагч мэргэжилтэн (Нохойн сургуулийн факультет) Дээд боловсролын түвшин: бакалавр Мэргэжилтэн-4 жил,
- Мэргэжлийн чиглэл: 56.05.01 Цэргийн ар тал, хангалтын мэргэжилтэн (Цэргийн ар тал, хангалтын факультет) Дээд боловсролын түвшин Мэргэжилтэн-5 жил,

Мөн ОХУ-ын Үндэсний гвардийн цэргийн албаны даргалах бүрэлдэхүүн, офицеруудыг БХЯ-ны Цэргийн их сургуулийн харьяа Үндэсний гвардийн сургуульд бэлтгэхээс гадна Зэвсэгт хүчний ерөнхий цэргийн академийн хуурай замын цэргийн шинжлэх ухаан, сургалт, бэлтгэлийн төвд бэлтгэгдэж байна.

ОХУ-ын Үндэсний гвардийн цэргийн командлал, удирдлага “Олон улсын терроризмтой тэмцэх” чиглэлээр команд штабын хээрийн сургуулийг хөрш зэргэлдээ болон хамтын ажиллагаатай улсуудтай хамтарсан сургалтыг тусгай хөтөлбөрийн хүрээнд байнга зохион байгуулж үр дүнг тооцож байна.

Тухайлбал 2019 оны 10 дугаарын 14-16 ны хооронд БНХАУ-ын ардын зэвсэгт цагдаатай хамтарсан хээрийн сургуулийг “Ууланд” нэртэйгээ Новосибирск хотын ойролцоог хээрийн сургалтын төвд зохион байгуулсан нь олон улсын болон бус нутгийн хэмжээнд терроризмын эсрэг хамтран тэмцэх бодлого барьж хүчээ нэгтгэж, сургалт бэлтгэлжилтийн чанар үр өгөөжийг дээшлүүлэх, аюулгүй байдлыг хангахад үнэтэй хувь нэмэр оруулж байна гэж судлаачийн хувьд үзэж байна. ОХУ-ын Үндэсний гвардын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 25 дугаар зүйлд Үндэсний гвардын цэрэгт боловсон хүчнийг доорхи үе шаттай бэлтгэнэ.

25.1. Холбооны улсын боловсролын тухай хуулийн дагуу явуулах сургалт:

25.1.1. Төрийн болон цэргийн албанд насан хүрээгүй хүүхдүүдийг урьдчилан сургаж бэлтгэх зорилгоор нэмэлт хөтөлбөрийн дагуу ерөнхий боловсролын ахлах болон дунд сургуулийн сурагчдын сургалт,

25.1.2. Мэргэжлийн дунд боловсролын сургалт,

25.1.3. Дээд боловсролын сургалт,

25.1.4. Мэргэжил дээшлүүлэх сургалт,

25.1.5. Тодорхой чиглэлээр мэргэшүүлэх сургалт,

25.2. Даргалах бүрэлдэхүүнийг мэргэшүүлэх, хугацаат цэргийн алба хаагчдын байлдааны бэлтгэлийн сургалт,

25.3. Алба хаагчдын мэргэжлийн тактик-тусгай бэлтгэлийн мэргэшүүлэх сургалт,

Албан тушаалын түвшингээр нь сургалт, бэлтгэлийг дараах байдлаар зохион байгуулна:

- Удирдах бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл (командующий);
- Ахлах бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл (офицер);

- Ахлагч бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл (парапорщики, мечмани);
- Цэргийн албаны сургалт бэлтгэл (хугацааны болон гэрээт); гэх зэргээр шаталсан зарчмаар явуулна.

Сургалт, бэлтгэлжилтийн орчин, нөхцөлд:

- Онол арга зүйн мэдлэг олгох сургалтыг (сургалтын танхимд лекц, семинар, команд штабын сургалт хэлбэрээр) олгоно;
- Сэтгэл зүйн бэлтгэл (цагийн байдалд ойртуулсан сургалтын төв, полигон) суулгана;
- Бие бялдрын бэлтгэл (цагийн нөхцөлд ойртуулсан сургалтын төв, полигон); суулгана
- Тэсвэр, тэвчээрийн бэлтгэл (цагийн нөхцөлд ойртуулсан сургалтын төв, полигон) суулгана

Цэргийн анги салбарт явуулах тасралтгүй

сургалт бэлтгэлжилтийн төрлүүд:

1. Биеийн хүчний бэлтгэлжилт: Гэмт этгээдийн эсэргүүцлийг биеийн хүчээр ялах бэлтгэлжилт, аюулыг өөрөөсөө зайлуулах, мэдрэх чадвар (Биеийн хүч, тэсвэр, тэвчээр, аюулыг хугацаанд нь мэдрэх)
2. Техникийн бэлтгэлжилт: (Нэг бүрийн тусгай хэрэгсэл, байлдааны мэх, өчигийг хуулийн хүрээнд цаг хугацаанд хэрэглэх чадвар)
3. Галт зэвсгийн бэлтгэлжилт: (Янз бүрийн байрлалаас оновчтой буудах чадвар, буудлагын зэвсгийн эд анги, ажиллах зарчмын талаархи хангалттай мэдлэг),
4. Мэргэжлийн Тактикийн бэлтгэлжилт: (Хувийн аюулгүй байдлаа хангах үүргээ биелүүлэх явцад өөрийн үйлдлийг хянах, хууль зөрчигч этгээдийн эсэргүүцлийг урьдчилан тооцох чадвар)
5. Эр зоригийн бэлтгэлжилт: (Бодит нөхцөлд өөрийнхээ үйлдлийг зохицуулах чадвар)
6. Мэргэжлийн сэтгэл зүйн бэлтгэлжилт: (Мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой сэтгэл зүйн хүндрэлийг даван туулах чадвар)
7. Байнгын биеийн бэлтгэлжилт: (Мэргэжлийн сургалтаар олж авсан мэдлэг, дадлага, чадварыг алба хаах хугацаандаа мэргэшлийн болгон бэлтгэлжиж, хадгалж байгаа байдал)

Сургалт, бэлтгэлжилтийг зохион байгуулах зарчим

Практикт ажиллагаанд суурилсан сургалт бэлтгэлийн нэгдсэн бодлого, тогтолцоо, хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнгээр нь тооцох зарчим;

Багшлах бүрэлдэхүүний сурган заах арга зүйг дээшлүүлэх, тасралтгүй сургалтын зарчим;

Бодит цагийн байдал, нөхцөлд ойртсон /зарим тохиолдолд бодитой/ сургалтын орчин, /төв, бааз, полигон гэх мэт /хэрэглэгдэхүүн /хамгаалах хувцас, хэрэгсэл, зэвсэг, техник, сум, галт хэрэгсэл, орлуулан ашиглах хэрэгсэл гэх мэт/- тэй сургалтыг тогтмол, өндөр ачаалал дор зохион байгуулах зарчим;

Сургалт бэлтгэлжилтийг идэвхүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /уралдаан тэмцээн, үзүүлэх тоглолт, тайлан тоглолт, красный брет/ байнгын өндөр ачаалалд явуулах нэгдсэн тогтолцооны зарчим;

ТАВ: ҮНДЭСНИЙ ГВАРДИЙН БҮТЦЭЭР ТЕРРОРИЗМТАЙ ТЭМЦЭЖ БАЙГАА ГАДААДЫН ЗАРИМ УЛС.

-  **США** — АНУ-ын үндэсний гварди
-  **Иран** — Исламын хувьсгалыг хамгаалах корпус
-  **Италия** — Италийн Карабинар
-  **Франция** — Үндэсний жандарм
-  **Китай** — БНХАУ-ын ардын зэвсэгт цагдаа
-  **Украина** — Украин улсын үндэсний гварди



Бид терроризм гэгчтэй шууд нүүр тулсан ил мэдрэгдэх аюулаас гадна мэдрэгдэхгүй, цагийн урт хугацааны явцад улс орны язгуур эрх ашигт нөхөж баршгүй хохирол учруулах (зөөлөн хүчний бодлогоор дамжин ирэх) тийм аюул, өөрөөр хэлбэл уламжлалт бус аюул тулгарч болохоор байна.

1. Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна гэсэн Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчмыг баримтлан, улс орны дотоод аюулгүй байдлыг хангах, терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагааны сургалт, бэлтгэлжилтийг эрдэм шинжилгээ судалгаанд тулгуурлан тасралтгүй явуулах зорилгоор ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн дэргэд “Дотоод цэргийн судлал”- судалгааны төвийг байгуулах үндэслэл, хэрэгцээ, өнөөгийн шаардлагыг тусгасан саналыг холбогдох байгууллагад танилцуулах;
2. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн төслийн танилцуулгад манай улсад хийгдсэн эрсдлийн үнэлгээгээр дээрх эрсдлийг нэмэгдүүлж байгаа хэд хэдэн хүчин зүйлс байгаа талаар дурдсан болно. Тухайлбал ... “Тагнуул, хууль сахиулах байгууллагын хүний нөөц, туршлага, зэвсэг хэрэгсэл хангалтгүй” гэснийг харгалзан терроризмтой тэмцэх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, алба хаагчдийн сургалт бэлтгэлжилтийн тогтолцоо, давтамж, чанар үр дүнг шинэ шатанд гаргах зорилгоор сургалтын орчин (бааз, полигон, төв

гэх мэт), хэрэгсэл (тусгай хувцас, зэвсэг, техник, сум галт хэрэгсэл гэх мэт)-д шаарддагдах төсөв, хөрөнгийн асуудлыг тавьж, шийдвэрлүүлэх;

3. Улсын дотоод аюулгүй байдлыг хангах, терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагаа явуулах, нийтийн аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах үүрэг хүлээсэн төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий зарим байгууллагуудын алба хаагчдын ажлын ачааллал, үүрэг гүйцэтгэх чадавхи, албаны бэлэн байдалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай гэж үзвэл ердийн болон онцгой нөхцөлд хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэх, байнгын бэлэн байдалд ажиллах сургалт бэлтгэлжилт, чадавхитай үндэсний хэмжээний нэгжийг байгуулах асуудлыг судлаж, хэрэгжүүлэх эсэхийг тодорхойлох;

СЭТГЭЛ СУДЛАЛЫН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ
СЭТГЭЛ ЗАСЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн багш, цагдаагийн
дэслэгч Д.Цэрэнлхам

Товч агуулга: Энэхүү сэдвээрээ хүүхдийн хүчирхийллийн талаар товч ойлголт өгөх, тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх сэтгэл заслын үйлчилгээнд анхаарах зарим асуудлын талаар хөндөж бичлээ.

Түлхүүр үг: Гэр бүлийн хүчирхийлэл, хохирогч, хүүхэд, сэтгэл зүй, нөлөөлөл

Үндсэн хэсэг: Бидний ирээдүй, үр хойч болсон хүүхдүүд эерэг, аз жаргалтай орчинд өсөн торних эрхтэй ч хүүхдийн хүчирхийлэл манай улсад улам бүр газар авч, аймшигт хэргүүд нийгмийг цочроосоор байна.

Жил бүр дэлхийд дөрвөн эмэгтэй хүүхэд тутмын нэг, найман эрэгтэй хүүхэд тутмын нэг нь бэлгийн хүчирхийлэлд ямар нэгэн байдлаар өртдөг бол 20 хүүхэд тутмын нэг нь бие махбодын хүчирхийлэлд өртдөг¹⁰⁵ гэх судалгаа гарчээ.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдгийг Хүүхдийн эрхийн тухай конвенцид: “Гэмтэл бэртэл учруулах, зүй бусаар харьцах, анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөлжих зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэр” гэж заасан байдаг бол “Хүүхэд хамгааллын тухай хууль”-д “Санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт” гэж заасан байдаг.

Хүүхдийн хүчирхийллийн хэлбэр:

Бие махбодын: Хүүхдийг эрхшээлдээ байлгах, давамгайл байдал тогтоох шийтгэх зорилгоор хүч ашиглан эрүүл мэнд, амь нас, өсөлт хөгжил нэр хүндэд нь аюул учруулах санаатай үйлдэл.

Сэтгэл санааны: Хүүхдэд бүдүүлэг хандах, анхаарал тавихгүй байх, хүүхдийг шүүмжлэх, нэр хоч өгөх, хүүхдийн эд зүйлийг эвдэлж хэмхлэх, чадлаас нь хэтэрсэн зүйлс шаардах.

Бэлгийн: Хүүхдийн бэлгийн халдашгүй байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, садар самуун үйлдэлд уруу татсан байдал.


¹⁰⁵ Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн статистик мэдээлэл., 2018 он

Үл хайхрах: Эцэг эх, асран хамгаалагч нь үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал алдагдах.

Монгол улсад 2 хүүхэд тутмын нэг нь хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртдөг гэж тогтоосон бөгөөд үүнээс бие махбодын хүчирхийлэлд-20.6%, сэтгэл санааны хүчирхийлэлд-56.8%, бэлгийн хүчирхийлэлд-2.09%, үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэлд 21% нь өртсөн¹⁰⁶ гэсэн судалгаа бий. Мөн 2015-2016 онд улсын хэмжээнд 298 хүүхэд, 2016-2017 оны байдлаар “Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах”, “Хүчиндэх” нийт 208 гэмт хэрэгт бага насны 213 хүүхэд өртөж хохирсон гэсэн тоо мэдээ байгаа бол Монгол Улсын ерөнхий прокурорын газрын 2017 оны мэдээгээр манай улсын хэмжээнд нийт 32259 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүүхэд, гэр бүл, ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 49.2 хувиар өссөн байна.

Хүчирхийллийн улмаас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн тоог графикаар харуулбал:

График 1



Бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн тоо 2015 онд 16 байсан бол 2019 оны эхний хагас жилийн байдлаар 22 тохиолдол болж жил ирэх тутам нэмэгдэж байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд шүүх сэтгэц, эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэсэн байдал.

График 2.,



¹⁰⁶ Хүний эрхийн Үндэсний комисс., “Хүүхдийн эрх ба хамгаалал” судалгаа, 2017 он.

2015-2017 онд хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогч буюу 0-18 насны 113 хүүхдэд ШСЭСМШ дүгнэлт гаргасан. Үүнээс 38 нь сэтгэцийн эмгэгтэй гэсэн дүгнэлт гарсан.

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд ихэнх тохиолдолд биеийн гэхээсээ илүү сэтгэл санаагаар хохирч үлддэг байна. Тэд гүн хямралд орж, хэрцгий зан авиртай болдог ба цаашлаад амиа хорлох ч тохиолдол гардаг. Харьцангуй том болсон хүүхдүүд архи, тамхи зэрэг мансууруулах бодист донтдог бол бага насны хүүхдүүд сэтгэл санааны хувьд ноцтой шархалдаг ажээ.

Хүчирхийллийн үр дагавар-насан туршид:

Хүснэгт 1.,

Нярай үе	Хүүхэд нас	Өсвөр нас	Насанд хүрэгчид
Гэмтэл	Сэтгэлзүйн гэмтлийн дараах эмгэг ба сэтгэл түгшилт	Төрөх үйлийн эмгэг	Бие хүний төрх, үйлийн эмгэг
Сэтгэл хөдлөлөө барьж чадахгүй	Сэтгэл хөдлөлийн эмгэг	Архины асуудал	Гэр бүлийн харилцааны асуудал
Хамааралтай харилцаа	Төрөх үйлийн өөрчлөлт	Мансууруулах бодисын асуудал	Ажил эрхлэлтийн асуудал
Өсөлт хоцрох	Сурлага хоцрох	Бусад эрсдэлт төрөх үйл	Архаг биеийн өвчин /зүрхний эмгэг, хавдар/
Сэтгэцийн хөгжлийн саатал	Үе тэнгийнхэний харилцааны асуудал	Давтан хүчирхийллийн хохирогч болох	

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд илрэх шинжүүдийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2.,

Бие махбодын	Цус алдах, хэвлийн доогуурх архаг өвдөлт, БЗХӨ, ДОХ, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт.
Сэтгэл санааны	Сэтгэл гутрах, Сэтгэл түгших, Айх, ичих, Өөрийгөө бусдаас доогуур үнэлэх, Сэтгэлзүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг.
Төрх үйлийн	Зожигрох, Эсэргүүцэн сөргөлдөх төрх үйлтэй болох, нийгмийн эсрэг янз бүрийн төрх үйл гаргах, архи, мансууруулах бодис хэрэглэх, гэрээсээ дайжих, этгээд бэлгийн төрх үйл гаргах.

Хүчирхийллийн улмаас биеийн талаас илэрсэн шинж тэмдгийг судалж үзэхэд зүрх дэлсэх, амьсгал давчдах гэх мэт вегетатив мэдрэлийн тогтолцооны хямралын шинж (36.2%) болон толгой өвдөх (30.4%), өтгөн хатах (20.3%) шинжүүд хамгийн түгээмэл байна.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд өсвөр насныханд сэтгэцийн талаас илэрсэн шинж тэмдгийг судлахад нойр хямрах (75.4%), айдас (71%), хар дарж зүүдлэх (53.6%), сэтгэл санаа тогтворгүй болох (50.7%) шинжүүд хамгийн их илэрсэн¹⁰⁷.

Бэлгийн хүчирхийлэлд 1 удаа өртсөн хүүхдэд үзэн ядах шинж илрэх нь 12 дахин их байх бөгөөд хүчирхийлэлд олон удаа өртөх нь:

Цочромтгой болох, түгшүүрлэх шинжийг 4 дахин;

Хоолны дуршил өөрчлөгдөх шинжийг 8 дахин;

Амиа хорлох оролдого хийхийг 29 дахин нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ: Монгол Улсад хүүхэд хамгааллын болон Хүүхдийн эрхийн тухай хуулиуд батлагдсанаар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо бий болж, тэдний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, оролцогч талуудын харилцааг тодорхойлон, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулсан.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар “хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”, “хамтарсан баг” хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг үзүүлэх талаар тодорхойлсон байдаг.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дараах 3 төрлийн үйлчилгээг үзүүлж байна.

Эмийн эмчилгээ: Сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн эсрэг эмийн эмчилгээ.

Сэтгэл заслын эмчилгээ: Ганцаарчилсан, бүлгийн сэтгэл засал.

Сэргээн засах эмчилгээ: Арттерапи буюу хөгжмийн эмчилгээ.

Сэтгэл заслын болон сэргээн засах эмчилгээ: Сэтгэл засал нь сэтгэл зүйн онол ба аргууд дээр үндэслэгддэг агаад үйлчлүүлэгчид сэтгэлийн түгшүүр төрүүлдэг мэдрэмж, сэтгэгдэл, харилцаа, сэтгэлзүйн шинж тэмдгүүдийг арилгах явдлыг зохицуулахаар хувь хүн ба бүлэгт тусламж үзүүлэх системтэй, чиглэл зорилго бүхий үйл ажиллагаа юм.

Сэтгэл заслын тогтсон үндсэн 4 загвар байдаг¹⁰⁸.

- Эмнэлгийн загвар: Сэтгэл засал бол эмчилгээний арга бөгөөд үйлчлүүлэгчийн бие, сэтгэцэд нөлөөлөх үйлдэл
- Социологийн загвар: Сэтгэл засал нь зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицоход туслах зорилготой нарийн төвөгтэй арга
- Сэтгэлзүйн загвар: Бие хүнийг сургах, зан үйлийг өөрчлөх үйл явцын хүрээнд хэрэглэгдэх арга

¹⁰⁷СЭМҮТ П.Энхчимэг “Бэлгийн хүчирхийллийн улмаас СЭМҮТөвд хэвтэн эмчлүүлэгсдийн судалгаа” магистрын ажил

¹⁰⁸ Анагаах ухааны сэтгэл судлал. Ш.Доржжадамба., 1997 он.

- Философийн загвар: Хүмүүсийн хоорондын харилцан үйлдэлд үүсдэг цогц үзэгдэл хэмээн тус тус үзнэ.

Арттерапия буюу хөгжмийн эмчилгээ нь янз бүрийн сэтгэлийн хөдлөл, айдас, сэтгэцийн эмгэгийг засах чадвартай байдаг.

Хөгжмийн эмчилгээний нөлөөлөл нь сэтгэлзүйн хувьд үйл ажиллагааны явцад бие махбодийн үйл ажиллагаанд эмчилгээний нөлөө үзүүлдэг ба дуу хөгжмийн тусламжтайгаар хувь хүний хөгжилд гарсан хазайлтыг засах, сэтгэцийн хөдөлгөөнийг сайжруулах үйлчилгээг үзүүлдэг¹⁰⁹.

Хөгжмийн эмчилгээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр ашигладаг. Хөгжим нь хүүхдийг татдаг, түүнд хүчтэй мэдрэмжийг төрүүлдэг, дотоод харааны дүр төрхийг сэрээдэг. Хөгжимд хүрэхэд хүүхэд ертөнцийг өөр хэлээр, мэдрэхүйн дүрслэлийн хэлээр ойлгож эхэлдэг бөгөөд хүүхдүүдэд аюулгүй байдлын мэдрэмжийг өгдөг.

Дүгнэлт: Сэтгэл зүйн зөвлөгөө ба сэтгэл засал гэсэн нэр томъёонууд нь тайлбарлах явцад холилдох явдал байнга гардаг бөгөөд онолын болон хэрэглээний төвшинд хэд хэдэн ялгаатай зүйлс байдаг.

Сэтгэл зүйн зөвлөгөө нь клиникийн хувьд эрүүл /сэтгэцийн эмгэг, өвчтэй бус/ боловч өдөр тутмын амьдралд тохиолдох сэтгэлзүйн хүндрэл бэрхшээл, асуудал, зан ааш, зан төлөвтэй холбоотой асуудлууд, мөн сэтгэл санаа хэвийн ч цаашид хэрхэн өөрийгөө бие хүний хувьд хөгжүүлэх талын асуудал зэрэгтэй тулгараад байгаа хүмүүст үзүүлж буй мэргэжлийн зөвлөгөө юм. Сэтгэлзүйн зөвлөгөө бол сэтгэцийн хувьд эрүүл боловч стресстэй, мухардалд орсон, амьдралынхаа хямарлын үед яваа, гэр бүл хосын харилцааны асуудалтай байгаа болон амьдралдаа илүү сайхан амьдрах замыг ирж хайж байгаа хүмүүст үзүүлдэг нэг төрлийн ярилцах засал юм.

Харин сэтгэл засал бол сэтгэцийн эмгэг /түгшүүр, сэтгэл гутрал, гэмтлийн дараах стрессээс үүдэлтэй эмгэг гэх мэт/ болон зан үйлийн эмгэг /түрэмгий байдал, цочмог зан, хор хохирол учруулах үйлдэл гэх мэт/ хүмүүст ярилцлага болон бусад аргаар эмчилгээ хийдэг. Энэ нь сэтгэл засалчийн заавар, зөвлөгөө, удирдлагын дагуу сэтгэц-зан үйлийн эмгэгийг өөрчлөхөд чиглэдэг байна. Сэтгэл заслын үед сэтгэл судлалын онол, сэтгэл заслын арга зүйд суурилсан хөтөлбөр гаргаж, өөрийн өвчнийг ухамсарлан ойлгох байдлыг нэмэгдүүлэх, тэнцвэртэй бус байдлыг өөрчлөх, сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдлыг арилгах, дахин сэдэрх байдлыг багасгахад үйлчлүүлэгчид тусалдаг юм.

Иймд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг газрууд эдгээр ойлголтын ялгааг сайтар таньж зөв, тохирсон тусламжийг үзүүлдэг байх нь чухал ач холбогдолтой юм. Үүнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

¹⁰⁹<https://yarmarkt.ru/mn/rabochaya-programma-po-muzykoterapii-dlya-vuza-konsultaciya-muzykalnogo-rukovoditelya-dlya-roditelei-i.html>

Санал:

1. Хүүхдийг тулгамдсан асуудлаа бусадтай хуваалцах, ярилцах, харилцааны ур чадварт суралцахад гэр бүл, сургуулийн орчинд дахь нөлөөллийг бий болгох, сайжруулах;
2. Сургуульд эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн хичээлийг хөтөлбөрийн дагуу чанартай заах, үр дүнг тооцдог байх;
3. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад мэргэжлийн сэтгэл зүйч болон сэтгэцийн эрүүл мэндийн эмчийг заавал ажиллуулах;
4. Арттерапи буюу хөгжмийн эмчилгээг илүү хөгжүүлж дэлгэрүүлэх;

HEAD OF THE STATE AUTO INSPECTION THE MAIN SUBJECT OF MAKING ROAD SAFETY

Ragchaasuren Bayarmagnai

Yagaantsetseg Battulga

Student of the 2nd faculty

(Academy of Management of the Ministry
of Internal Affairs of Russia)

police colonel

e-mail: ybattulga0330@gmail.com

Annotation: In solving the diverse and laborious tasks of ensuring road safety, the main role is assigned to the State Road Safety Inspectorate of the Ministry of Internal Affairs of Russia and the Mongolian Traffic Police, including the authorities. In addition, control by Internal Affairs acts as a mandatory and effective means of preventing road traffic offenses and crimes, because it has a direct or indirect relation with road safety.

Key words: ensuring road safety, task and function of the head of the State Traffic Inspectorate, ensuring road safety

With the democratization of social relations, the content and the nature of state administration changes – it is becoming more organizational, which means that, along with direct influential actions associated with the process of developing and making decisions (we mean the management function), we use motivation, prediction, and control.

Therefore, it is reasonable to talk about the management of traffic safety, or the coordination functions, which include organizational principles. Moreover, it is necessary for the regulation to enshrine full powers of the corresponding authorities.

The process of road safety management by the state administration can be divided into following parts:

- preparation for management decision making;
- management decision making;
- implementation of management decisions;
- monitoring the implementation of management decisions;
- adjustments in case of insufficient implementation of the management decision.

Management decision has a number of scientific definitions. Common to all definitions is that the decision must be imperious, binding. That is, it obliges, prohibits, allows, because it is an act of the governing body or authorities. In addition, the decision is binding on the establishment of a socially necessary action or behavior, always aimed at the future, at achieving certain goals [2, p. 152].

A variety of definitions of the concept of "management decision" necessitates the identification of signs of a managerial decision:

- has an executive, strong-willed character;
- adopted by authorized state bodies (their officials);
- is a form of expression of the targeted governing influence of the subject of public administration on its object;
- the management decision is binding or recommending to the management object;
- management decision is an action by which the management problem is solved
- is conscious in nature;
- management decision considers existing feedbacks.

Based on these signs, a management decision can be defined as an act of the subject of management - the head of the State traffic inspectorate. Such a decision has a conscious-volitional nature, considers existing feedbacks and is aimed at the practical implementation of a targeted influence on the object of public administration - road safety.

Since management decisions are made by authorized bodies (officials) in the process of managing road safety on a legal basis, they (decisions) implement the rule of law. Hence, one can distinguish three types of managerial decisions in accordance with a certain form of implementation of the rule of law:

- permissive;
- prohibitive;
- obligatory.

Permissive decisions are decisions taken on the basis of permissive norms, that is, management entities carry out certain actions to which they are permitted by law.

A managerial authorization decision will be legitimate if management entities carry out actions permitted by law.

Prohibitive decisions made on the basis of prohibitive norms, consist in the fact that the subjects of legal relations in the field of road safety management refrain from misconduct that is prohibited by the rules of law. In the event that the prohibiting decision is not implemented, the implementation of the sanction of the relevant legal norm enters into force.

Mandatory decisions are made in accordance with state and departmental regulatory legal acts. Their meaning lies in the fact that the subject of traffic safety management performs targeted actions to fulfill the legal duties assigned to him.

This position on the allocation of certain types of managerial decisions is due to the existence of legal and non-legal forms of government. If we look at legal forms, we mean the legal consequences of using these forms - the creation or amendment of the legal regime, the generation, modification or termination of specific legal relations. That is, the legal consequences that occur when issuing management acts, entering into transactions, and the implementation of rule-making activities by state bodies.

For example, The State Traffic Inspectorate, in accordance with the tasks assigned to it, participates in the development of draft laws, other normative acts, documents,

including rules, norms, standards, state and regional programs for ensuring road safety and its participants. Decree of the President of the Russian Federation of June 15, 1998 N 711 "On Additional Measures to Ensure Road Safety [1]" clarifies the competence of the Chief of the State Traffic Inspectorate as follows:

- a) take part in the development and implementation of the main directions of state policy in the field of ensuring road safety, as well as in coordinating the activities of federal executive bodies and executive bodies of the constituent entities of the Russian Federation;
- b) represent the Ministry of Internal Affairs of the Russian Federation in relations with the Government of the Russian Federation, federal executive bodies, state authorities of the constituent entities of the Russian Federation;
- c) conduct correspondence on behalf of the Ministry of the Interior of the Russian Federation;
- d) request and receive in the prescribed manner from federal bodies of state power, bodies of state power of the constituent entities of the Russian Federation, local authorities of municipalities, organizations and officials information on their compliance with the legislation of the Russian Federation in the field of road safety;
- e) e) make orders (decrees, representations, decisions) , in accordance with the legislation of the Russian Federation, to federal bodies of state power, bodies of state power of constituent entities of the Russian Federation, bodies of local self-government of municipalities and organizations, to eliminate violations of the laws of the Russian Federation in the field of road safety;
- f) create expert bodies (councils, commissions, groups) on issues related to the prevention of road traffic accidents and the reduction of the severity of their consequences, in agreement with interested state bodies and organizations;
- g) represent the interests of the Russian Federation in international organizations and in foreign relations, in accordance with the legislation of the Russian Federation;
- h) manage the activities of the main state road safety inspectors in the constituent entities of the Russian Federation.

Thus, the activity of the heads of the traffic police bodies is associated with the adoption of a whole range of managerial decisions, since the road safety management process is characterized by the following features:

- is an expression of the functioning of the management system;
- has a certain structure in the form of stages;
- the change in stages is cyclical in nature, which manifests itself in the fact that after receiving reporting information on the implementation of the management decision, the stages of the management process are repeated;

- The main stages and stages of the road safety management process are enshrined in law;
- the management process is carried out by authorized state bodies (officials), the powers of which are fixed by the legal norm.

As we have already analyzed the functional aspect of the activity of the heads of the State Traffic Inspectorates that are revealed in these areas through the corresponding managerial tasks, which form a certain structure for the performance of work, reflects rather a behavioral one.

Professor Elagin A.G., identified three directions of the leader’s actions (strategic, organizational, support) and identified certain tasks in each direction [3, p. 20]



Pic. 1. Safety Leaders' Activities

The effective and purposeful activity of the chiefs, who ensure safety, is processed firstly through the organization of joint actions of the personnel of special structures. Certain determinant factors, such as thought, motivation, knowledge, and action, influence this activity. Those factors are the most important predictors of successful achievement of the set goals.

List of references

1. Decree of the President of the Russian Federation of June 15, 1998 N 711 (as amended on September 15, 2018) "On Additional Measures to Ensure Road Safety" (Regulation on the State Road Safety Inspection of the Ministry of Internal Affairs of Russia) [Electronic resource]: [http: // www .consultant.ru / document / cons_doc_LAW](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW) (accessed: 12/19/2019).
2. Bezhentsev A. A. Road safety: Textbook / - Moscow: University textbook, SIC INFRA-M, 2019.
3. Elagin A. G. Security (theory, support, management): scientific publication / Academy of Management of the Ministry of Internal Affairs of Russia. - M., 2013.